Зураг 17. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох чадвар эцэг, эхийн хариултаар.....	62
Зураг 18. Өгсөн зааврын дагуу бие даан тухайн үйлдлийг хийдэг эсэх талаарх эцэг, эхийн хариулт, нийт хүүхдээр.....	62
Зураг 19. Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг талаарх эцэг, эхийн хариулт, нийт хүүхдээр.....	63
Зураг 20. Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал, нийт хүүхдээр.....	63
Зураг 21. Халбага, сэрээ, харандааг өөрөө барьдаг байдал, нийт хүүхдээр.....	63
Зураг 22. Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох чадвар.....	64
Зураг 23. Саадыг давж гүйх, харайх зэрэг үйлдлийг хэр хийдэг талаарх эцэг, эхийн хариулт.....	64
Зураг 24. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас, хүйс - хувиар.....	66
Зураг 25. Нийт хүүхдүүдийн амьдарч буй өрхийн ам бүлийн тоо, хувиар.....	66
Зураг 26. Хичээлийн бус цагаар зохион байгуулдаг ажилд оролцох байдал, хувиар.....	68
Зураг 27. Өрхийн сарын орлого, хувиар.....	69
Зураг 28. Охид, хөвгүүдийн биеийн жингийн үзүүлэлт, кг (3-5 нас).....	73
Зураг 29. Охид, хөвгүүдийн бүсэлхийн тойрог, см (3-5 нас).....	73
Зураг 30. Охид, хөвгүүдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт, см (3-5 нас).....	74
Зураг 31. Охид хөвгүүдийн толгойн тойргийн дундаж үзүүлэлт, насаар (3-5 нас).....	75
Зураг 32. Охид, хөвгүүдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас).....	77
Зураг 33. Охид, хөвгүүдийн биеийн жингийн дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас).....	78
Зураг 34. Охид, хөвгүүдийн цээжний тойргийн дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас).....	80
Зураг 35. Охид, хөвгүүдийн бүсэлхийн тойргийн дундаж үзүүлэлт, см (6-17 нас).....	81
Зураг 36. Охид, хөвгүүдийн толгойн тойргийн дундаж үзүүлэлт, см (6-17 нас).....	82
Зураг 37. Охид, хөвгүүдийн баруун гарын атгах хүчний дундаж үзүүлэлт, кг (6-17 нас).....	83
Зураг 38. Охид, хөвгүүдийн зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт, кг (6-17 нас).....	84
Зураг 39. Охид, хөвгүүдийн баруун, зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт (6-17 нас).....	84
Зураг 40. Охид, хөвгүүдийн тэнцвэрийн чанарын дундаж үзүүлэлт, сек (3-5 нас).....	85
Зураг 41. Охид, хөвгүүдийн хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек (3-5 нас).....	86
Зураг 42. Охид, хөвгүүдийн уян хатан чанарын дундаж үзүүлэлт, см (3-5 нас).....	86
Зураг 43. Охид, хөвгүүдийн тэсвэрийн чанарын дундаж үзүүлэлт, сек (4-5 нас).....	87
Зураг 44. Охид, хөвгүүдийн хөлийн хүчний дундаж үзүүлэлт хүйсээр, см (3-5 нас).....	87

Зураг 45. Охид, хөвгүүдийн хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек (6-10 нас).....	88
Зураг 46. Охид, хөвгүүдийн хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек (11-17 нас).....	88
Зураг 47. Охид, хөвгүүдийн хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек (6-17 нас).....	88
Зураг 48. Охид, хөвгүүдийн хүчний чанарын дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас).....	89
Зураг 49. Охид, хөвгүүдийн уян хатан чанарын дундаж үзүүлэлт, см (6-17 нас).....	91
Зураг 50. Охид, хөвгүүдийн авхаалж самбааны чанарын дундаж үзүүлэлт, сек (6-17 нас)	93
Зураг 51. Охид, хөвгүүдийн тэсвэрийн чанарын дундаж үзүүлэлт, мин (6-17 нас).....	94
Зураг 52. Охид, хөвгүүдийн хөлийн хүчний дундаж үзүүлэлт, м (6-17 нас).....	95
Зураг 53. Хүчний чанарын судалгаа 1 ба 2 ийн харьцуулсан байдал, хөвгүүд (6-17 нас)...	97
Зураг 54. Хүчний чанарын судалгаа 1 ба 2-ын харьцуулсан байдал, охид (6-17 нас).....	98
Зураг 55. Ажигч чадварын гүйцэтгэл, насаар (3-5 нас)	102
Зураг 56. Хүртэхүйн ажигч чанарын даалгаврын гүйцэтгэл (3-5 нас).....	102
Зураг 57. Ажигч чанарын түвшин, насаар (3-5 нас).....	103
Зураг 58. Хүүхдүүдийн ажиглаж тогтоосон байдал (3-5 нас)	103
Зураг 59. Анхаарлын тогтворжилтын түвшин, насаар (3-5 нас)	104
Зураг 60. Анхаарлын шилжилт, насаар (3-5 нас)	105
Зураг 61. Сэргээн санасан үг, хувиар (3-5 нас).....	106
Зураг 62. Тогтоосон үгийн ангилал (3-5 нас)	106
Зураг 63. Хүүхдүүдийн тогтоосон үгийн гүйцэтгэл, нийт үгээр (3-5 нас)	107
Зураг 64. Богино хугацааны харааны ой тогтоолтын түвшин, хувиар (3-5 нас).....	108
Зураг 65. Сонорын ой тогтоолт ба харааны ой тогтоолтын харьцуулсан үзүүлэлт (3-5 нас)	109
Зураг 66. Логиктой сэтгэх чадварын гүйцэтгэлийн түвшин, насаар (3-5 нас)	110
Зураг 67. Бодит үйлдлийн сэтгэхүйн гүйцэтгэлийн түвшин (3-5 нас)	111
Зураг 68. Бодит үйлдлийн сэтгэхүйн чадварын сорил 2-ын гүйцэтгэл (3-5 нас).....	111
Зураг 69. Сэтгэхүйн харьцуулах чадварын түвшин, насаар (3-5 нас)	112
Зураг 70. Сэтгэхүйн харьцуулах чадварын түвшин, насаар (3-5 нас)	113
Зураг 71. Санаагаа өгүүлбэрээр илэрхийлсэн байдал, хувиар (3-5 нас)	114
Зураг 72. Ажигч чанарын даалгаврын гүйцэтгэл, хувиар (6-7 нас).....	117
Зураг 73. Ажигч чанарын түвшин, хувиар (6-7 нас).....	118
Зураг 74. Богино хугацааны харааны ой тогтоолтын түвшин, хувиар (6-7 нас).....	118
Зураг 75. Богино хугацааны харааны ой тогтоолтын түвшин, хувиар (6-7 нас).....	119
Зураг 76. Богино хугацааны харааны ой тогтоолт, даалгаврын гүйцэтгэл, хувиар (6-7нас)	119
Зураг 77. Богино хугацааны сонорын ой тогтоолт, хувиар (6-7 нас)	120
Зураг 78. Утгын ой тогтоолтын түвшин, судалгааны 1 ба 2-р шатаар, хувиар (6-7 нас) ...	120
Зураг 79. Утгын ой тогтоолт, сэргээн санаж байгаа утга, хувиар (6-7нас)	121
Зураг 80. Хүртэх чадвар, насаар, хувиар (8-10 нас).....	125
Зураг 81. Судалгааны 1-р шатны гүйцэтгэлийн түвшин, хувиар (8-10 нас).....	125
Зураг 82. Анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	126
Зураг 83. Богино хугацааны харааны ой тогтоолт, цифр тогтоох, даалгаврын гүйцэтгэл, хувиар (8-10 нас).....	128
Зураг 84. Богино хугацааны харааны ой, дүрс тогтоох, даалгаврын гүйцэтгэлээр (8-10 нас)	129
Зураг 85. Богино хугацааны харааны ой, дүрс зураг тогтоох, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	130
Зураг 86. . Утгын ой тогтоолт, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	131
Зураг 87. Хийсвэр сэтгэхүй, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (6-7 нас).....	137
Зураг 88. Хийсвэр сэтгэхүй, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	138

Зураг 89. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар, хувиар (8-10 нас).....	138
Зураг 90. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	140
Зураг 91. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (8-10 нас).....	141
Зураг 92. Үг тайлбарлах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (6-10 нас).....	142
Зураг 93. Үгийг алдаатай ангилах онцлог, хувиар (6-10 нас).....	144
Зураг 94. Ярих чадвар 1 ба 2-р шатны судалгааны харьцуулалт (6-10 нас).....	145
Зураг 95. Ажигч чанар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-17 нас).....	151
Зураг 96. Ажигч чанар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-17нас).....	152
Зураг 97. Бүхэл бүтнээр хүртэх, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	153
Зураг 98. Юмсыг нарийн бүтэц, бүрэлдэхүүнийг хүртэх (11-14 нас).....	154
Зураг 99. Анхааралтай хурдтай ажиллах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	156
Зураг 100. Анхааралтай ажиллах хурд, даалгаврын гүйцэтгэлээр (15-17 нас).....	156
Зураг 101. Богино хугацаанд харааны ой тогтоолт-цифр, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	158
Зураг 102. Богино хугацааны харааны ой-цифр тогтоох, даалгаврын гүйцэтгээр, хувиар (15-17нас).....	158
Зураг 103. Сонорын ой тогтоолт, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	160
Зураг 104. Сонорын ой тогтоолт, даалгавраар, хувиар (15-17 нас).....	161
Зураг 106. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	164
Зураг 107. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (15-17 нас).....	165
Зураг 108. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас).....	168
Зураг 109. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, насаар (11-14 нас).....	168
Зураг 110. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (15-17 нас).....	169
Зураг 111. Үгийн утгыг гадаад шинж, илэрхийлж буй юмсын үйлдэл нөлөөллөөр нь тайлбарлах, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас).....	170
Зураг 112. Үгийн утгыг гол шинжээр нь тайлбарлах, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас).....	170
Зураг 113. Үгийг утгаар нь ангилахад гаргаж байгаа алдаа, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас).....	172
Зураг 114. Ярих чадвар, насаар, дундаж үзүүлэлт (11-17нас).....	175
Зураг 115. Гунигтай, ууртай байгаа хүүхдийг таних хувиар (3-5 нас).....	183
Зураг 116. Баярлаж байгаа хүүхдийг олж таних (3-5 нас).....	184
Зураг 117. Өөртөө хандах хандлагын чадваруудын дундаж үзүүлэлт, судалгааны үе шатаар (6-10 нас).....	187
Зураг 118. Өөртөө итгэх итгэлийн дундаж үзүүлэлт, насаар (6-10 нас).....	189
Зураг 119. Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-10 нас).....	193
Зураг 120. Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын дундаж үзүүлэлт (6-10 нас).....	193
Зураг 121. Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг мэдэх чадвар (6-10 нас).....	194
Зураг 122. Дасан зохицолтын дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-10 нас).....	195
Зураг 123. Өөрийгөө хүлээн зөвшөөрөх чадварын дундаж үзүүлэлт, насаар (6-10 нас).....	195
Зураг 124. Дотоод хяналтын чадварын дундаж үзүүлэлт, насаар (6-10 нас).....	195
Зураг 125. Гадаад хяналтын чадварын дундаж үзүүлэлт, насаар (6-10 нас).....	195
Зураг 126. Дасан зохицолтын чадваруудын дундаж үзүүлэлт (6-10 нас).....	196
Зураг 127. Ээнэгшилтийн чадваруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-10 нас).....	197
Зураг 128. Үнэт зүйлийн зарим үзүүлэлтийн дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-10 нас).....	201

Зураг 129. Нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх чадваруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-10 нас)	204
Зураг 130. Бие хүний онцлогийн зарим чадваруудын ялгаа, судалгаагаар (Улаанбаатар, 11-14 нас)	206
Зураг 131. Сэтгэлийн хөдөлгөөний зарим чадваруудын ялгаа, судалгаагаар (11-14 нас)	208
Зураг 132. Дасан зохиолтын чадваруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (11-14 нас)...	210
Зураг 133. Эцэг эх, хүүхэд хоорондын харилцааны дундаж үзүүлэлт, судалгаагаар (11-14 нас)	211
Зураг 134. Эцэг эх, хүүхэд хоорондын итгэлцлийн дундаж үзүүлэлт, хүйсээр (11-14 нас)	212
Зураг 135. Харилцааны үед бусдын сэтгэл санааг ойлгох чадварын дундаж, судалгаагаар (11-14 нас)	213
Зураг 136. Үнэт зүйлийн зарим даалгавруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (11-14 нас)	215
Зураг 137. Үнэт зүйлийн үзүүлэлтүүдийн дундаж, хүйсээр (11-14 нас).....	216
Зураг 138. Нийгмийн хэм хэмжээг баримтлах чадваруудын ялгаа, судалгаагаар (Улаанбаатар, 11-14 нас)	217
Зураг 139. Бие хүний онцлогийн зарим чадваруудын ялгаа, судалгаагаар (15-17 нас) ..	219
Зураг 140. Бие хүний онцлогийн зарим чадваруудын дундаж үзүүлэлтийн ялгаа, хүйсээр (15-17 нас)	220
Зураг 141. Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын дундаж үзүүлэлт, судалгаагаар (15-17 нас)	221
Зураг 142. Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын дундаж үзүүлэлт (15-17 нас)	222
Зураг 143. Бусдыг хүлээн зөвшөөрөх чадвар, судалгаагаар (15-17 нас).....	223
Зураг 144. Дасан зохицолтын чадваруудын дундаж үзүүлэлт (15-17 нас).....	224
Зураг 145. Дасан зохицох чадваруудын үзүүлэлт - түвшин ба хувиар (15-17 нас).....	224
Зураг 146. Ээнэгшилтийн дундаж үзүүлэлт, судалгаагаар (15-17 нас)	225
34. Зураг 147. Ээнэгшилтийн чадваруудын дундаж үзүүлэлт (15-17 нас)	225
Зураг 148. Харилцааны үед бусдын сэтгэл санааг ойлгох чадварын ялгаа, судалгаагаар (15-17 нас)	226
Зураг 149. Харилцааны чадваруудын дундаж үзүүлэлт (15-17 нас)	227
Зураг 150. Үнэт зүйлийн зарим чадварын ялгаа, судалгаагаар (15-17 нас)	228
Зураг 151. Нийгмийн хэм хэмжээг баримтлах чадваруудын ялгаа, судалгаагаар (15-17 нас)	231
Зураг 152. Өөртөө итгэх итгэл болон өөрийн үнэлэмжийн дундаж үзүүлэлт, судалгаагаар (6-17 нас).....	232
Зураг 153. Өөртөө итгэх итгэлийн дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас)	232
Зураг 154. Өөрийн үнэлэмжийн дундаж үзүүлэлт, насаар (6-17 нас)	232
Зураг 155. Бие хүний онцлогийн үзүүлэлтүүдийн дундаж, судалгаагаар (6-17 нас)	233
Зураг 156. Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын дундаж, судалгаагаар (6-17 нас)	234
Зураг 157. Дасан зохицолтын дундаж, судалгаагаар (6-17 нас)	235
Зураг 158. Ээнэгшилтийн чадваруудын дундаж, судалгаагаар (6-17 нас)	236
Зураг 159. Харилцааны чадваруудын дундаж, судалгаагаар (6-17 нас)	237
Зураг 160. Үнэт зүйлийн чиг баримжааны зарим үзүүлэлтийн дундаж, судалгаагаар (6-17 нас)	238
Зураг 161. Нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх чадваруудын дундаж, судалгаагаар (6-17 нас)	239

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА СУДЛАЛЫН ҮНДЭС

1.1 ҮНДЭСЛЭЛ

Боловсролын аливаа үйл ажиллагаа нь хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлогтой уялдсан, тэдний хэрэгцээг тооцсон байх нь улс орны хөгжилд нэн чухал болох талаар боловсрол судлаачид, хөгжлийн судлаачид санал нэгдэж байна.

Хүүхэд, залуучуудын суралцахууд бий болж буй шинэ чиг хандлага нь багшлах арга зүйг суралцагчдын онцлогтой уялдуулах, тэдний зөөлөн ур чадварыг хөгжүүлэх, улмаар хүүхдийн цогц хөгжлийн орчинг бүрдүүлэхэд анхаарч байгаа юм.

Хүний цогц хөгжлийг XIX зууны II хагасаас бие бялдар, нийгэмшил, оюун ухаан, танин мэдэхүйн бүрэлдэхүүний цогцод нь авч үзэж ирсэн ба дэлхийн улс орнууд хүүхэд, залуучуудын хөгжлийн судалгааг гүйцэтгэж, хөгжлийн шалгуур үзүүлэлт боловсруулан ашиглаж байна.

Монгол улсын хувьд, хүүхэд залуучуудын өсөлт хөгжлийн онцлогт тулгуурлан бодлого, сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулж хөгжлийн үйл явцад шинжлэх ухаанч байр сууринаас хандах хэрэгцээ шаардлага боловсролын бодлого тодорхойлогчид, эрдэмтэн судлаач, багш нарын тулгамдсан асуудал болж байна. Энэхүү хэрэгцээ шаардлагатай холбоотойгоор Монгол хүүхдийн хөгжлийн онцлог, нөлөөлж байгаа хүчин зүйл зэргийг илрүүлэн, шалгуур үзүүлэлтийг боловсруулах судалгааг хийж гүйцэтгэсэн. 2014-2017 онд Боловсролын хүрээлэн нь БСШУЯ-ны захиалга, ШУТС-ийн санхүүжилтээр “Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг тодорхойлох технологийг сургалтын практикт нэвтрүүлэх нь” үндэсний түвшний цөм технологийн төслийн судалгааг гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнд 3-21 хүртэлх насны хүүхэд, залуучуудын цогц хөгжлийн онцлогийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадваруудаар эхний байдлаар тодорхойлсон. Судалгаанд тулгуурлан хүүхэд, залуучуудын цогц хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг боловсролын түвшин бүрээр боловсруулж, уг шалгуурыг ашиглах боломжтой эсэх талаар ЕБС-ийн багш нараас судалгаа авч баталгаажуулан сайжруулав.

Монгол Улсад “18 хүртэлх насны хүнийг хүүхэд” гэж тодорхойлдог бол НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуулинд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлжээ.

Хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлогийг тогтоох судалгаа хийдэг бусад улс, орнуудын туршлагаас харахад энэ чиглэлийн судалгааг тасралтгүй хийж, давтан судалгааны үр дүнд авч үздэг онцлогтой байна. Иймээс бид Монголын хүүхэд,

залуучуудын хөгжлийн онцлогийг тогтоох судалгааг 4 жилийн зайтай 3 удаа хийх зорилго тавьж, 2014 онд уг судалгааны гарааг эхлүүлж, 2 дахь шатны үйл ажиллагааг 2020 онд хийв.

Судалгааны зорилго

3-17 настай хүүхдийн цогц хөгжлийн онцлогийг тодорхойлох.

Зорилтууд

- Сургуулийн өмнөх боловсролын түвшний 3-5 настай хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудыг тодорхойлох;
- Бага боловсролын түвшний 6-10 настай хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудыг тодорхойлох;
- Суурь боловсролын түвшний 11-14 настай хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудыг тодорхойлох;
- Бүрэн дунд боловсролын түвшний 15-17 настай хүүхдүүдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудыг тодорхойлох;
- Насны бүлгээр хүүхдийн чадваруудын хамаарлыг тогтоох;
- Хүүхдийн хөгжилд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох.

Судалгааны объект

3-17 настай хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн цогц бүрдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс.

Судлах зүйл

3-17 настай хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадварууд.

1.2. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН АРГА ЗҮЙ

Судалгааны мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр цуглуулсан ба нийслэлийн 7 дүүрэг, 5 аймгийн (онцгой нөхцөл байдлын улмаас Завхан, Орхон, Дорноговь аймгуудын мэдээллийг цуглуулах хугацаа хойшилсон) 16 сургуулийг хамарсан түүвэр судалгааг зохион байгуулсан.

Түүвэр судалгааг хоёр шатат, энгийн санамсаргүй түүврийн аргаар хийв. Түүврийн дизайн өмнөх судалгаатай ижил зарчмаар тодорхойлогдсон. 1-р шатны судалгааны тайлан гол үзүүлэлтүүдийн хувьд алдааны хязгаар, дизайны нөлөө нь судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд тооцоолж байсан хэмжээнд гарсан тул түүврийн хэмжээ, дизайныг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

1-р үе шат: Сургууль сонгох

Сургуулиудыг сонгохдоо нийслэлийн 7 дүүргээс (Баганхангай дүүрэг түүврийн шаардлагад тохирохгүй, Багануур дүүрэг хэт алслагдсан зүүн бүс рүү орох боломжтой тул зүүн бүсээр тооцож түүвэрт оруулсан болно.) 1 сургууль байхаар, нэг бүсээс цөөндөө 1 аймаг, аймаг дотроо 2 сумын сургууль, аймгийн төвийн 2 сургууль байхаар тооцож системчилсэн түүврийн аргаар сонгосон.

Аймаг	Бүс	Боломжит						Сонгогдсон						
		Сургууль			Цэцэрлэг			Сургууль			Цэцэрлэг			
		Аймгийн төв	Сум	Нийт	Аймгийн төв	Сум	Нийт	Аймгийн төв	Сум	Нийт	Аймгийн төв	Сум	Нийт	
Баян-Өлгий	Баруун бүс	15	29	44	28	22	50							
Говь-Алтай	Баруун бүс	6	22	28	11	19	30							
Завхан	Баруун бүс	6	24	30	11	30	41	2	2	4	2	2	4	
Увс	Баруун бүс	8	22	30	16	18	34							
Ховд	Баруун бүс	8	17	25	25	18	43							
Дорнод	Зүүн бүс	13	14	27	23	13	36	2	2	4	2	2	4	
Сүхбаатар	Зүүн бүс	4	12	16	11	13	24							
Хэнтий	Зүүн бүс	5	21	26	14	22	36							
Говьсүмбэр	Төвийн бүс	3	2	5	8	3	11							
Дархан-Уул	Төвийн бүс	21	5	26	34	7	41							
Дорноговь	Төвийн бүс	5	16	21	16	26	42	2	2	4	2	2	4	
Дундговь	Төвийн бүс	5	14	19	8	14	22							
Өмнөговь	Төвийн бүс	6	16	22	10	19	29							
Сэлэнгэ	Төвийн бүс	7	28	35	8	36	44							
Төв	Төвийн бүс	4	27	31	7	43	50							
Архангай	Хангайн бүс	10	23	33	17	19	36							
Баянхонгор	Хангайн бүс	9	22	31	23	20	43							
Булган	Хангайн бүс	4	18	22	6	16	22							
Орхон	Хангайн бүс	23	1	24	38	1	39			4			4	
Өвөрхангай	Хангайн бүс	7	25	32	17	30	47							
Хөвсгөл	Хангайн бүс	9	26	35	22	28	50	2	2	4	2	2	4	
Багануур	Улаанбаатар			4			10							
Багахангай	Улаанбаатар			1			3							
Баянгол	Улаанбаатар			49			105			1			1	
Баянзүрх	Улаанбаатар			63			189			1			1	
Налайх	Улаанбаатар			8			14			1			1	
Сонгинохайрхан	Улаанбаатар			32			119			1			1	
Сүхбаатар	Улаанбаатар			50			66			2			2	
Хан-Уул	Улаанбаатар			43			126			1			1	
Чингэлтэй	Улаанбаатар			26			52			1			1	
		Нийт								28				28

2-р үе шат: Судалгаанд оролцогч сонгох

Түүврийн анхан шатны нэгж буюу судалгаанд оролцогчийг сонгох энгийн санамсаргүй түүврийн аргаар дараах нөхцлүүдийг тооцож сонгов. Үүнд:

- Өмнөх судалгаанд хамрагдсан судалгаанд оролцогчийг өгөгдлийн сангаас авч сонгож авсан.
- Үлдсэн тооны судалгаанд оролцогчийг RNG (random number generator) app ашиглан тухайн насны судалгаанд хамрагдах боломжтой (эрүүл мэнд болон бусад шалтгаанаас бусад) судалгаанд оролцогчдоос сонгосон.

Түүврийн хэмжээ

Түүврийн хэмжээг судалгаанд хамрагдах боломжтой оролцогчдоос тэнцүү магадлалтайгаар түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$n = \frac{z^2 p(1-p)}{e^2} def f$$

n-судалгаанд хамрагдах оролцогчдын тоо буюу түүврийн хэмжээ

z-хүсч байгаа ач холбогдлын түвшинг тодорхойлох статистик утга

p-судалгаагаар хэмжих түлхүүр үзүүлэлтийн хувийн жин


deff-дизайны нөлөө буюу ямар нэг шалтгаанаар судалгаанд хамрагдахгүй байх

тохиолдол байдгийг тооцон түүврийн хэмжээг тодорхой хувиар ихэсгэх үзүүлэлт

e-Итгэх мужид хүлээн зөвшөөрөгдөх алдааны хязгаар

Ингээд судалгааны нийт түүврийн хэмжээ 5040 байхаар тооцсон ба хооронд нь харьцуулах тохиолдолд түүврийн тэгш хуваарилалт илүү зохимжтой гэж үзсэн болно.

1.3 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Хамтын ажиллагааны чиглэл:

- БШУЯ нь энэхүү судалгааны захиалагч бөгөөд судалгааны үр дүнг өмчилнө.
- Боловсролын хүрээлэн хамтрагч талуудтай судалгааны удирдамж, арга зүй боловсруулах, мэдээлэл цуглуулах шатанд техникийн болон санхүүгийн дэмжлэг авах мөн хүүхдийн оношилгооны аргачлалыг сургалтын практикт хэрэгжүүлэх

- боломжийг авч үзэх, үр дүнгийн шатанд хүүхдийн хөгжлийн онцлогийг тогтоож, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд хамтран мэргэжлийн манлайлан ажиллаж байна.
- Орон нутгийн түвшинд судалгааг зохион байгуулахад аймаг, дүүргийн боловсролын газрын дэмжлэг авч хамтран ажиллав.
 - Судалгааны мэдээлэл цуглуулахад сургууль, цэцэрлэгийн түвшинд зохион байгуулж, танхимын түвшинд хүүхдийн хөгжлийн оношилгоог хийж, үр дүнг багшлах үйл ажиллагаанд ашиглах, аргачлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллав.
 - Судалгааны мэдээлэл цуглуулахад багш, эцэг эхчүүдээс дэмжлэг авах, ялангуяа багш нартай хамтран хүүхдийн цогц хөгжлийн оношилгооны аргачлалыг сайжруулах, хүүхдийг оношлох, үр дүнг ашиглах аргачлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллав.
 - Судалгааны аргачлалыг хөгжүүлэх чиглэлээр сурагчдын дэмжлэгийг авч ажиллав.
 - Судалгааны багуудтай судалгааны үе шат бүрт төлөвлөгдсөн ажлуудыг зорилтын хүрээнд хэрэгжүүлж, үр дүнг гаргахад хамтран ажиллав.

1.4 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

XX зууны дунд үеэс хүний хөгжлийг танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжлийн цогц хэмээн үзэж хөгжлийг судлахдаа цогц арга зүйгээр, хүчин зүйлийн нэгдэлд нь судлах хандлага давамгайлах болжээ.

Танин мэдэхүйн хөгжил нь оюун ухаан гэсэн ойлголтой төстэй хэрэглэгдэх нь түгээмэл. Ялангуяа, тест судлалын хүрээнд танин мэдэхүйн хөгжлийг оюун ухааны хөгжил хэмээн тодорхойлсоор ирсэн.

Судлаачид оюун ухааныг юмс үзэгдлийг хүртэх, мэдлэг эзэмших, мэдээллийг боловсруулах, хэл яриаг эзэмших үйл явц, танин мэдэхүйн үйлүүдийн төлөвшил гэж үздэг бол (гештальт онол, нийгэм-соёлын хандлага, танин мэдэхүйн сурахуйн онол, мэдээллийн хандлага, үйлийн түвшний онол гэх мэт) зарим нь оюун ухааныг зөвхөн мэдээлэл боловсруулах танин мэдэхүйн үйл явц төдий биш өргөн хүрээний ойлголт, ялангуяа, хүрээлэн буй орчиндоо дасан зохицох, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах чадвар гэж үздэг байна (генетик хандлага, зохицуулалтын хандлага). Иймд оюун ухаан нь мэдлэг, танин мэдэхүйн үйлийг агуулсан хэсгээс бүрдэхээс гадна нийгэм-соёлын орчинд дасан зохицох, зан төлөвөө хянан зохицуулах чадварыг өөртөө агуулсан өргөн хүрээний ойлголт ажээ.

XX зууны сүүлээс оюун ухааныг хүний амьдрах чадварыг нөхцөлдүүлэгч сэтгэцийн нийлмэл үзэгдэл болох талаас нь тайлбарлах байдал улам нэмэгдэж, сэтгэн бодох чадвар буюу танин мэдэх үйл нь хөгжлийн нэгэн хэсэг ба оюун ухааныг бүхэлд нь тодорхойлж чадахгүй тул бусад бүрдэл буюу бие хүний онцлог, харилцаа, шийдвэр гаргалт, дасан зохицох байдал, танин мэдэхүйн үйл явц нь нийлээд оюун ухааны илрэл гэж үзэх болсон (Кауфман, 2006; Штернберг, 2011).

Эндээс үзэхэд, хүний сэтгэцийн хөгжлийг бүхэлд нь оюун ухаан гэж нэрийдэх нь нийцтэй ба харин танин мэдэхүйн хөгжлийг оюун ухаан гэсэн ойлголтоор тэмдэглэх нь хязгаарлагдмал байх талтай байна.

Тест судлалын хүрээнд оюун ухааны хөгжлийг танин мэдэхүйн бүтэц талаас нь түлхүү авч үздэг.

Бид энэхүү судалгаагаар хүний хөгжлийн бүрдэл хэсгийг танин мэдэхүй болон нийгэмшил хэмээн авч үзэхдээ дээр дурдсан үзэл баримтлалыг үндэс болгосон. Үүнээс гадна бидний судалгааны үр дүн нь боловсрол, сургалтын бодлого, шийдвэр, хэрэгжилтэд ашиглагдах давхар зорилготойг харгалзан хүүхдийн танин мэдэхүй, хувь хүний төлөвшлийн үйл явцыг судлагдахуун болгов. Харин бие бялдрын бүрдэл нь олон улс, эрдэмтэн судлаачдын хүрээнд судлагдахуун, аргын хувьд харьцангуй тогтвортой, стандарчилагдсан арга зүйтэй тул түүнийг үндэс болгов.

ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙН ДААЛГАВАР

Бид 3-5, 6-10, 11-14, 15-17 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг судлахдаа хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан, хүртэхүй, анхаарлын төвлөрөл, богино хугацааны ой, утгын ой, бодит сэтгэхүй, хийсвэр сэтгэхүй, хэл ярианы чадваруудыг судлагдахуун болголоо.

Танин мэдэхүйн хөгжлийн цөмийг хүртэхүй, анхаарал, ой, тогтоолт, сэтгэхүй, хэл ярианы чадвар хэмээн үзэж тухайн чадваруудыг авч үзлээ.

Танин мэдэхүйн чадварыг судлах даалгаврыг сонгож боловсруулахдаа нэгдүгээрт, хэл ярианы ба хэл ярианы бус даалгавраар судалдаг хандлага; хоёрдугаарт, насны онцлог; гуравдугаарт, боловсролын түвшний агуулгын онцлогийг харгалзан үзэв.

Боловсролын түвшинд хамрагдах насаар нь сургуулийн өмнөх нас (3-5 нас), бага боловсролын нас (6-10 нас), суурь боловсролын нас (11-14 нас), бүрэн дунд боловсролын нас (15-17 нас) гэж тооцон түүврийг сонгож авсан.

Даалгаврын аргачлал боловсруулалтын гол онцлог нь:

1. Бага боловсролын 6-7 насны хүүхдийн танин мэдэхүйн чадвар нь сургуулийн өмнөх насны хүүхдээс ач холбогдолтой ялгаа багатай, тестийн даалгаврын

заавар, гүйцэтгэлийг ойлгох нь хангалтгүй талтай тул зарим аргачлал нь сургуулийн өмнөх насны хүүхэдтэй төстэй буюу 8-10 насны хүүхдийнхээс ялгаатай байхаар боловсруулагдсан.

2. Хүүхдийн танин мэдэхүйн нас зүйн онцлогийг тодорхойлохоос гадна нас нэмэгдэхэд хэрхэн өөрчлөгдөж байгаа харьцуулалтыг хийх, хөгжлийн мэдрэмтгий үеийг илрүүлэх үүднээс насны бүлгүүдэд даалгаврууд нь арга зүйн хувьд төстэй, мөн зарим насны онцлогтой уялдан аргачлалын агуулга нь бага зэрэг ялгаатай байхаар боловсруулсан.
3. Найман наснаас эхлээд хүүхэд юмсын талаар хийсвэр ойлголт төсөөлөлтэй болж, сурах арга барил эзэмшиж, танин мэдэхүйн зориудын үйл төлөвшсөн байдаг тул нэлээд даалгаврууд нь 8-17 нас хүртэл ижил байна.
4. Танин мэдэхүйн чадваруудыг насны бүх бүлэгт хүртэхүй, анхаарал, ой тогтоолт, сэтгэхүй, хэл ярианы чадвараар авч үзсэн.
5. Даалгаврын хүнд, хөнгөний түвшин нь насны онцлог, боловсролын түвшинг харгалзан үзсэнээс гадна танин мэдэхүйн цогц үйл ажиллагаа, харилцан хамаарлыг илрүүлэхэд чиглэсэн.
6. Танин мэдэхүйн хөгжил нь бодитоос хийсвэр рүү, ерөнхийгөөс нэгж рүү, зориудын бусаас зориудын үйл рүү чиглэдэг зүй тогтлыг харгалзан үзэж даалгаврын хүнд хөнгөн болон төрлийг сонгож боловсруулав.

1. Хүртэхүйн чадварыг тодорхойлох даалгавар

а/ Ажигч чанарыг судлах даалгавар

Юмсыг анхааралтай хүртэж, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүнийг таньж мэдэх чадварыг ажигч чанар гэнэ. Бид юмсыг богино хугацаанд анхааралтай ажиглан тэдгээрийн өвөрмөц онцлог, бүтэц бүрэлдэхүүн, ялгаатай байдлыг нь таних чадварыг ажигч чанар хэмээн үзэж судалсан. Үүнийг судалдаг үндсэн 2 арга байдаг ба нэгдүгээрх нь зургийн дутуу хэсгийг олох, 2 юмсын ялгаатай байдлыг олох аргаар судалдаг байна. (Андронникова Е.А, Зайка Е.В, 2001).

3-5, 6-7 насанд энгийн зургийн дутуу зурагдсан дутуу зурагдсан хэсгийг богино хугацаанд олж нэрлэх (шууд хүртэх) даалгавар, 8 ба түүнээс дээш насанд 2 зургийн ялгаатай зурагдсан юмсыг богино хугацаанд олох даалгаврыг сонгов. Энэхүү ялгаатай зүйлсийг зургаас олж нэрлэх даалгавар хүүхдийн анхаарал, ой тогтоолттой холбоотой шууд хүртэх чадварыг шаардана.

3-5 насанд ажигч чанарын даалгаврын бүтэц нь хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн зүй тогтлыг агуулсан. Жишээлбэл, хамгийн эхний зурагт ширээний 1 хөл нь дутуу

байгааг, 2 дахь зураг нь хайчны нэг ирийг нэрлэх бол сүүлийн даалгавар нь хүүхдээс илүү анхаарал ажигч чанарыг шаардсан буюу хаалганы бариул дутуу зурагдсаныг нэрлэх юм. Харин 6-7 насанд аргачлал нь адилхан ч олж гүйцэтгэх даалгаврын тоо нь нэмэгдсэн байгаа. 3-5 насанд 4 даалгавар байгаа бол 6-7 нас нь 7 даалгавартай.

б/ Хүртэхүйн бүхэл бүтэн чанар ба орон зайн хүртэхүйг судлах даалгавар

8-17 насанд хүртэхүйг судлах нэмэлт даалгавар болгож зургийн дутуу зүйлийг олж нэрлэх даалгаврыг оруулсан. 2 зургийн хоорондын ялгаатай зүйлийг олох даалгавартай харьцуулахад зургийн дутуу зүйлийг олж нэрлэх нь анхаарал, харьцуулах чадвар, ой тогтоолтыг бага шаардах ба юмсыг бүхэлд нь хүртсэний дараагаар задалж хүртэх чадварыг шаарддаг онцлогтой. Харин 2 зургийн ялгаатай зүйлсийг олж нэрлэх нь жижиг хэсгүүдийг тус бүрт хүртэх чадварыг шаарддаг тул анхаарал, ой тогтоолт зэрэг танин мэдэхүйн бусад процессын оролцоог илүү шаардана. Харин бүхэлд нь хүртэх чадварыг шаарддаггүй.

Ийнхүү танин мэдэхүйн хувьд бүхэллэг эсвэл аналитик (задлан шинжлэх) хэв шинж давамгайлж байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор *Векслерийн оюун ухааны шкалын* даалгавар болох “зургийн дутуу зүйлийг олж нэрлэх” даалгавраар хүртэхүйн чадварыг судалсан. Даалгаврын онцлог нь хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн зүй тогтолтой, хүндрэх тусам анхаарал, зүй тогтолд нь сэтгэх чадварыг илүү шаарддаг. Иймд сэтгэхүйн хийсвэрлэл, анхаарлын төвлөрлийн онцлогийг давхар илрүүлэх боломжтой юм.

2. Анхаарлыг судлах даалгавар

Анхаарлын чадварыг судлахдаа анхаарлын тогтворжилт, шилжилтийг судлагдахуун болгов. Анхаарлыг судлах үндсэн шалгуурыг сэтгэхүйн хурд, бүтээлч чанар буюу оновчтой гүйцэтгэлийг гэж үзсэн.

Даалгаврын сонголтыг хийхдээ хүүхдийн нас зүйн онцлог, чадварыг харгалзан үзсэн. Ийнхүү 3-5, 6-7 насанд энгийн дүрсүүдэд, өгөгдсөн хялбар тэмдэглэгээг зурж тэмдэглэх даалгаврыг гүйцэтгэнэ (*Пьер - Рузений арга, Векслерийн аргатай төстэй*), 3-5 насанд тэмдэглэх дүрсийн тоо цөөн. 8-10 насанд өгөгдсөн хугацаанд 1 оронтой 2 тоонуудыг хооронд нь нэмэх, хасах үйлдлийг ээлжилж гүйцэтгэх (Крепелиний арга), 11-14 насанд өгөгдсөн олон тооны үсгүүдээс олох ёстой үсгүүдийг олж зохих тэмдэглэгээгээр тэмдэглэх (Бурдоны арга), 15-17 насанд өгөгдсөн хугацаанд 1 оронтой тоонуудыг хооронд нь нэмж хасах үйлдлийг аргачлалын дагуу гүйцэтгэх даалгаврыг оруулсан. (Крепелиний арга). Эдгээр даалгаврууд нь хүүхдийн насны онцлог чадвартай нь уялдан даалгаврын хүндийн

түвшин нь үйлдлийн энгийн хялбар байдал, анхаарлын төвлөрөл, хийсвэр сэтгэхүйн оролцоогоороо ялгаатай юм. Тухайн аргуудаар анхаарлын төвлөрөл, шилжилтийн чадварыг нь хамтад нь тодорхойлсон.

Мөн 8-аас дээш насанд өгөгдсөн тоонуудад харгалзах тэмдэглэгээг хийх даалгавар нэмэлтээр орсон (*Векслерийн “шифрлэх” тест*). 8-10 насанд тоон үйлдэл хийх, 11-14 насанд үсэг олж тэмдэглэх, 15-17 насанд тоон үйлдэл хийх зэрэг даалгаврууд нь харьцангуй анхаарлын тогтворжилт, хийсвэр сэтгэхүйг илүү шаардана. Харин энгийн нэг оронтой тоонд харгалзах дүрс тэмдэглэгээг хийх нь харааны хүртэхүй, хөдөлгөөний чадвар илүү оролцдог онцлогтой. Тухайн даалгавраар гүйцэтгэлийн хурдыг үнэлэх боломжтой. Мөн танин мэдэхүйн хийсвэрлэлийн түвшинг харьцуулан тодруулах үүднээс даалгаврыг сонгосон болно.

3.Ой тогтоолтыг судлах даалгавар

а/ Богино хугацааны харааны ой тогтоолтыг судлах даалгавар

Богино хугацааны ой тогтоолтыг 2 аргачлалаар судалсан. Нэгдүгээрт нь, 8 ба түүнээс дээш насанд 2 оронтой 12 цифрийг хараад дарааллаар нь тогтоох (Э.Р.Ахмежановын арга (Ж.Миллерийн арга ч гэж нэрлэдэг), хоёрдугаарт, хялбар дүрс, зургийг хараад дэс дарааллаар нь тогтоох (12 дүрс зураг) гэсэн хоёр даалгаврыг сонгосон.

3-5, 6-7 насанд энгийн зураг тогтоох (3-5 насанд 9 зураг, 6-7 насанд 12 зураг) аргаар богино хугацааны ой тогтоолтыг судалсан.

8-аас танин мэдэхүйн хөгжлийн түвшин, ой тогтоолтын онцлогийг тодорхойлох үүднээс цифр болон дүрс, зургийг тогтоох 2 аргачлалаар судалгаа авсан. Цифр тогтоох нь сэтгэхүйн харьцуулах, хийсвэрлэх болон анхаарлын төвлөрлийн оролцоог илүү шаарддаг бол энгийн дүрс, зураг тогтоох нь шууд харааны хүртэхүй, төсөөллийн оролцоотой явагддаг тул илүү хялбар байдаг байна.

б/ Богино хугацааны сонорын ой тогтоолтыг судлах даалгавар

Мэдээллийг сонсоод шууд сэргээн санах богино хугацааны ой тогтоолтыг судлахдаа бид 10 үг сонсоод сэргээн санах арга (А.Р.Лурнигийн арга)-аар судаллаа. 3-5 ба 6-7 насанд өгөгдсөн үгс нь адилхан, харин 8-10 ба 11-14 насанд тогтоох үгс нь мөн адилхан байхаар боловсруулсан. 3-7 насанд тогтоох үгс нь энгийн бодит үгс байх ба 11-14 насанд үгсийн нөөцийг харгалзан үзэж юмсыг нэрлэсэн, хийсвэр үгс оролцсон үгсийг сонгож авсан. Харин 15-17 насанд юмс үзэгдлийн талаарх мэдлэгтэй нь холбоотой үгс, хийсвэр үгсийг тогтоож сэргээн санахад чиглэсэн.

Ийнхүү даалгаврын сонголт бүхий үгс нь бодитоос хийсвэр рүү чиглэсэн байгаа нь насны онцлогийг тусгахаас гадна танин мэдэхүйн хийсвэрлэл, зориудын шинжийг илрүүлэх зорилготой. Нас нэмэгдэх тусам үгс илүү хийсвэрлэлтэй болж байгаа нь ой тогтоолтын зориудын шинжийг илүү шаардана. Харин үгс нь илүү танил энгийн байх нь зориудын хүчин чармайлтыг тодорхой хэмжээгээр шаардах ч төсөөлөл дээр тулгуурладаг онцлогтой.

в/ Утгын ой тогтоолтыг судлах даалгавар

Мэдээллийг утга санаа, учир шалтгаан, холбоо хамааралд нь тогтоох чадвар болсон утгын ой тогтоолтыг богино хэмжээний өгүүллэг, үлгэр сонсоод утгаар нь үйл явдлыг нь сэргээн санах аргаар судалсан (Утгын ой тогтоолтыг судлахад өргөн хэрэглэгддэг аргачлал бөгөөд анх С.Я. Рубинштейн үндсийг нь тавьсан гэж үздэг, 1962). Энэ чадварыг 6-7, 8-10, 11-14, 15-17 насанд судалсан.

6-7 насанд энгийн хураангуй өгүүлбэртэй, хялбар үйл явдалтай өгүүллэгийг уншиж өгч утгаар нь үйл явдлыг нь яриулах даалгавраар судалсан. 8-10 насанд энгийн үйл явдалтай үлгэр, 11-16 насанд олон үйл явдлыг агуулсан хийсвэр утга оролцсон үлгэр, 17 насанд илүү нарийн үйл явдал, хийсвэр үг, мэдлэг туршлагатай холбогдохуйц богино хэмжээний өгүүллэгийг сэргээн санах даалгаврыг хүүхэд гүйцэтгэсэн.

Ийнхүү насны онцлог, хамрагдаж буй боловсролын түвшинтэй уялдуулан даалгаврын агуулга гүнзгийрсэн. Өгүүллэг, үлгэр энгийн байх тусам анхаарлын тогтворжилтыг бага шаардаж, үйл явдлыг төсөөлөн тогтоох боломжтой. Харин өгүүллэг, үлгэрийн үйл явдал нарийсах тусам анхаарлын тогтворжилт, хийсвэр сэтгэхүй, хэл ярианы хөгжлийн оролцоог илүү шаардана. Энэ нь мөн танин мэдэхүйн хөгжлийн нэгдмэл байдлыг илэрхийлэх боломжтой юм.

Сэтгэхүйг судлах даалгавар

Сэтгэхүй нь юмсын зүй, тогтол, холбоо хамаарлын шинж, учир шалтгааныг таньж мэдэх сэтгэцийн шууд бус тусгал юм. Хүний сэтгэхүй нь бодитоос хийсвэр шинж рүү чиглэн хөгждөг тул сэтгэхүйг ерөнхийд нь бодит ба хийсвэр сэтгэхүй гэж 2 хуваадаг. Бодит сэтгэхүйн хөгжилд тулгуурлан хийсвэр сэтгэхүй хөгжинө.

Сургуулийн өмнөх насанд танин мэдэхүй нь бодит шинжтэй байх ба хүүхэд юмс үзэгдлийг бодитоор хүртсэний үндсэн дээр таньж мэддэг. Харин сургуульд орсноор хийсвэр сэтгэхүйн хөгжил эрчимтэй хөгжиж ялангуяа 7, 8 наснаас хүүхдэд хийсвэр ойлголтууд бий болж, сэтгэхүйн ангилах, хийсвэрлэх, харьцуулах гэх мэт чадвар илт

нэмэгддэг байна (Л.С.Выготский). Бид бодит ба хийсвэр сэтгэхүйг гол судлагдахуун болголоо.

а/ Хийсвэр сэтгэхүйг судлах даалгвар

Хийсвэр сэтгэхүйн даалгавар нь сэтгэхүйн харьцуулан нэгтгэн дүгнэх чадварыг илрүүлэхэд чиглэнэ.

Танин мэдэхүйн хөгжлийг судлахад өргөн хэрэглэдэг сонгодог тестүүд тухайлбал, Векслерийн тестийн 3-7 насны хувилбар (WPPSI)-т орсон даалгавар болох зургуудыг дарааллаар нь байрлуулах, 7-16 насны хувилбарт асуултад хариулах, 16-аас дээш насанд арифметик хийсвэр сэтгэхүйн хөгжлийг судалдаг байна. Стэнфорд-Бинегийн тестэд сэтгэхүйн хөгжил, ойлголтын төлөвшлийг асуултад хариулах даалгавраар судалдаг байна.

3-5 насанд энгийн зурган дүрслэлийг хараад учир шалтгаан, зүй тогтлыг нь таних чадварыг илрүүлэх даалгавраар судалсан (Р.С.Немов). Энэ нь тухайн насны хүүхдийн энгийн юмс үзэгдлийн талаарх мэдлэг, төсөөлөлтэй нь холбоотой ба шууд хүртэхүйн чадварт тулгуурласан. Хүүхдийн ажигч чанар, бүхэлд нь харж ойлгох дээр үндэслэн юмс үзэгдлийн зүй тогтол, үр дагаврыг нь таних чадварыг илрүүлэхэд чиглэнэ.

6-10 насанд асуултад хариулах аргаар судалсан. 11-17 насанд арифметик үйлдэл хийх сэтгэхүйн чадвараар судалсан (Векслерийн тест). Тухайн даалгавар нь 11-14, 15-17 насанд хүнд хөнгөний түвшнээрээ ялгаатай.

б/ Бодит сэтгэхүйн даалгавар

3-5, 6-7 насанд хүүхдийн бодит дүрслэлийн сэтгэхүйг судлав. Сургуулийн өмнөх насанд хүүхэд энгийн дүрс зургийг хараад хэлбэр, хэмжээ, холбоос зэргийг нь хүртэн ойлгож, дуурайж гүйцэтгэх чадвартай байх ба энэ нь сургуулийн бэлэн байдлыг тодорхойлох нэг үзүүлэлт юм. Хүүхэд сургуульд орсноор хийсвэр сэтгэхүй эрчимтэй хөгждөг боловч тэдний танин мэдэхүйд бодит сэтгэхүй давамгайлсаар байдаг тул сургалт хөгжлийн бүхий л үйл ажиллагаанд үүнийг тооцон үзэх зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ насанд хүүхдийн танин мэдэх үйл ажиллагаа нь юмсыг хараад түүний холбоо хамаарлыг таньж мэдэх чадвар танин мэдэхүйд илүү давамгайлдаг. Тухайн чадвар нь хүүхдийн харааны хүртэхүй, хөдөлгөөний эв дүй, чадвар дадалтай ихээхэн холбоотой.

Бодит дүрслэлийн сэтгэхүй нь янз бүрийн холбоос бүхий энгийн дүрсийг хараад холбоосыг ойлгож дуурайж зурах, мөн өгөгдсөн хэмжээний дагуу дүрсийг дуурайж

зурах даалгавраар бодит сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судалсан. 3-5 насанд дүрсийн тоо цөөн.

в/ Сэтгэхүйн харьцуулах чадварыг судлах даалгавар

- Хэл ярианы бус - сэтгэхүйн харьцуулах чадвар

Сургуулийн өмнөх насанд юмсын хэлбэр хэмжээг хараад адилтгах, ялгаатай зүйлийг нь олж харах чадвар хөгждөг нь сэтгэхүйн харьцуулах чадвар хөгжих урьдал болно. Иймд 3-5 насанд 4 бүлэг дүрсээс ялгаатай дүрсийг олох цуурал даалгавраар сэтгэхүйн харьцуулах чадварыг судалсан. Даалгавар хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн 4 багц хэсэгтэй.

- Хэл ярианы - сэтгэхүйн харьцуулах чадвар

Сэтгэхүйн харьцуулах чадвар нь хийсвэр сэтгэхүйн хөгжлийн чухал үйлдэл бөгөөд хүний сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэх, ангилах үйлдэлтэй холбоотой юм. Ялангуяа задлан шинжлэх сэтгэхүйн чадвартай холбоотой юм.

1. Бага боловсролын 8 наснаас эхлэн хүүхдэд сурах чадвар, хийсвэр ойлголтын төлөвшил, танин мэдэхүйд нь хийсвэр сэтгэхүйн оролцоо нэмэгддэг тул хэл ярианы - сэтгэхүйн харьцуулах чадварыг 8-14 насанд юмсын хоорондын илэрхий харьцаа, зүй тогтлыг нь таньж мэдэх даалгавраар, 15-17 насанд хийсвэр сэтгэхүй танин мэдэхүйд нь давамгайлж юмс үзэгдлийн дотоод учир шалтгааныг танин мэдэх нас зүйн онцлогийг харгалзан үзэж ойлголт хоорондын багтаамж, харьцаа, утгын холбоо хамааралд нь харьцуулах даалгавраар судалсан.

в. Хэл яриа - сэтгэхүйн харьцуулах чадвар – ижил төсийг олох даалгавар

8-аас дээш насанд хэл яриа-сэтгэхүйн харьцуулах чадварыг судлахдаа юмсын ижил төсөөтэй талыг нь таних даалгавраар судалсан. Өмнө нь дурдсан даалгавар нь юмсын хоорондын харьцаа холбоог илрүүлэх бол энэхүү даалгавар нь ижил төстэй талыг нь танихад чиглэнэ. Тухайн даалгавар нь юмсын гол шинжийг нь гол бус шинжээс нь ялгах, нэгтгэн дүгнэх (синтез) сэтгэхүйн чадвартай илүү холбоотой. Даалгавар нь энгийнээс нарийн руу чиглэсэн бүтэцтэй. Өөрөөр хэлбэл, даалгаврууд нь аажмаар хийсвэр сэтгэхүйн чадвар, задлан шинжлэх чадварыг илүү их шаарддаг. Даалгавар нь 8-14, 15-17 насны 2 хувилбартай. (*Векслерийн тест*)

Сэтгэхүйн нэгтгэх (синтез) чадварыг судлах даалгавар

Сэтгэхүйн нэгтгэх чадвар нь чадвар нь задлан шинжлэх, ижил төсөөтэй шинжийг нь таних, хэл ярианы чадвар, үгийн нөөц, мэдлэг зэргийг шаарддаг нарийн нэгдмэл хийсвэр сэтгэхүйн үйлдэл юм.

Хэдийгээр тухайн чадвар нь сургуулийн өмнөх насны хүүхдэд хожуу төлөвшдөг гэж үздэг боловч хэрхэн хөгждөг онцлогийг нь илрүүлэх үүднээс багц энгийн дүрс зургийг харуулан тэдгээрийг бүхэлд нь нэр өгөх аргаар сэтгэхүйн тухайн чадварыг судлах зорилтыг тавьсан. 4 багц зургийг хэрэглэсэн ба энэ нь хөнгөнөөс хүндэрсэн буюу хүүхдийн сэтгэхүй, мэдлэгийн оролцоог илүү шаардана.

Хэл ярианы чадварыг судлах даалгавар

Хэл ярианы эзэмшилт нь танин мэдэхүй, харилцааны нэгдмэл үйл явцын үр дүн бөгөөд юмс үзэгдэл ба түүнийг тэмдэглэж байгаа үг хоёрын хооронд холбоо үүсэх замаар хөгждөг байна (*Шахнорович А.М*). Хэл яриа ба сэтгэхүйн холбоо нь хүний үг яриа дахь утгаар илэрдэг зүй тогтолтой тул хэл яриа ба сэтгэхүй нь салшгүй холбоотой юм. Хэл ярианы хөгжлийг судлахдаа үгийн утгыг эзэмшсэн байдал буюу юмсын талаарх ойлголтын төлөвлөөр тодорхойлдог. Хэл ярианы хөгжил нь үгийн хэрэглээний онцлог, хувь хүний зан төлөвийн онцлог, сэтгэхүйн ерөнхийлөх нэгтгэн дүгнэх чадвартай холбоотой юм (Леонтьев, А.Н, 1989).

Хэл ярианы хөгжлийн илрэл болох ойлголтын төлөвшлийг судлахдаа хэвтээ ба босоо гэсэн 2 чиглэлээр судалдаг сэтгэц-хэл шинжлэлийн хандлага байдаг. Хэвтээ чиглэлд үгийн утгын хийсвэрлэлийн түвшин, сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар зэрэг сэтгэцийн талыг нь судалдаг бол босоо чиглэлд нь үгийн нөөцийг авч үзнэ. Практикт хэрэглэхдээ судалгааны зорилгоос хамааран нэгийг нь эсвэл хоёуланг нь сонгож хэрэглэдэг (*Шахнорович.А.М, 1973*).

Хэл яриа нь сэтгэхүйтэй хамтдаа хөгждөг. Иймд хүний танин мэдэхүйн хөгжлийг судлахдаа хэл яриа, сэтгэхүйг хамтад нь авч үздэг.

Хүүхдийн хэл ярианы хөгжлийг оношлох үндсэн 2 чиглэл байна. Нэгдүгээрт нь, хэл шинжлэл талаас ойлголтын төлөвшил, идэвхтэй хэрэглэж буй үгийн тоо, өгүүлбэр зүйн хэрэглээг, сэтгэл зүйн талаас нь үгийн утгын хийсвэрлэлийн түвшин, сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадварыг хэл ярианы хөгжлийн үзүүлэлт болгон судалдаг. Гэтэл ийнхүү салгаж үзэх нь практик дээр боломж хязгаарлагдмал байдаг. Учир нь хэл яриа нь хэл шинжлэлийн ч сэтгэл зүйн шинжийг ч адилхан агуулдаг тул нэгдэлд нь судлах нь зохимжтой юм (Немов.Р.С, 2001).

Векслерийн тестийн даалгаварт ойлголтын төлөвшлийг асуултад хариулах асуултад хариулах, үгийн нөөцийг үг тайлбарлах даалгавраар судалдаг.

Иймд дээрх онцлогийг харгалзан хэл ярианы хөгжлийг оношлох даалгаврын сонголт, боловсруулалтыг хийхдээ хэл шинжлэл талаас нь ойлголтын төлөвшил буюу үгийн утгын эзэмшилт, идэвхтэй хэрэглэж буй үгийн тоо, өгүүлбэр зүйн

хэрэглээний онцлогийг, сэтгэл зүйн талаас үгийн утгын хийсвэрлэлийн түвшин, сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар зэргийг гол үзүүлэлт болгосон.

6-17 насанд ойлголтын төлөвшлийг судлахдаа үгийг утгын гол шинжид нь тулгуурлан тайлбарлах, утгын ижил төстэй шинжээр нь үгсийг бүлэглэх даалгавраар судалсан.

Мөн зураг хараад ярих даалгаврыг 3-17 хүртэлх насанд оруулсан. Энэ нь санаагаа өгүүлбэрээр илэрхийлж байгаа болон нэгтгэн дүгнэх онцлогийг илрүүлэхэд чиглэнэ. 3-5 насанд зураг нь ялгаатай байх ба хүүхэд санаагаа хэрхэн илэрхийлж байгаа үг, өгүүлбэрийн хэрэглээний онцлогийг илрүүлэхэд чиглэнэ.

НИЙГЭМШЛИЙН ДААЛГАВАР

Нийгэмшлийн даалгаврыг судлуулагчийн өөртөө хандах хандлага, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа, дасан зохицолт, ээнэгшилт, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээний төлөвшлийг илэрхийлэх бодомж хэлбэрээр өгсөн.

Олон улсын боловсролын салбар нь хүүхдийн Нийгэмшлийн хөгжлийг үнэлэн боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж ирсэн. Үүнийг “Нийгэм-сэтгэлийн хөдлөлд суралцах” (SEL) болон Skills for Life (SFL) хэмээн томъёолж олон улс орнууд боловсролын хөтөлбөртөө нэвтрүүлж байна. Нийгэм-сэтгэлийн хөдөлгөөнд суралцах загварт суурилсан хөтөлбөрүүдийн жишээг дурдвал Collaborative for Academic, Social and Emotional Learning (CASEL), Center for Social and Emotional Education, Edutopia: The George Lucas Educational Foundation, TRIBES зэрэг төрийн бус байгууллагууд нийгэм сэтгэлийн хөдөлгөөнд суралцах ур чадварыг боловсролын байгууллагуудад, эцэг эхчүүдэд болон сурагчдад зориулан үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү загварын үндсэн ойлголт нь хүүхэд болон насанд хүрэгчдэд амьдралын үндсэн чадварууд болон өөрийн зохион байгуулалт, харилцааны ур чадвар, ёс зүй эзэмшүүлэх зорилготой байдаг байна (Edutopia, 2014).

Нийгэмшил – Сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн хэмжигдэхүүн нь өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, бусдын сэтгэлийг ойлгох, бусадтай эерэг харилцааг таслахгүй үргэлжлүүлэх, хариуцлагатай шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, чадвар, туршлага эзэмших, түүнийг үр дүнтэй амьдралдаа хэвшүүлэх үйл явцын нэгдэл юм (Collaborative for Academic, Social, and Emotional Learning, 2013). CASEL

Нийгэмшлийг:

1. Нийгмийн харилцааны чадамж (Social Skills)

2. Сэтгэлийн хөдөлгөөний чадамж (Emotional skills, Responsible Decision making)
3. Өөрийн ухамсар (Self-awareness)
4. Ээнэгшилт (Attachment)
5. Бие хүний онцлог (Personality) гэсэн дэд хэсгүүдэд хуваасан байна. Дээрх судалгаанд үндэслэн монгол хүүхдийн нийгэмшлийн хөгжлийн чадварыг 7 шалгуураар судлан гаргаж ирсэн. Үүнд:

1. Нийгмийн харилцааны чадвар
2. Нийгмийн дасан зохицох чадвар
3. Үнэт зүйл ба хэм хэмжээ
4. Бие хүний зан төлөв
5. Өөрийн ухамсар
6. Сэтгэлийн хөдөлгөөний чадвар
7. Ээнэгшилт

Эдгээр шалгуур үзүүлэлтийг тус бүрт нь авч үзье.

1. Нийгмийн харилцааны чадвар

Хүүхэд бүр бусдын адилаар өөртөө болон нийгмийн хөгжилдөө хувь нэмэр оруулах чадвартай байдаг бөгөөд бусадтай нээлттэй сайн харилцаатай байх нь түүний нийгмийн чадамжийн түвшинг нэмэгдүүлдэг аж. Жишээлбэл, харилцааны хувьд бусадтай нээлттэй биш, өөрийн байр суурийг тогтоож чадаагүй хүүхдүүд хэвийн харилцаатай хүүхдүүдээс илүү эвдэн сүйтгэх хандлагатай, түрэмгий авиртай байдаг байна (Hartup, 1992). Нөгөө талаас хүүхэд бусадтай тоглох, харилцах цаашлаад өөрийгөө энэ нийгмийн нэгээхэн хэсэг гэж мэдэрснээр бусадтай харилцах харилцаа нь илүү бат бэх болж эерэг харилцааны чадварыг эзэмшдэг байна.

Нийгэм-сэтгэл зүйн дасан зохицол

Нийгэм-сэтгэл зүйн дасан зохицол гэдэг нь хүн нийгмийн шинэ орчин нөхцөл, харилцан үйлчлэлд суралцах үйл явц юм. Энэ нь харилцаа болон тухайн нийгмийн бүлгээс ихээхэн шалтгаалдаг.¹ И.Б.Котова ба Е.Н.Шиянов нарын эрдмийн ажилд дурдсанаар дасан зохицол нь нийгэмшлийн нэг бүрэлдэхүүн хэсэг аж.

Харчева В.Г. «Социологийн үндэс» номондоо нийгэмшлийн 2 хэлбэрийг хуваасан байна: “Дасан зохицол” буюу нийгмийн орчин, түүний шаардлагад идэвхгүй суралцах хэлбэр, мөн “идэвхтэй харилцан үйлчлэлцэл” буюу нийгэмдээ нөлөөлөх эрхээ эдлэх хэлбэр.

¹ [Гриценко В.В.](#), доктор психологических наук, профессор

Ж.Пиаже хүний сэтгэцийн хөгжил нь бүхэлдээ дасан зохицох үйл явц гэж үзэж, энэ нь ижилсэх (ассимиляци) болон зохицох (аккомодаци) гэсэн 2 арга замаар явагддаг гэж үзсэн. Ижилсэх нь нэгэнт эзэмшсэн мэдлэг, туршлага, чадвараа орчинтойгоо зохицуулан хэрэглэх талаарх ойлголтыг агуулна, харин зохицох нь хүүхэд шинэ зүйлийг сурч мэдэн, орчиндоо тохирсон зан үйлийг эзэмшихийг хэлнэ. Нийгэм-сэтгэл зүйн дасан зохицлыг Америкийн сэтгэл зүйч К.Рожерс өөрийгөө хүлээн зөвшөөрөх, бусдыг хүлээн зөвшөөрөх, сэтгэл хөдлөлийн тав тухтай байдал, манлайлах чиг хандлага гэсэн үзүүлэлтээр хэмжих боломжтой гэжээ.

К.Рожерс, Р.Даймонд нар хүн нийгэмдээ хэрхэн төлөвшиж, нийгэм-сэтгэл зүйн хувьд дасан зохицох үйл явцад бие хүний хөгжлийн хөдөлгүүр болох өөрийн үнэлэмж, өөрийгөө болон бусдыг хүлээн зөвшөөрөх чадвар, нийгэм дэх чиг баримтлал, манлайлах тэмүүлэл мөн бусдыг даган дуурайх хандлага зэрэг чухал нөлөөлдөг гэж үзсэн байдаг.²

Энэхүү үзлийн дагуу дээрх бие хүний үзүүлэлтүүдийг илрүүлэх мөн нийгэм сэтгэл зүйн дасан зохицох чадварыг илрүүлэх сэтгэл зүйн оношилгоо судалгааны аргыг 1954 онд боловсруулан гаргажээ. Тухайн аргыг 2004 онд ОХУ-ын Сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор А.К. Осницкий өөрчлөн гаргасан.

Бид судалгаандаа 6-17 насанд К.Рожерс, Р.Даймонд нарын онолыг баримтлан судалгааны аргыг нь ашигласан.

2. Өөрийн ухамсар

Өөрийн ухамсрын онолд өөрийн ухамсар бол хүрээлэн бүй орчны үйл явдлууд дунд өөрийн хувийн байдал, амьдрал, бие махбодоо ухааран ойлгох байдал гэж тодорхойлжээ. (Duval & Wicklund, 1972, p.2).

LeFrancois (1996)-ийн дэвшүүлснээр өөрийн ухамсрыг өөртөө итгэлтэй байдал, өөрийн тухай ойлголт төсөөлөл, өөрийн идэвхжүүлэлт гэсэн хэсгүүд бүрдүүлнэ. Өөрийн ухамсар бол танин мэдэхүйн механизм дээр үндэслэсэн өөрийн талаарх төсөөлөл гэж зарим судлаачид үздэг (Alison Gopnik, 1994). Оксфордын толь бичигт тайлбарласнаар “Өөрийн зан төлөв, мэдрэмж, хүсэл, сэдлийг ухамсарласан мэдлэг”³. Бие хүний өөрийн ухамсар нь өөрийгөө бусдын нүдээр харж үнэлэх чадвар⁴ зэргээр тайлбарласан байна.

² Dymond R. Adjustment changes over Therapy Self-sorter. // Psychotherapy and Personality Changes. / Ed. by Rogers and R. Dymond. Chicago, 1954.

³ <http://www.oxforddictionaries.com/>

⁴ Л.Уранцэцэг, М.Дэлгэржав, Бие хүний нийгмийн сэтгэл зүй, УБ., 2012, хуудас 151

Эдгээрээс нэгтгэн “Өөрийн ухамсрыг” тодорхойлбол: Хүрээлэн буй ертөнцөөс тусгаар байдлаа ойлгох явцад өөрийн нийгмийн дүр, сэтгэцийн үзэгдэл, өөрийн өнгөрсөн-одоо-ирээдүй дэх баримжааг үнэлэх чадвар юм. Өөрийн ухамсар нь зан үйлээ зохицуулахад гол үүрэг гүйцэтгэнэ.

Бид судалгаандаа өөрийн ухамсрыг судлахдаа 6-17 насанд М.Росенбергийн “Өөрийн хүндлэлийн тест” болон В.В.Столин, С.Р.Пантелеев нарын “Өөрт хандах хандлагыг судлах тест”ийг ашиглалаа.

3. Сэтгэлийн хөдөлгөөний чадвар

Хүүхдийн хөгжилд сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, ялган таних чадвар маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн чадвар хангалтгүй байх нь цаашдаа бие хүний хөгжил төлөвшилд сөргөөр нөлөөлдөг. Сэтгэл санаатай холбоотой олон асуудал нь тухайн чадвар сул байгаатай холбоотой (J.Ciarrochi, 2006). Хэдийгээр өнгөрсөн хугацаанд бие хүний ажиллах бүтээмжийг үнэлэх үндсэн арга нь оюун ухааны тест байсан боловч сүүлийн жилүүдэд сэтгэлийн хөдөлгөөний чадамжийг судлах түүнийг боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхийг дэмжих сэтгэл судлаач нар олширсон (Qualter, 2007).

Сэтгэл судлаачид 1930 оноос эхлэн сэтгэлийн хөдөлгөөний тухай судалж эхэлсэн бөгөөд анх нийгмийн оюун ухаан гэсэн нэршилд хамруулсан байв. Барууны сэтгэл судлалын салбарт “сэтгэл хөдлөлийн чадамж” гэх ойлголт XX зууны төгсгөлд гарч ирсэн байна. Энэ нэр томъёоны талаар ОХУ-ын нэлээн хэдэн эрдэмтэд өөрийн үзлийг илэрхийлсэн ба тэдгээрийн гол төлөөлөгчид Л.С.Выготский “мэдрэмжүүдийн нэгдэл”, А.В.Запорожец “сэтгэл хөдлөлийн төсөөлөл”, В.С.Мухина “мэдрэмжийн оюун ухаан” зэрэг онолоор тодорхойлсон байна. Эдгээр ойлголтын нэгтгэн 1990 онд сэтгэл судлаач Петер Саловей, Жонн Маейр нар “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан” гэсэн ойлголтыг гаргасан бол олон нийтэд хүргэсэн хүн нь 1995 онд Emotional Intelligence – EQ номыг бичсэн Даниел Голмен юм. Үүнээс хойш сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны сорил 90-ээд оноос эхлэн дэлхий дахинд дэлгэрч эхэлжээ. Тухайлбал, эрдэмтэн Ваяне Паяне 1985 онд докторын зэрэг хамгаалах нэг сэдэвт бүтээлээрээ EQ (Emotional Intelligence test) сорилыг анх танилцуулсан байна. Улмаар 1987 онд EQ сорилыг ашиглаж судалгаа хийсэн анхны эрдэм шинжилгээний өгүүллэгүүд бичиж байв.

Бид судалгаандаа 6-17 насанд В.Люсиний сэтгэл хөдлөлийн асуулгыг ашигласан бөгөөд энэ нь бусдын болон өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийллийг хянах чадварыг агуулжээ.

4. Бие хүний онцлог

Ротбартын зан араншингийн 3-н талт онолын үндсэн ойлголт нь хүүхдэд танин мэдэхүйн болон нийгмийн хүчин зүйлээс нөлөөлөх нөлөөллөөс өмнө хүүхдэд бий болох төрөлхийн араншин юм. Сүүлийн 25 жилд энэ аргачлал нь араншинг тодорхойлох хамгийн өргөн хүрээтэй аргачлалуудын нэг болсон.

Таван хүчин зүйлийн онол нь зан араншин (темперамент)-гийн онолоос урган гарсан ба сүүлийн хориод жилийн судалгааны үр дүнгээр бие хүний хүчин зүйлсийг хэмжихэд тохиромжтой хэмээн судлаачид санал нийлж байна.

Бидний ашигласан тестийн загвар нь бие хүнийг судалдаг Айзанк, Олпорт болон Кеттел нарын ажлууд дээр тулгуурласан болно.

Бие хүний онцлогийг судалснаар сэтгэл хөдлөлийн хөгжлийн хувьд тухайн хүний суурь онцлогт тулгуурлаж (жишээлбэл, сэтгэл санааны тогтвортой байдал, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн хурд), хөгжлийн бусад үзүүлэлттэй холбон харьцуулж, улмаар сэтгэл хөдлөлийн хөгжлийг нь тодорхойлох боломжтой. Мөн хүний суурь зан чанарын онцлог болоод бие хүний онцлогийг тодорхойлсноор нийгэмшихүйн хөгжлийн хувьд яагаад өөр байгааг эсвэл яагаад хоцрогдолтой байгааг дүн шинжилгээ хийх боломжтой болно. Үүний нэг жишээ нь: зарим хүүхдүүд нийгмийн хэм хэмжээг дагахгүй байдлыг авч үзвэл энэ нь магадгүй тухайн хүүхдүүдийн сөрөг зан төлөвөөс (Ротбартын тестийн нэг хэмжүүр) болсон байх жишээтэй.

Ротбартын бие хүний онцлог:

- Идэвхтэй/гадагшаа (эерэг хүлээлт, өдөөлттэй, өндөр идэвхтэй, мэдрэмжтэй),
- Сөрөг нөлөөтэй (айдас, уйтгар таагүй байдал, уур, цөхрөл),
- Хичээмтгий хяналт (анхаарал төвлөрүүлэх шилжүүлэх, саатуулах/хүлээж авахгүй байх хяналт, хүртэхүйн мэдрэмж, таашаал бага хүлээн авалт)

6-17 насанд Rothbart Early Adolescent Temperament, Таван хүчин зүйлийн тест - Big Five-ийн аргыг ашиглалаа.

5. Энэнгшилт

Энэнгшилт нь хүмүүсийн хооронд үүссэн цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах сэтгэлийн хөдөлгөөний бат бөх, тогтвортой холбоо юм (Ainsworth, 1973; Bowlby, 1969).

Хүүхдийн нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил тогтвортой явагдахын тулд хүүхэд анхдагч асран хамгаалагчтай тодорхой холбоо харилцаа үүсгэсэн байх хэрэгтэй. Энэхүү харилцааны загвар нь насан туршид хадгалагдаж, тухайн хүний зан үйлийг тодорхойлдог (Bowlby, 1969).

Хүүхдийн ээнэгшилтийн загвар нь хүүхдийн “Би” үзэл баримтлал, сэтгэлийн хөдөлгөөний зохицуулалт болон бусадтай харилцах харилцааны загварыг тодорхойлдог. John Bowlby 1920 онд онолын үзэл бодол болон ерөнхий санааг гаргасан бол Mary Ainsworth 1960-70 онолын үндэслэлийг туршилтаар батлан дэлгэрүүлсэн.

Ээнэгшилт (Attachment) загвар нь дараах хүчин зүйлээр тодорхойлогдоно. Үүнд:

- "Care-giving bond"- халамж анхаарал хүсэх ээнэгшилт
- "Alarm"- Айдас ба аюулаас зайлсхийхтэй холбоотой үүсэх ээнэгшилт
- "Anxiety"- Уур бухимдлаа гаргах байдлаар үүсэх ээнэгшилт

Бага насны хүүхдийн ээнэгшилтийн загвар нь хүүхдийн үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны загварыг тогтоодог ба энэ нь насанд хүрсэн үеийн харилцааны загвар, өөрийн үнэлэмж болон нийгэмд үзүүлэх зан үйлийн суурь болдог. Хүүхдийн ээнэгшилтийн загварыг тодорхойлох хүчин зүйл нь эцэг эхийн хүмүүжлийн арга барил ба гэр бүлийн орчин дах эрсдэл эсвэл боломжоос шалтгаалдаг ба энэ нь бат бөх бус холбоогоор холбогдсон хүүхдийн нийгмийн чадамж, зан үйлийн асуудлыг тодорхойлох томоохон хүчин зүйл болдог.

б. Хэм хэмжээ, үнэт зүйл

Хэм хэмжээ гэдэг нь нийгэмд хүмүүс хэрхэн биеэ авч явах хэрэгтэй байдаг талаархи итгэл үнэмшил ба нийтээр хүлээн зөвшөөрсөн зан үйлийн тогтсон загвар юм. Мөн зохистой болон зохисгүй хэм хэмжээ, үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага болон зан үйлийн талаарх хүмүүсийн тогтоосон (хэрэглэдэг) дүрэм журам юм. Эдгээр дүрэм журмууд нь ил болон далд байж болно. Социологичид тодорхойлохдоо хэм хэмжээ гэдэг бол нийгмийн зан үйлийг жолоодож байдаг албан бус ойлголт хэмээн үзсэн [1].

Үнэт зүйл нь зан үйлийг бүрэлдүүлэгч, тогтсон хэм хэмжээ нь зан үйлээр хэр их илэрдэг, нийгмийн бүлэг тухайн илэрч буй зан үйлийг хэрхэн хүлээж авдаг вэ гэсэн хоёр хэмжүүрээр тодорхойлогдоно [2].

Үнэт зүйлсийн төрлүүдийг ёс зүй, ёс суртахуун, үзэл суртал, оршихуй, оюун санааны, нийгмийн, гоо сайхны үнэт зүйлс гэж авч үздэг. Эдгээр үнэт зүйлс нь хүний зан төлөв, үйлдлийн сонголтод нөлөөлж, түүний баримжаалал болж байдаг. Жишээлбэл, хувь хүний үнэт зүйлд хүлээн зөвшөөрөх, өгөөмөр байдал, хүндлэл, хичээл зүтгэл, итгэл үнэмшил, зэрэг багтаж болно. Социологичид үзэхдээ хувь хүний үнэт зүйлс нь тухайн нийгмийн бүлгээр тодорхойлогдож байдаг ба эдгээр үнэт зүйлс нь тодорхой нөхцөл байдлын дор хэрхэн өөрчлөгддөг болох, ялгаатай

бүлгийн хүмүүс нь нийгмийн зан үйлд нөлөөлж байгаа үнэт зүйлсийг хэрхэн хүлээн авдгийг судалдаг. Харин сэтгэл судлаачид тодорхой үнэт зүйлсийн талаарх итгэл үнэмшил, түүнийг батлах, хүний амжилтад нөлөөлж буй нөлөөлөл талаас нь судалдаг Мөн нөгөө талаар хувь хүний үнэт зүйл нь ёс зүйтэй үйлдэлд суурилсан байдаг. Зарим үнэт зүйл нь физиологийн талаар тодорхойлогддог бөгөөд ерөнхийдөө бие махбодын хувьд өвдөхөөс зайлсхийх, аз жаргалтай, сэтгэл хангалуун байхыг эрэлхийлэх зэрэг объектив байдлыг анхааран үздэг бол бусад үнэт зүйл нь соёлын болон итгэл үнэмшлийн гэх мэт субъектив байдлаар тодорхойлогддог байна.

Хүн юмс үзэгдэл, ойлголтод үнэлгээ өгч, өөрийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн зүйлээ үнэт зүйл гэж тооцдог.

Нийгмийн хэм хэмжээг судлахдаа Вашингтоны их сургуулийн асуулга, үнэт зүйлийн баримжааллыг судлахдаа Шварц Шаломын “Бие хүний үнэт зүйлийг тодруулах асуулга”-аар судалсан.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшлийн чадварын даалгавар

Сургуулийн өмнөх нас буюу 3 наснаас эхлэн хүүхэд бие даасан тусгаар хүн гэдгээ илүү ихээр мэдэрч, энэ нь гадаад зан үйлээр нь тодорхой ажиглагдаж байдаг. Мөн хүүхэд бусдад санаа бодлоо илэрхийлэх чадвартай болсон байна. Энэ онцлогийг гол болгож бид 3-5 насны хүүхдийн нийгэмшлийн чадварыг:

- Өөрийн тухай ойлголт
- Сэтгэлийн хөдөлгөөний чадвар (*өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг мэдэх, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних*)
- Харилцааны чадвар (*үе тэнгийнхэнтэйгээ харилцах чадвар, бусдаас дэмжлэг авах чадвар*)
- Дүрмийг дагах чадвар гэсэн бүрэлдэхүүнээр судалсан. Ингэхдээ асуулт асуух, зураг харуулах аргаар судалсан.

Эдгээр аргачлал нь хүүхдийн харилцааны үед зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах, биеэ авч явах чадварын тухай мэдлэг, төсөөлөл, чадварыг илрүүлэхээс гадна хүүхдийн хүртэхүй, сэтгэхүй, хэл ярианы хөгжлийн онцлогийг давхар илрүүлэх боломжтой юм.

БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН АРГАЧЛАЛ

Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн байдал нь ямар нэг өвчинтэй байгаагаар бус, харин тэдний бие бялдрын болон оюуны өв тэгш хөгжлөөр тодорхойлогдоно. Иймд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэхэд чиглэсэн олон асуудлыг

шийдвэрлэхэд өсөлт бойжилтын явцад бие махбодод явагдах биологийн өөрчлөлтийн шинж төрхийг заавал харгалзан үзэх шаардлагатай. Өсөлт, хөгжил гэдэг нь бие махбодод явагдаж байгаа нэгэн процессийн хоорондоо харилцан уялдаатай хоёр тал юм. Өсөлт гэдэг нь бие махбод болон эд эрхтний хэмжээний хувьд өсөн нэмэгдэх тооны өөрчлөлт юм. Хөгжил гэдэг нь эд эрхтний бүтэц, үйл ажиллагааны хувьд боловсронгуй болж байгаа чанарын өөрчлөлт юм. Насны үе шат бүрд бие махбодын өсөлт, хөгжил нь удаашрах, хурдсах зэргээр харилцан адилгүй явагдах бөгөөд түүний үндэс нь бодисын солилцоо юм (Батчулуун,Д., Цолмон,Ч.1990).

1.Биеийн өсөлт

Биеийн өндөр нь интегратив үзүүлэлт бөгөөд “Хүн судлалын онцлог” - ийг тодорхойлох гол үзүүлэлт болдог. Түүнчлэн “өсөлт” гэдэг нэр томъёоны хүрээнд түүний явцыг авч үздэг. Их Британий эрдэмтэн Жеймс Таннер “*Өсөлт бол тухайн нийгэмд болж байгаа үйл явцуудын толь мөн*”- гэж онож хэлсэн. Антропометрийн үзүүлэлтүүд удамшил, угсаа зүй, байгаль, газар зүй болон нийгэм эдийн засгийн гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Мөн сэтгэл зүйн уур амьсгал хүний өсөлтөд нөлөөлж болдог байна.

Удамшил, орчны хүчин зүйлс нь хүний өсөлт хөгжилтөд нөлөөлдөг. Хүний биеийн хэмжээ нь заримдаа эволюцийн дасан зохицох зүй тогтлын илэрхийлэл болдог. Тухайлбал, өндөр нуруутай хүмүүс гол төлөв халуун, чийглэг газар нутгийн бүсэд амьдардаг бол, харин намхан нь хүйтэн, туйлын бүс нутагт амьдардаг байна (Katzmarzyk & Leonard, 1998). Түүнчлэн, хоол унд сайтай, халдварт өвчний тархалт багатай өндөр хөгжилтэй орны хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил сайн байхад, ядуурал, өлсгөлөн, өвчин элбэг тохиолддог буурай орны хүүхэд, залуучуудын өсөлт, хөгжлийн түвшин доогуур байна (Bogin, 2001). Ядуу буурай улсаас баян чинээлэг оронд шилжин ирсэн айл гэрийн хүүхдийн өсөлт, хөгжил сайжирч, биеийн өндөр төдийгүй, хөлний урт нь ч нэмэгддэг байна. Учир нь хүүхэд насанд хамгийн түрүүн хөл нь урт болж хөгждөг.

Бид биеийн өсөлт хөгжлийг сургуулийн өмнөх болон сургуулийн насанд биеийн өндөр, жин, толгой, цээж, бүсэлхийн тойрог, хөлийн хүч буюу уртад харайх чадварыг хэмжсэн. Сургуулийн насанд гарын атгах хүчийг хэмжив.

Биеийн өндрийг өндөр хэмжигч, биеийн жинг жин хэмжигч, биеийн тойргийг хулдаасан метр, уртад харайлтыг шугаман метр, гарын атгах хүчийг динамометр багажаар хэмжсэн.

2.Бие бялдрын бэлтгэлжилт

Бие бялдрын бэлтгэлжилт гэдэг нь биеийн чанаруудыг зорилго-чиглэлтэйгээр хөгжүүлэх, бие бялдрын чадвар дадал эзэмших зохион байгуулалттай сурган хүмүүжүүлэх явц, бие бялдрын бэлтгэлийн үр дүн (Алтанцэцэг,Л. 2011). Хүүхэд, залуусын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тодорхойлох сорил (дасгалууд) - ыг дэлхийн янз бүрийн орнуудад хэрэгжүүлж байна.

Манайд "Ерөнхийлөгчийн зөвлөлийн тест" боловсруулан хэрэгжүүлсэн туршлага бий. Энэхүү судалгаанд - хэрж гүйх 4x30 фут, сунилт, суугаа байдлаас бөхийлт, хэвтээ байдлаас цээжээ өргөх, 1 миль (1550 метр)газар гүйх гэсэн 5 дасгал багтсан. Бид бие бялдрын бэлтгэлжилтийг хурд, авхаалж самбаа, тэсвэр, хүч, уян хатан чанар гэсэн хөгжлийн 5 чанараар хэмжсэн.

Хурд: Сургуулийн өмнөх болон сургуулийн бага насанд хурдыг хэмжихдээ 30 м-ийн, дунд болон ахлах ангийн хүүхдүүдийг 50 м-ийн зайд гүйлгэж хэмжсэн.

Авхаалж самбаа: Сургуулийн өмнөх насанд авхаалж самбааг бөмбөг сагсанд шидэж оруулах аргаар, сургуулийн насанд 10 м-ийн зайд 3 удаа хэрж гүйх аргаар хэмжив.

Тэсвэр: Тухайн чадварыг судлахдаа хүүхэд гүйх харайх чадвартай болсон эсэхийг харгалзан 4-5 насны хүүхдээс авсан болно. 4 насны хүүхдийг 100м, 5 насны хүүхдийг 200 м-ийн зайд гүйлгэж тэсвэрийн чанарыг тодорхойлсон.

Бага ангийн 6-7 насны хүүхдийг 300м, 8-10 насны хүүхдийг 500м-ийн зайд гүйлгэж хэмжилт хийв.

Дунд ангийн 11-14 насны хүүхэд 500м, 15-17 насанд 1000м гүйлгэж тэсвэрийн чанарыг тодорхойллоо.

Хүч: Сургуулийн насанд гар дээр суниах аргаар хэмжив.

Уян хатан: Сургуулийн өмнөх болон сургуулийн насанд уян хатан чанарыг суугаа байдлаас бөхийх аргаар хэмжихдээ секундомер, шугам, шугман метр, тоолох зэргийг ашигласан.

Судалгааны асуулга

Хүүхэд, залуучуудын бие бялдар, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшилд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэн судлах зорилгоор асуулга боловсруулан анкетын аргаар судалгаа авсан. Асуулгыг 6-21 насны хүүхэд, залуучууд бие даан хариулах байдлаар боловсруулсан бөгөөд сургуулийн өмнөх, бага ангийн хүүхдүүдээс хариулж мэдэхгүй тохиолдолд гэр бүл, эцэг эхтэй холбоотой асуулгыг ангийн багш, эцэг эхчүүдээс авсан.

Судалгааны асуултыг:

- Хүн ам зүйн зүйн хүчин зүйл
- Сургуультай холбоотой хүчин зүйл
- Багштай холбоотой хүчин зүйл
- Гэр бүл, эцэг эхтэй холбоотой хүчин зүйл
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлтэй холбоотойгоор боловсруулсан.

Судалгааны үр дүнг боловсруулах арга

Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ даалгаврыг зөв гүйцэтгэсэн онооны нийлбэр дээр үндэслэн Лайкертийн 5 шкалыг хэрэглэсэн. Үүнд: 1- хөгжлийн маш сул түвшин, 2- сул түвшин, 3- дундаж түвшин, 4- өндөр түвшин, 5- маш өндөр түвшин гэж авч үзсэн.

Математик статистик боловсруулалтын хувьд дескриптив статистик арга, дундаж тооцох, дунджийг харьцуулах, найдвартай байдлыг тооцох арга, хүчин зүйлийн анализ, каноникал анализ, даалгаврын ши нжитлгээ, Т-тест, Индепендент Т –тест, Вариацийн шинжилгээ, корреляци, регрессийн аргыг хэрэглэсэн.

Хүчин зүйлийн анализын аргаар даалгаврын тохирц байдлыг насны үе шатаар, хөгжлийн бүрдэл/айгаар даалгавар тус бүрээр илрүүлж, мэдээллийн үр дүнг боловсруулалт хийв.

Тохирцыг илрүүлэхдээ:

- Итгэх мужид хүлээн зөвшөөрөгдөх алдааны хязгаарыг 0.5 хувиар тооцож, ач холбогдлын түвшингийн хязгаарыг 0.4 байхаар сонгов.
- Даалгаврын бүтцийг зорилго, агуулгын хувьд бүрдлийг үүсгэж чадаж байгаа эсэхийг шалгуур болголоо.
- Судалгааны даалгаврын тохирцыг боловсролын түвшин тус бүрээр гаргасан.
- Бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадвар тус бүрээр нийт аргачлалын хүрээнд тохирц байдлыг тодорхойлов.
- Судалгааны аргачлал тус бүрийн даалгаврын тохирцыг илрүүлсэн болно.

Бага боловсролын насны 6-10 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг илрүүлэх даалгаврын тохирцын шинжилгээ

6-7 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг судлахад нийт 4 чадамж, 9 чадвараар тодорхойлов. Судалгааны 1 ба 2-р шатанд хэрэглэсэн даалгаврын тохирцыг авч үзэхэд:

- үгийн утгыг ойлгож нийтлэг шинжээр нь ангилах,

- үгийн утгыг тайлбарлах логик чадварыг илрүүлэх, мэдлэг, ойлголт-хийсвэр сэтгэхүйн даалгавар
- ярих чадварыг илрүүлэх даалгавар
- ажигч чанар, анхаарлын тогтворжилт, сонорын ой тогтоолт, богино хугацааны харааны ой тогтоолтыг илрүүлэх даалгаврын тохирц сайн байна.

Харин тухайн насны хүүхдүүдийн анхаарлын шилжилт, ярих чадварыг дүгнэсэн өгүүлбэрийн хэрэглээ гэсэн үзүүлэлтээр хэмжих нь тохирц тааруухан байна. Бага боловсролын 6-7 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг илрүүлэх даалгаврын бүрэлдэхүүн нь танин мэдэхүйн чадварын бүрдэл, хийсвэрлэлийн шинжийг илэрхийлж чадаж байгаа тул тохирц байдал хангалттай байна.

Судалгааны даалгаврууд нь нийт 6 багцыг үүсгэж байна.


Хүснэгт 1. Танин мэдэхүйн даалгаврын тохирц (6-7 нас), Улаанбаатар

8. Өд	9. Тохирцтой багц даалгавар	10. Тохирц
1.	- Ажигч чанар	.525
	- Богино хугацааны харааны ой	.659
	- Сонорын ой	.431
	- Анхаарлын тогтворжилт	.687
2.	- Хийсвэр сэтгэхүй	.581
	- Үгийн утга тайлбарлах чадвар - Бодит үг түвшин	.817
	- Үгийн утга тайлбарлах чадвар - Хийсвэр үг	.808
	- Үгийн утга тайлбарлах чадвар-Салаа үг	.709
3.	- Үг бүлэглэх Тэмдэг нэр	.822
	- Үг бүлэглэх- Нэрлэсэн үг	.517
	- Үг бүлэглэх - Салаа үг	.828
	- Үг бүлэглэх Хийсвэр үг	.757
4.	- Үг бүлэглэх бодит үг	.684
	- Анхаарлын шилжилт	.687
5.	- Бодит үйлдлийн сэтгэхүй	.577
	- Ярих чадвар-гадаад байдал тоочсон	.671
	- Ярих чадвар-энгийн өгүүлбэрийн хэрэглээ	.771
6.	- Ярих чадвар - нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ	.722
	- Ярих чадвар холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэр	.712
7.	- Ярих чадвар - Дүгнэсэн өгүүлбэрийн хэрэглээ	.877

Хүснэгт 2. Танин мэдэхүйн даалгаврын найдвартай байдлын коэффициент (6-7 нас)

Өд	Чадамж	Чадвар	Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
1.	Хүртэхүй	- Бүхэлд нь ажиглан хүртэх чадвар	.591
2.	Ой тогтоолт	- Богино хугацааны харааны ой-дүрс тогтоох	.663
		- Утгын ой тогтоолт	
		- Сонорын ой тогтоолт	
3.	Сэтгэхүй	- Хийсвэр сэтгэхүй	.718
		- Бодит үйлдлийн сэтгэхүй	.661
4.	Хэл ярианы чадвар	- Үгийг тайлбарлах логик чадвар	.682
		- Үгийг нийтлэг шинжээр нь ангилал логик чадвар	
		- Ярих чадвар	

Зураг 1. Даалгаврын өгөгдлийн ач холбогдлын түвшний хязгаар (6-7 нас)



8-10 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг нийт 4 чадамж, 16 чадвараар тодорхойллоо.

Судалгааны 1-р шатны судалгааны үр дүнд тулгуурлан танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг гүнзгийрүүлэн судлах үүднээс 2-р шатанд нэмэлт даалгавруудыг хэрэглэсэн. 8-10 насанд хүртэхүй, харааны ой тогтоолт сэтгэхүйн харьцуулах чадвар, хийсвэр сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судлах нэмэлт даалгаврууд боловсруулсан. Даалгаврын тохирц чанарыг авч үзэхэд:


- Үгийн утга тайлбарлах чадвар, мэдлэг, ойлголт-сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар, сэтгэхүйн математик/тооцоолох чадвар, сэтгэхүйн харьцуулах – ижил төсийг олох, утгын ой тогтоолтыг судлах, үгийн утгын нийтлэг шинжийг таньж ангилах, энгийн шинжээр нь харьцуулах сэтгэхүйн чадварыг илрүүлэх даалгавар
- Анхаарлын тогтворжилт, анхаарлын шилжилт, бүхэл бүтнээр хүртэх, анхааралтай хурдтай ажиллах чадвар
- Ярих чадварыг илрүүлэх үзүүлэлт болох энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, гадаад байдлыг тоочин ярих үзүүлэлт
- Богино хугацааны хараанд дүрс, цифрийг тогтоох, сонсоод мэдээллийг тогтоох, ажигч чанарыг илрүүлэх даалгавруудын тохирц сайн байна.
- Харин ярих чадварыг илрүүлэх үзүүлэлт болох дүгнэсэн өгүүлбэр, нийлмэл өгүүлбэр, холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ үзүүлэлтийн тохирц нь хангалтгүй байна.

Хүснэгт 3. Танин мэдэхүйн даалгаврын тохирц байдал (8-10 нас)

11. дд	12. Тохирцтой багц даалгавар	13. Тохирц
1.	- Анхаарлын тогтворжилт	.431
	- Анхаарлын шилжилт	.856
	- Хүртэхүйн бүхэл бүтнээр хүртэх чадвар	.530
	- Анхаарал хурдтай ажиллах чадвар	.734

2.	- Үгийн утга тайлбарлах логик чадвар (бодит үг, салаа утгатай үг, хийсвэр үг) - Хийсвэр сэтгэхүйн чадвар - Математик сэтгэхүйн чадвар - Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар - Утгын ой тогтоолтын чадвар	.728 .588 .479 .556 .413
3.	- Сэтгэхүйн харьцуулан задлан шинжлэх чадвар - Үг бүлэглэх чадвар	.462 .757
4.	- Ярих чадвар-энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх чадвар - Ярих чадвар-гадаад байдлыг тоочин ярих	.809 .841
5.	- Богино хугацааны харааны ой-цифр тогтоох чадвар - Богино хугацааны харааны ой-дүрс тогтоох чадвар - Сонорын ой тогтоолтын чадвар - Ажигч чанар	.621 .668 .582 .413

Зураг 2. Даалгаарын өгөгдлийн ач холбогдлын түвшний хязгаар (8-10нас)



Хүснэгт 4. Танин мэдэхүйн даалгаарын найдвартай байдлын коэффициент (8-10 нас)

дд	Чадамж	Чадвар	Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
1.	Анхаарал, Хүртэхүй	- Задлан шинжилж хүртэх/ажигч чанар - Бүхэлд нь хүртэх - Анхаарлын тогтворжилт - Анхаарлын шилжилт - Анхааралтай хурдтай ажиллах чадвар	.720
2.	Ой тогтоолт	- Богино хугацааны харааны ой-цифр тогтоох чадвар - Богино хугацааны харааны ой-дүрс тогтоох чадвар - Богино хугацааны сонорын ой тогтоолтын чадвар - Утгын ой тогтоолтын чадвар	.846
3.	Сэтгэхүй	- Хийсвэр сэтгэхүйн чадвар - Математик сэтгэхүйн чадвар - Задлан шинжилж харьцуулах - Харьцуулан нэгтгэх чадвар	.915
4.	Хэл ярианы чадвар	- Үгийг тайлбарлах логик чадвар - Үгийг нийтлэг шинжээр нь ангилалх логик чадвар - Ярих чадвар	.537

Суурь, бүрэн дунд боловсролын 11-17 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг илрүүлэх даалгаврын тохирцын шинжилгээ


11-17 насны хүүхдийн танин мэдэхүйн чадварыг нийт 4 чадамж, 20 чадвараар тодорхойллоо.

Судалгааны 1-р шатны судалгааны үр дүнд тулгуурлан танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг гүнзгийрүүлэн судлах үүднээс 2-р шатанд нэмэлт даалгавруудыг хэрэглэсэн. 11-17 насанд хүртэхүй, харааны ой тогтоолт сэтгэхүйн харьцуулах чадвар, хийсвэр сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судлах нэмэлт даалгаврууд боловсруулсан.

Хүснэгт 5. Танин мэдэхүйн даалгаврын тохирц байдал (11-17 нас)

дд	Тохирцтой багц даалгавар	Тохирц
1.	- Анхаарлын тогтворжилт	.750
	- Анхаарлын шилжилт	.711
	- Ярих чадвар-дүгнэсэн өгүүлбэр	.532
2.	- Ярих чадвар-энгийн өгүүлбэрийн хэрэглээ	.891
	- Ярих чадвар-гадаад байдал тоочсон	.785
3.	- Ярих чадвар-нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ	.752
	- Ярих чадвар-холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ	.696
4.	- Утгын ой тогтоолт	.409
	- Үгийн утга тайлбарлах логик чадвар (бодит үг, хийсвэр үг, салаа/ижил утгатай үг)	
	- Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх	
5.	- Ажигч чанар/задлан шинжилж ажиглах	.580
	- Бүхэл бүтнээр хүртэх	.581
	- Анхааралтай, хурдтай ажиллах	.596
	- Богино хугацааны харааны ой-цифр тогтоох	.640
	- Богино хугацааны харааны ой-дүрс тогтоох	.621
	- Богино хугацааны сонорын ой	.642
	- Математик хийсвэр сэтгэхүй	.493
6.	- Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах	.519
	- Үгийг утгаар нь ангилах логик чадвар (бодит үг, хийсвэр үг, салаа/ижил утгатай үг, тэмдэг нэр, нэрлэсэн үг)	.744

Зураг 3. Даалгаврын өгөгдлийн ач холбогдлын түвшний хязгаар (11-17 нас)



Хүснэгт 6. Танин мэдэхүйн даалгаврын найдвартай байдлын коэффициент (11-17нас), Улаанбаатар

дд	Чадамж	Чадвар	Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)	
1.	Анхаарал, Хүртэхүй	- Задлан шинжилж хүртэх/ажигч чанар - Бүхэлд нь хүртэх - Анхаарлын тогтворжилт - Анхаарлын шилжилт - Анхааралтай ажиллах хурд	.679	
2.	Ой тогтоолт	- Богино хугацааны харааны ой-цифр тогтоох чадвар - Богино хугацааны харааны ой-дүрс тогтоох чадвар - Богино хугацааны сонорын ой тогтоолтын чадвар - Утгын ой тогтоолтын чадвар	.883	
3.	Сэтгэхүй	- Математик сэтгэхүйн чадвар	11-14 нас	.918
		- Задлан шинжилж харьцуулах - Харьцуулан нэгтгэх чадвар	15-17 нас	.740
4.	Хэл ярианы чадвар	- Үгийг тайлбарлах логик чадвар - Үгийг нийтлэг шинжээр нь ангилах логик чадвар - Ярих чадвар	.607	


ХОЁРДУГААР БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН 3-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ

2.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН 3-17 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1.1 Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдүүдийн ерөнхий мэдээлэл


Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг, Налайх дүүргийн цэцэрлэгийн 3-5 насны нийт 288 хүүхэд хамрагдсан. Судалгааны үр дүнг бодитой болгох үүднээс нас, хүйсийн тэнцвэртэй байдлаар эрүүл хүүхдүүдийг сонгож санамсаргүй түүврийн арга ашигласан.

Зураг 4. Судалгаанд хамрагдсан цэцэрлэг, хувиар




Улаанбаатар хотын цэцэрлэгүүдийг түүврийн аргаар сонгосон.

Зураг 5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас ба хүйс




Судалгаанд хамрагдаж буй хүүхдүүдийн эцэг эх болон асран хамгаалагчдаас хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжлийн талаар асуулгын аргаар судалгаа авсан.

Зураг 6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг, эх ба асран хамгаалагчид




Хүүхдийн хөгжлийн талаарх асуулгад 68.1 хувь нь эцэг, эх, 16 хувь нь өвөө, эмээ болон ах эгч нар, 14.9 хувь нь хүүхдийн эцэг, эхийг төлөөлөх эрхтэйгээр судалгаанд хамрагдсан байна.

Зураг 7. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ам бүлийн гишүүдийн тоо




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 64.9 хувь нь 4-5 гишүүнтэй гэр бүлд амьдарч байгаа бол 4.1 хувь нь 7 оос дээш гишүүнтэй гэр бүлд амьдарч байна.

Зураг 8. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаж буй жил




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 11.1 хувь нь сургуулийн өмнөх боловсролд эхний жилдээ хамрагдаж буй хүүхүүд, 74.7 хувь нь 2-3 дахь жилдээ хамрагдаж буй бол 14.2 хувь нь 4 дэх жилдээ хамрагдаж буй хүүхдүүд байна.

Зураг 9. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хаана амьдарч буй байдал




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 93.8 хувь нь гэртээ амьдарч буй бол 6.2 хувь нь эмээ, өвөөгийн дөө болон хамаатныдаа амьдарч буй хүүхдүүд байна.

Зураг 10. Судалгаанд хамрагдаж буй хүүхдүүдийн амьдралын нөхцөл




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50.7 хувь нь бохир усны шугамд холбогдоогүй гэр хороололд амьдарч буй хүүхдүүд байгаа ба 39.2 хувь нь орон сууцанд амьдардаг байна.

Зураг 11. Хүүхдүүдийн суралцаж буй цэцэрлэг ба гэр хоорондын зай




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 82.9 хувь нь гэрээсээ 500м-2 км зайд байрлах цэцэрлэгт хамрагддаг байна. Харин 3.5 хувь нь гэрээсээ 5км -ээс илүү хол зайд амьдардаг байна.

Зураг 12. Хүүхдүүдийн эцгийн боловсролын түвшин




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцгийн 50.0 хувь нь дээд боловсролтой, 39.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 5.9 хувь нь тусгай дунд боловсрол эзэмшсэн ба 2.1 хувь нь ямар боловсрол эзэмшсэн эсэхталаар хариулаагүй байна.

Зураг 13. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эхийн боловсролын түвшин




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцгийн 67.0 хувь нь дээд, 26.0 хувь нь бүрэн дунд, 4.9 хувь нь тусгай дунд боловсролтой байна.

Зураг 14. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцгийн ажил эрхлэлт




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцгийн 27.7 хувь нь төсвийн байгууллагад, 22.9 хувь нь хувиараа жижиг бизнес эрхэлдэг бол 4.5 хувь нь тодорхой ажил эрхэлдэггүй байна.

Зураг 15. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гэр бүлийн өрхийн сарын орлого



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 20.9 хувь нь 100,0-700,0 мянга, 54.9 хувь нь 701,0-1.300 мянган төгрөгний орлогтой гэр бүлд амьдарч байна.

Зураг 16. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эхийн ажил эрхлэлтийн байдал




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эхийн ажил эрхлэлтийг авч үзэхэд 23.3 хувь нь төсвийн байгууллагад, 34.4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад 13.2 хувь нь ямар нэг ажил эрхлээгүй, 0.3 хувь нь малчин байна.

Хүүхдийн хөгжлийн талаарх асуулга

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг эх болон асран хамгаалагчдаас асуулгын аргаар хүүхдийн танин мэдэхүйн хөгжил, нийгэмшил, бие бялдрын хөгжлийн талаар асуулга судалгаа авсан болно.

Хүснэгт 7. Санаа бодлоо яриагаар илэрхийлж буй байдал (3-5 нас)



Эцэг эх ба асран хамгаалагчид хүүхдүүд өөрсдийнхөө санаа бодлоо хэл яриагаар 86.8 хувь нь маш сайн, сайн илэрхийлдэг гэж хариулсан байна.


Хүснэгт 8. Өөрийн санаа бодлыг илэрхийлж буй байдал, насаар (3-5 нас)

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	3.1	1.0	0.0
Дундаж	14.6	8.3	12.5
Сайн	52.1	43.8	36.5
Маш сайн	30.2	46.9	51.0

Эцэг эх болон асран хамгаалагчдын хариултыг авч үзэхэд 3 настай хүүхдүүдийн 82.3 хувь нь, 4 настай хүүхдүүдийн 90.7 хувь нь, 87.5 хувь нь өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадвар сайн, маш сайн түвшинд байгаа гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 13.2 хувь нь сул буюу дундаж түвшинд санаагаа илэрхийлэх чадвартай гэж хариулсан байна. Эцэг эх болон асран

хамгаалагчдын хариултаас үзэхэд судалгаанд хамрагдсан хүүхдүүд санааг илэрхийлэн сорил гүйцэтгэх боломжтой байна.

Зураг 17. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох чадвар эцэг, эхийн хариултаар




Судалгаанд хамрагдсан хүүхдүүд баярлаж, уурлаж байгаа гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнийг 93.7 хувь нь сайн, маш сайн ялгаж ойлгодог гэж эцэг, эхчүүд хариулжээ.

Хүснэгт 9. Сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох чадвар, эцэг, эхийн хариулт

	3 нас	4 нас	5 нас
Дундаж	8.3	3.1	7.3
Сайн	55.2	35.4	37.5
Маш сайн	36.5	61.5	55.2

3 насны хүүхдүүдийн 91.7 хувь, 4 насны хүүхдүүдийн 96.1 хувь, 5 насны хүүхдүүдийн 93.7 хувь нь баярлаж хөөрч, уурлаж бухимдаж байгаа сэтгэлийн хөдөлгөөнийг сайн, маш сайн таньж ойлгодог гэж эцэг эхчүүд хариулсан байна.

Зураг 18. Өгсөн зааврын дагуу бие даан тухайн үйлдлийг хийдэг эсэх талаарх эцэг, эхийн хариулт, нийт хүүхдээр




Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 84.8 хувь нь сайн, маш сайн түвшинд өгсөн зааврын дагуу бие даан үйлдлийг хийдэг гэж хариулсан байна.

Хүснэгт 10. Өгсөн зааврын дагуу бие даан тухайн үйлдлийг хийдэг эсэх талаарх эцэг, эхийн хариулт, насаар

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	1.0	2.1	1.0
Дундаж	17.7	13.5	10.4
Сайн	52.1	42.7	47.9
Маш сайн	29.2	41.7	40.6

Судалгаанд хамрагдсан 3 насны хүүхдүүдийн 81.3 хувь, 4 насны хүүхдүүдийн 84.4 хувь, 5 насны хүүхдүүдийн 88.5 хувь нь өгсөн зааврын дагуу бие дааж тухайн үйлдлийг хийдэг гэж эцэг, эх болон асран хамгаалагчид нь хариулсан байна.

Зураг 19. Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг талаарх эцэг, эхийн хариулт, нийт хүүхдээр




Нийт хүүхдийн 34.4 хувь нь өөрийн сонирхож буй зүйлээ дуустал нь маш сайн хийдэг гэж хариулсан байна. Нийт хүүхдүүдийн 21.9 хувь нь дундаж түвшинд буюу хааяа дуусгалгүй орхих тал байдаг байна.

Хүснэгт 11. Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг талаарх хариулт, насаар

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	3.1	0.0	1.0
Дундаж	27.1	14.6	24.0
Сайн	42.7	45.8	38.5
Маш сайн	27.1	39.6	36.5

Судалгаанд хамрагдсан 3 насны хүүхдүүдийн 3.1 хувь нь сонирхсон зүйлээ дуустал нь хийх чадвар сул гэж хариулсан бол 69.8 хувь нь , 4 насны хүүхдүүдийн 85.4 хувь, 5 насангуудыг 74.0 хувь сонирхоод хийж буй зүйлээ дуустал нь хийдэг гэж эцэг, эх болон асран хамгаалагчид хариулсан байна.

Зураг 20. Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал, нийт хүүхдээр




Нийт хүүхдүүдийн 13.2 хувь нь гар шүдээ угаах дадал дундаж түвшинд байгаа бол 86.5 хувь нь өдөр тутам шүдээ, гараа угаах дадал маш сайн төлөвшсөн гэж эцэг, эх асран хамгаалагчид нь хариулсан байна.

Хүснэгт 12. Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал, насаар

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	1.0	0.0	0.0
Дундаж	16.7	11.5	11.5
Сайн	56.3	40.6	52.1
Маш сайн	26.0	47.9	36.5

Хүүхдүүд 3 наснаас гар болон шүдээ угаах дадалтай болсон гэж эцэг, эх, асран хамгаалагчид нь хариулсан байна.

Зураг 21. Халбага, сэрээ, харандааг өөрөө барьдаг байдал, нийт хүүхдээр




Нийт хүүхдүүдийн 94.1 хувь нь өөрөө халбага сэрээгээр хоолоо идэж чаддаг ба үзэг харандаа барьж зурж, бичиж чаддаг гэж эцэг, эх асран хамгаалагчид нь хариулсан байна.

Хүснэгт 13. Халбага, сэрээ, харандааг өөрөө барьдаг байдал, насаар

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	1.0	2.1	0.0
Дундаж	8.3	2.1	4.2
Сайн	52.1	22.9	38.5
Маш сайн	38.5	72.9	57.3

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд 3 наснаас эхлэн харандаа сайн барьж сурсан байна. Энэ нь бидний сорилыг бие дааж гүйцэтгэх боломжтой гэж эцэг, эх асран хамгаалагчдын хариултаас харж болохоор байна.

Зураг 22. Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох чадвар




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг хамтарч тоглох дуртай гэж нийт эцэг, эх асран хамгаалагчид нь хариулсан байна.

Хүснэгт 14. Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох дуртай эсэх, эцэг, эхийн хариултаар

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Сул	1.0	0.0	0.0
Дундаж	6.3	0.0	4.2
Сайн	44.8	30.2	37.5
Маш сайн	47.9	69.8	58.3

Хүүхдүүд 3 наснаас эхлэн 92 хувь нь үеийнхээ хүүхдүүдтэй хамтарч тоглох дуртай болдог байна.

Зураг 23. Саадыг давж гүйх, харайх зэрэг үйлдлийг хэр хийдэг талаарх эцэг, эхийн хариулт



Хүүхдүүдийн бие бялдрын хөгжилтэй холбоотой саадыг давж гүйж, харайх чадвар хийт хүүхдүүдийн 82.3 хувь нь сайн маш амжилттай гүйцэтгэдэг гэж хариулсан нь бие бялдрын сорил гүйцэтгэх боломжтой гэж үзэж болох юм.

Хүснэгт 15. Саадыг давж гүйх, харайх зэрэг үйлдлийг хэр хийдэг талаарх эцэг, эхийн хариулт

Түвшин	3 нас	4 нас	5 нас
Маш сул	1.0	0.0	0.0
Сул	1.0	0.0	0.0
Дундаж	19.8	14.6	16.7
Сайн	53.1	39.6	38.5
Маш сайн	25.0	45.8	44.8

Саад давж гүйх чадвар маш сул ба сул түвшинд 3 насны хүүхдүүдийн 2 хувь нь байгаа бол дундаж түвшинд 3 насны хүүхдүүдийн 19.8 хувь, 4 насны хүүхдүүдийн 14.6 хувь, 5 насны хүүхдүүдийн 16.7 хувь нь дундаж түвшинд гүйцэтгэдэг бол 3 насны хүүхдүүдийн 78.1 хувь, 4 насны хүүхдүүдийн 85.4 хувь нь сайн, маш сайн түвшинд хийж чадна гэж эцэг, эх асран хамгаалагчид хариулсан байна.

Хүснэгт 16. Хүүхдүүдийн ерөнхий мэдээллийн хамаарал

	Амьдралын нөхцөл	Эцгийн боловсрол	Эхийн боловсрол	Эцгийн хөдөлмөр эрхлэлт	Эхийн хөдөлмөр эрхлэлт	Өрхийн сарын орлого
Амьдралын нөхцөл		-.331**	-.244**			-.320**
Эцгийн боловсрол	-.331**		.364**	-.360**		.371**
Эхийн боловсрол	-.244**	.364**		-.171**	-.208**	.242**
Эцгийн хөдөлмөр эрхлэлт		-.360**			.221**	-.267**

Хүүхдүүдийн амьдарч буй өрийн сарын орлого нь эцэг, эхийн боловсрол ба амьдралын нөхцөлтэй холбоотой байна.

Хүснэгт 17. Хүүхдийн хөгжилтэй холбоотой эцэг эхийн хариулт

Өөрийн санаа бодлоо яриагаар хэр илэрхийлдэг	Баярлаж, уурлаж байгаа гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох чадвар	Өгсөн зааврын дагуу бие даан тухайн үйлдлийг хийдэг	Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг	Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал хэр бий болсон	Өөрөө халбага, сэрээ, харандааг хэр барьдаг	Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох дуртай	Саадыг давж гүйх, харайх зэрэг үйлдлийг хэр хийдэг
Өөрийн санаа бодлоо яриагаар хэр илэрхийлдэг	.447**	.388**	.327**	.357**	.354**	.354**	.340**
Баярлаж, уурлаж байгаа гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох чадвар	1	.508**	.405**	.314**	.510**	.437**	.376**
Өгсөн зааврын дагуу тухайн үйлдлийг хийдэг	бие даан	1	.426**	.392**	.501**	.411**	.463**

Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг	1	.443**	.412**	.388**	.329**
Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал хэр бий болсон	1	.435**	.308**	.320**	
Өөрөө халбага, сэрээ, харандааг хэр барьдаг			1	.509**	.368**
Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох дуртай				1	.525**

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).


* . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Хүүхдүүдийн хөгжлийн талаарх хариултууд бүгд хоорондоо хамааралтай байна.

2.1.2. Ерөнхий боловсролын 6-17 насны хүүхдүүдийн ерөнхий мэдээлэл


Судалгаанд ЕБС-д суралцаж буй нийслэлийн 7 дүүргийн 14 сургуулийн нийт 1151 хүүхдээс судалгааг санамсаргүй түүврийн аргаар мэдээлэл цуглуулан хүүхдүүдийг хүйсийн хувьд тэнцвэртэй хамрагдахаар судалгаанд хамруулсан.

Зураг 24. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас, хүйс - хувиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50.4 хувь нь эмэгтэй, 49.6 хувь нь эрэгтэй байна.

Зураг 25. Нийт хүүхдүүдийн амьдарч буй өрхийн ам бүлийн тоо, хувиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 61.4 хувь нь 5 ам бүлээс дээш өрхөд, 35.9 хувь нь 3-4 ам бүлтэй өрхөд амьдардаг байна.

Хүснэгт 18. Нийт хүүхдүүдийн амьдарч буй газар, хувиар

дотуур байранд	таньдаг айлдаа	хамаатан	өвөө эмээгийн дээ	гэртээ
1.2	0.2	1.6	6.3	90.7

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 90.7 хувь нь гэртээ амьдарч байгаа бол 9.3 хувь нь таньдаг айл, хамаатан, эмээ өвөөгийн дөө амьдарч байна.

Хүснэгт 19. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн амьдарч буй нөхцөл, хувиар

<i>гэр хороолол</i>	<i>цэвэр, бохир усны хангамжид холбогдсон гэр хороолол</i>	<i>орон сууц</i>	<i>түрээсийн байр</i>
51.3	11.6	32.5	4.5

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 51.3 хувь нь цэвэр ус, бохир усны хангамжид холбогдоогүй гэр хороололд амьдарч байгаа бол 32.5 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Нийт хүүхдүүдийн 27.4 хувь нь тусдаа өрөөтэй байна.

Хүснэгт 20. Нийт хүүхдүүдийн сургуулиас хэр зайтай амьдарч байгаа байдал, хувиар

<i>5 км дээш</i>	<i>4-5 км</i>	<i>3-4 км</i>	<i>2-3 км</i>	<i>1-2 км</i>	<i>500 м-1 км</i>	<i>500 м</i>
7.7	7.2	5.2	10.8	18.3	28.4	22.3

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ихэнх хувь нь сургуульдаа 500м – 1 км зайнаас алхаж ирдэг бол хамгийн 7 орчим хувь нь сургуулиасаа 5-аас дээш км-ийн зайд амьдарч байна. Нийслэлд амьдарч буй хүүхдүүдийн 50.7 хувь нь сургуулийнхаа ойр хамран тойрох хүрээнд амьдарч суралцдаг байна.

Нийт хүүхдүүдийн 54.3 хувь нь сургуульдаа явган очдог бол 25.9 хувь нь нийтийн тээврээр, 16.7 хувь нь хувийн унаагаар сургуульдаа хүргүүлэн очдог бол 2.2 хувь нь таксигаар явдаг гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 58.4 хувь нь өөрсдийгөө “эрүүл” гэж тодорхойлсон бол 40.8 хувь нь хааяа өвддөг, 0.8 хувь нь “байнга өвддөг” гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 66.3 хувь нь 20-22 цагийн хооронд унтдаг бол 33.7 хувь нь 23- шөнийн 1 цагт унтдаг байна.


Хүснэгт 21. Эцэг эхийн хүүхдэдээ хандах хандлага, хувиар

<i>зоддог</i>	<i>загнадаг</i>	<i>магтдаг</i>	<i>сайн байдаг</i>	<i>урамшуулдаг</i>
0.7	4.9	12.2	67.1	15.2

6-17 насны хүүхдүүдийн 67.1 хувь нь эцэг эх нь хүүхдэдээ сайн ханддаг гэж хариулсан бол 4.9 хувь нь “загнадаг” эсвэл “зоддог” гэж хариулсан байна. Харин багш нар хүүхдүүдтэй харилцахдаа 2.8 хувь нь “загнаж харьцдаг”, 4.4 хувь нь багш “тоодоггүй”, 35.4 хувь нь “үргэлж зөвлөдөг”, 57.3 хувь нь “сайн харилцдаг” гэж хариулсан байна.

Гэрийн даалгавар гүйцэтгэх нь 7.7 хувьд нь хэцүү байдаг гэсэн бол 31.7 хувь нь амархан байдаг, 60.6 хувь нь дунд зэрэг байдаг гэж хариулжээ.

Зураг 26. Хичээлийн бус цагаар зохион байгуулдаг ажилд оролцох байдал, хувиар



Хичээлийн бус цагаар сургуулиас зохион байгуулж буй ажилд хэрхэн оролцдог талаар хүүхдүүдээс асуухад “ямар нэг ажилд огт оролцдоггүй” гэж 11.8 хувь нь хариулсан бол 23.0 хувь нь “сургуулиас зохион байгуулдаг спортын уралдаан тэмцээнд

оролцдог” гэж хариулжээ.

Спортоор хичээллэдэг эсэх талаар асуухад нийт хүүхдүүдийн 52.4 хувь нь “хичээллэдэг” байна. Хүүхдүүд сонгосон спортын төрлөөрөө ихэвчлэн 1-3 жил хичээллэдэг ба цаашид үргэлжлүүлж буй хүүхдүүдийн хувь бага байна.

Хүснэгт 22. Хүүхдүүдийн эцгийн боловсрол эзэмшсэн байдал, хувиар

Боловсрол эзэмшээгүй	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Тусгай мэргэжлийн боловсрол	Дээд боловсрол	байхгүй
14. 0.4	15. 1.5	16. 3.0	17. 50.0	18. 5.1	19. 29.6	20. 10.4

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн эцгийн боловсрол эзэмшсэн байдлыг авч үзэхэд 50.0 хувь нь бүрэн дунд боловсролтой, 29.6 хувь нь дээд боловсролтой, 4.5 хувь нь бага болон суурь боловсрол эзэмшсэн байгаа ба 0.4хувь нь ямар нэг боловсрол эзэмшээгүй байгаа нь бага хувьтай байна. Мөн нийт хүүхэд, залуучуудын 10.4 хувь нь эцэггүй буюу эзэмшсэн боловсролын түвшинг нь мэдэхгүй байсан.

Хүснэгт 23. Хүүхдүүдийн эхийн боловсрол эзэмшсэн байдал, хувиар

Боловсрол эзэмшээгүй	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Тусгай мэргэжлийн боловсрол	Дээд боловсрол	байхгүй
0.1	0.8	3.0	47.0	6.3	41.2	1.7

Нийт хүүхдүүдийн эхийн 88.2 хувь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсрол эзэмшсэн бол 0.1 хувь нь ямар нэг боловсрол эзэмшээгүй гэсэн нь эцгийн боловсрол эзэмшээгүй гэсэн хувиас бага байгаа нь эмэгтэйчүүдийг ямар нэг боловсролын түвшинд хамруулан сургадаг байсантай холбоотой байж болох юм.

Хүснэгт 24. Хүүхдүүдийн эцгийн ажил эрхлэлт, хувиар

ажилгүй	тэтгэвэрт	хувиараа жижиг бизнес эрхэлдэг	хувийн хэвшлийн байгууллагад	малчин	төсвийн байгууллагад	гадаадад	байхгүй
4.3	0.7	29.6	30.0	3.1	17.0	2.9	12.4


Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн эцгийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд төсвийн байгууллагад 17 хувь нь ажилладаг, 29.6 хувь нь хувиараа ямар нэг жижиг бизнес эрхэлдэг бол 4.3 хувь нь ямар нэг ажил эрхэлдэггүй байна.

Хүснэгт 25. Хүүхдүүдийн эхийн ажил эрхлэлт, хувиар

ажилгүй	тэтгэвэрт	хувиараа жижиг бизнес эрхэлдэг	хувийн хэвшлийн байгууллагад	малчин	төсвийн байгууллагад	гадаадад	байхгүй
14.8	1.3	24.1	28.4	2.3	22.7	2.5	3.9

Нийт хүүхдүүдийн эхийн ажил эрхлэлтийн байдлыг үзэхэд хувиараа жижиг бизнес эрхэлдэг 24.1 хувь, төсвийн байгууллагад 22.7 хувь нь ажилладаг бол ямар нэг ажил хийдэггүй 14.8 хувь байгаа нь өндөр хувьтай байна. Эцэг эхийн гадаадад ажиллаж байгаа хувь нь бараг адилхан 2.7 хувь байна.

Зураг 27. Өрхийн сарын орлого, хувиар



Нийт хүүхдүүдийн 67.1 хувь нь 900.0 мянга хүртэл төгрөгийн орлоготой гэр бүлд амьдарч байгаа ба 32.9 хувь нь сардаа 901.0 мянгаас дээш төгрөгийн орлоготой гэр бүлд амьдарч байна.

2.1.3. Дүгнэлт

СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийн хувьд:


- Нийт хүүхдүүдийн 64.9 хувь нь 4-5 ам бүлтэй өрхөд амьдардаг байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 11.1 хувь нь СӨБ -д эхний жилдээ хамрагдаж буй хүүхүүд, 74.7 хувь нь 2-3 дахь жилдээ хамрагдаж буй бол 14.2 хувь нь 4 дэх жилдээ хамрагдаж буй хүүхдүүд байна.

- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50.7 хувь нь цэвэр бохир усны системд холбогдоогүй гэр хороололд, 39.2 хувь нь орон сууцанд амьдарч байна.
 - СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийн 82.9 хувь нь цэцэрлэгээсээ 500м–2 км зайтай газар амьдарч байна.
 - Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн эхийн боловсролын түвшинг авч үзвэл 39.6 хувь нь бүрэн дунд, 50.0 хувь нь дээд боловсролтой, төсвийн байгууллагад 23.3 хувь нь, 0.3 хувь нь малчин байна.
 - Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн эцгийн боловсролын түвшинг авч үзвэл 39.0 хувь нь бүрэн дунд, 67.0 хувь нь дээд боловсролтой, 22.9 хувь нь хувиараа жижиг бизнес эрхэлдэг, 34.4 хувь нь хувийн хэвшилд, 13.2 хувь нь ямар нэг ажил эрхлээгүй байна.
 - Хүүхдүүдийн 11.8 хувь нь 1.500.000 аас дээш орлогтой гэр бүлд, 4.2 хувь нь 100.000-300.000 мянган төгрөгний сарын орлогтой гэр бүлд амьдарч байна.
 - Судалгаанд хамрагдсан 3 насны хүүхдүүдийн хувьд 82.3 хувь нь өөрийн санаа бодлоо хэл ярианы тусламжтай илэрхийлэх, 91.7 хувь нь сэтгэлийн хөдөлгөөнийг таних, 81.3 хувь нь өгсөн зааврын дагуу бие дааж ажиллах чадвартай, 69.8 хувь нь сонирхоод эхэлсэн зүйлээ дуустал хийх чадвартай, 82.3 хувь нь шүд гараа угаах дадалтай болсон, 90.6 хувь нь халбага, харандаа өөрөө барих чадвартай гэж эцэг эх, асран хамгаалагчид нь хариулсан байна. Бусад насанд энэ чадварууд нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байна.
 - Бие бялдрын хөгжлийн хувьд саадыг давж гүйж харайх үйлдлийг 3 насны хүүхдүүдийн 78.1 хувь нь, 4 насны хүүхдүүдийн 85.4 хувь нь, 5 насны хүүхдүүдийн 83.3 хувь нь амжилттай хийж чадна гэж эцэг эх, асран хамгаалагчид нь хариулсан байна.
 - Эцэг эх болон асран хамгаалагчдын хариултаас судалгаанд оролцож буй хүүхдүүд бие даан танин мэдэхүйн даалгавар гүйцэтгэх болон бие бялдрын сорил гүйцэтгэх боломжтой гэж үзэж болох юм
21. ЕБС-д суралцаж буй хүүхдүүдийн хувьд:
- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50.4 хувь нь эмэгтэй, 49.6 хувь нь эрэгтэй байна.
 - Хүүхдүүдийн 61.4 хувь нь таваас дээш ам бүлтэй өрхөд амьдардаг байна.
 - Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 90.7 хувь нь гэртээ амьдарч байгаа бол таньдаг айл, хамаатан, эмээ өвөөгнийндөө 8.1 хувь нь сургуулийн дотуур байранд 1.2 хувь нь амьдарч байна.

- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 51.3 хувь нь цэвэр ус, халуун хүйтэн усанд холбогдоогүй гэр хороололд амьдарч байгаа бол нийт хүүхдүүдийн 32.5 хувь нь орон сууцанд амьдардаг байна.
- Нийт хүүхдүүдийн 25.9 хувь нь нийтийн тээврээр, 16.7 хувь нь хувийн унаагаар сургуульдаа хүргүүлдэг байна.
- Нийт хүүхдүүдийн 52.4 хувь нь спортын ямар нэг төрөлөөр хичээллэдэг буюу голчлон багийн спортоор хичээллэдэг байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эхийн боловсролын түвшин өндөр байна.
- Нийт хүүхдүүдийн 67.1 хувь нь 900,0 мянга хүртэл төгрөгийн орлоготой гэр бүлд амьдарч байна

2.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН 3-17 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ

Хүний бие бялдрын хөгжлийг биеийн ерөнхий өсөлт хөгжил, бие бялдрын бэлтгэлжилтийн байдал гэсэн хоёр үндсэн хэлбэрээр авдаг. Бид энэхүү судалгаагаар хүүхдийн бие бялдрын ерөнхий хөгжлийг биеийн өндөр, биеийн жин, толгойн болон цээжний тойрог хэмжих хэмжилтийн аргаар, бүсэлхийн тойрог; бэлтгэлжилтийг хурд, хүч, уян хатан, авхаалж самбаа, тэсвэрийн чанарыг хугацаагаар хэмжиж тодорхойлсон.



2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн бие бялдрын ерөнхий хөгжлийн онцлог

Биеийн жин


Хэмжих нэгж нь килограмм буюу (кг) бөгөөд хүүхдийг жинг хэмжигч багаж ашиглан хэмжилтийг 0.1 гр-ын нарийвчлалтай хийсэн.

Хүснэгт 26. Охид, хөвгүүдийн биеийн жингийн статистик үзүүлэлт (3-5 нас)

нас	Mean	Range	Maximum	Minimum	Std. Deviation
Хөвгүүд					
3 нас	15.6	12.1	24.1	12.0	2.4
4 нас	17.3	11.5	24.0	12.5	2.2
5 нас	19.4	10.2	25.0	14.8	2.3
Охид					
3 нас	15.7	9.5	21.0	11.5	2.2
4 нас	16.3	6.9	20.4	13.5	1.4
5 нас	18.8	12.0	25.0	13.0	2.6

Гурван насанд охидын биеийн жингийн хамгийн бага үзүүлэлт 11.5кг, хамгийн өндөр үзүүлэлт 21.0 кг байна. Стандарт хазайлт 2.2 байна. Хөвгүүдийн хувьд хамгийн их үзүүлэлт 24.1 кг, хамгийн бага үзүүлэлт 12.0 кг байна.

Зураг 28. Охид, хөвгүүдийн биеийн жингийн үзүүлэлт, кг (3-5 нас)



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн биеийн жин нас нэмэгдэх тусам нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь физиологийн өсөлтийн дагуу хөгжил явагдаж байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 27. Охид, хөвгүүдийн биеийн жингийн индекс, насаар (3-5 нас)

	Хөвгүүд	БЖИ	Охид	БЖИ
3 нас	15.7	Хэвийн	15.8	Хэвийн
4 нас	15.2	Хэвийн	14.8	Хэвийн
5 нас	15.0	Хэвийн	14.8	Хэвийн

Биеийн жингийн индекс хэвийн байна.


Бүсэлхийн тойрог

Хэмжих нэгж нь сантиметр (см) бөгөөд хэмжилтийг 0.1 см-ын нарийвчлалтай хийсэн.

Хүснэгт 28. Охид, хөвгүүдийн бүсэлхийн тойргийн статистик үзүүлэлт, насаар (3-5 нас)

Нас	Mean	Range	Minimum	Maximum	Std. Deviation
Хөвгүүд					
3 нас	50.646	12.0	46.0	58.0	2.7771
4 нас	51.740	12.0	47.0	59.0	2.9191
5 нас	53.229	17.5	46.0	63.5	3.2681
Охид					
3 нас	51.167	12.0	45.0	57.0	2.7969
4 нас	50.217	14.0	43.0	57.0	2.7898
5 нас	52.302	15.0	46.0	61.0	3.1382

Зураг 29. Охид, хөвгүүдийн бүсэлхийн тойрог, см (3-5 нас)



Хөвгүүдийн бүсэлхийн тойрог нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байна. Охидын хувьд 4 насанд 1 см-ээр буурсан 5 насанд 2 см-ээр нэмэгдсэн байна.

Цээжний тойрог


Хүүхдийн цээжний тойргийг хулдаасан метр ашиглан 1 мм-ийн нарийвчлалтайгаар хэмжсэн.

Хүснэгт 29. Охид, хөвгүүдийн цээжний тойргийн статистик үзүүлэлт, насаар (3-5 нас)

Нас	Mean	Range	Minimum	Maximum	Std. Deviation
Хөвгүүд					
3 нас	53.192	13.0	47.0	60.0	2.4020
4 нас	55.250	10.0	50.0	60.0	2.4925
5 нас	56.573	11.0	51.0	62.0	2.4689
Охид					
3 нас	53.677	10.0	48.0	58.0	2.5275
4 нас	53.438	10.0	48.0	58.0	2.1354
5 нас	55.698	14.0	49.0	63.0	2.8727

Гурван насанд охидын цээжний тойрог хамгийн бага үзүүлэлт 50.3 см, хамгийн өндөр үзүүлэлт 58.0 см байна. Стандарт хазайлт 2.11 байна.

Хүснэгт 30. Охид, хөвгүүдийн цээжний тойрог, насаар, см (3-5 нас)



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн цээжний тойрог нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байна.

Биеийн өндөр


Хэмжих нэгж нь сантиметр буюу (см) бөгөөд хүүхдийг өндрийг өндөр хэмжигч багаж ашиглан хэмжилтийг 0.1 см-ийн нарийвчлалтай авсан.

Хүснэгт 31. Охид, хөвгүүдийн биеийн өндрийн статистик үзүүлэлт, насаар (3-5 нас)

Нас	Mean	Range	Minimum	Maximum	Std. Deviation
Хөвгүүд					
3 нас	99.7	23.7	93.0	116.7	4.7
4 нас	106.9	23.4	96.0	119.4	4.7
5 нас	113.8	14.5	106.0	120.5	3.7
Охид					
3 нас	99.7	20.7	90.0	110.7	4.3
4 нас	104.8	13.6	98.5	112.1	3.2
5 нас	112.8	17.7	105.5	123.2	4.4

Гурваас таван насанд охидын биеийн өндөр хамгийн бага үзүүлэлт 3 насанд 99.7 см, хамгийн өндөр үзүүлэлт 110.7 см байгаа бол 5 насанд 112.8 см, хамгийн өндөр үзүүлэлт 123.2 см байна.

Зураг 30. Охид, хөвгүүдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт, см (3-5 нас)



Гурваас таван насанд охидын биеийн өндөр 3-4 насанд 5.1 см, хөвгүүд 7.2 см, 4-5 насанд охид 8.0 см, хөвгүүд 6.9 см өссөн байна. Энэ нь физиологийн өсөлт хөгжлийн дагуу явагдаж байгааг харуулж байна.

Толгойн тойрог

Хүүхдийн толгойн тойргийг хулдаасан метр ашиглан хэмжсэн бөгөөд 1 мм-ийн нарийвчлалтайгаар хэмжсэн.

Хүснэгт 32. Охид, хөвгүүдийн толгойн тойргийн статистик үзүүлэлт, насаар (3-5 нас)

	Mean	Range	Minimum	Maximum	Std. Deviation
<i>Нас</i>				<i>Хөвгүүд</i>	
3 нас	50.2	7.0	47.0	54.0	1.43392
4 нас	51.1	5.0	49.0	54.0	1.15772
5 нас	51.8	6.0	49.0	55.0	1.28824
				<i>Охид</i>	
3 нас	50.3	8.0	46.0	54.0	1.40675
4 нас	50.8	6.0	47.0	53.0	1.26529
5 нас	51.3	8.0	47.0	55.0	1.70998

Хүүхдүүдийн толгойн тойрогийн хэмжээ нас нэмэгдэх бүрд өссөн үзүүлэлттэй байна. Энэ насанд физиологийн өөрчлөлтүүд эрчимтэй явагддаг үе бөгөөд анатоми, физиологийн онцлогоос авч үзвэл: хүүхдийн тархины хэмжээ 5 насанд хүрхэд жингийн хувьд насанд хүрсэн хүнийхтэй бараг тэнцүү болж тархины мушгиралт ба ховилын хөгжил маш эрчимтэй явагддаг байна.

Зураг 31. Охид хөвгүүдийн толгойн тойргийн дундаж үзүүлэлт, насаар (3-5 нас)



Хүүхдүүдийн толгойн тойрог нас нэмэгдэх тусам 1см-1.7 см-ээр нэмэгдсэн байна.

Дүгнэлт

Бие бялдрын хөгжлийн бие бялдрын ерөнхий хөгжлийн хувьд: Биеийн өндөр, биеийн жин гэх мэт үзүүлэлтээс гадна хурд, хүч, авхаалж самбаа гэх мэт чанаруудын хөгжлийг хэмжилт хийж дундаж үзүүлэлт болон өсөлтийг хэмжиж үзлээ.

- Гурван насанд охидын биеийн жингийн хамгийн бага үзүүлэлт 11.5кг, хамгийн өндөр үзүүлэлт 21.0кг байна. Хөвгүүдийн хувьд хамгийн их үзүүлэлт 24.1 кг, хамгийн бага үзүүлэлэлт 12.0 кг байна.
- 3-5 насны хүүхдүүдийн биеийн жингийн индекс хувьд хэвийн хэмжээнд байна.

- Хөвгүүдийн бүсэлхийн тойрог охидын хувьд 4 насанд 1см ээр буурсан ч 5 насанд 2 см ээр нэмэгдсэн мөн цээжний тойрог нас нэмэгдэх тусам нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
- Гурваас таван насанд охидын биеийн өндрийн хамгийн бага үзүүлэлт 3 насанд 99.7 см, хамгийн өндөр үзүүлэлт 110.7 см байгаа бол 5 насанд 112.8 см, хамгийн өндөр үзүүлэлт 123.2 см байна. Хүүхдүүдийн биеийн өндрийн үзүүлэлт харилцан ялгаа ихтэй байна.
- Хүүхдүүдийн толгойн тойрогийн хэмжээ нас нэмэгдэх бүрд өссөн үзүүлэлттэй байна. Энэ насанд физиологийн өөрчлөлтүүд эрчимтэй явагддаг үе бөгөөд анатоми, физиологийн онцлогоос авч үзвэл: 5 насанд хүүхдийн тархины хэмжээ жингийн хувьд насанд хүрсэн хүнийхтэй бараг тэнцүү болж, тархины мушгиралт, ховилын хөгжил эрчимтэй явагддаг байна.
- Хүүхдүүдийн тэнцвэрийн чанар нас нэмэгдэх тусам сайжирдаг ба 5 насанд нэг хөл дээрээ тэнцвэрээ олж хадгалан тогтвортой зогсож чаддаг болдог байна.

2.2.2 Ерөнхий боловсролын 6-17 насны хүүхдийн бие бялдрын ерөнхий хөгжлийн онцлог

Охид, хөвгүүдийн бие бялдрын өсөлт, хөгжлийг судлан харьцуулж байх нь тэдний өсөлт, хөгжлийн хурдцыг тогтоохоос гадна тэдэнд тохирсон стандарт боловсруулах үндэслэл болдог.

Бие бялдрын хөгжлийг биеийн өндөр (см), биеийн жин (кг), толгойн тойрог (см), гарын атгах хүч (кг)-ний үзүүлэлтүүдээр хэмжив.

Биеийн өндөр (см)

Хүүхдийг зурагт тайван, номхон зогсоогоод шалнаас толгойн оройн цэг хүртэл 0.01 см-ийн нарийвчлалтайгаар хэмжив.


Хүснэгт 33. Охид, хөвгүүдийн биеийн өндрийн статистик үзүүлэлтүүд, насаар (6-17 нас)

	Mean	95% Confidence Interval for Mean		Median	Variance	Std. Deviation	Minimum	Maximum	Range	Std. Error
		Lower Bound	Upper Bound							
Охид										
6 нас	116.5	115.3	117.7	117.0	17.2	4.1	108.5	125.5	17.0	0.6
7 нас	120.7	119.3	122.1	120.8	23.2	4.8	109.1	128.1	19.0	0.7
8 нас	126.9	125.4	128.4	126.5	25.8	5.1	113.2	143.0	29.8	0.7
9 нас	133.0	130.9	135.1	132.8	52.4	7.2	113.8	146.4	32.6	1.0
10 нас	139.6	137.1	142.1	137.2	73.7	8.6	124.4	172.8	48.4	1.2
11 нас	145.5	143.1	147.9	147.8	65.3	8.1	126.0	161.0	35.0	1.2
12 нас	151.1	149.2	152.9	151.1	39.3	6.3	137.5	166.0	28.5	0.9
13 нас	156.1	154.6	157.6	156.0	26.8	5.2	143.8	168.0	24.2	0.7
14 нас	157.9	156.3	159.5	157.5	29.6	5.4	148.0	170.0	22.0	0.8

15 нас	158.8	157.2	160.3	159.1	27.6	5.3	145.9	168.8	22.9	0.8
16 нас	158.6	156.8	160.5	157.3	38.3	6.2	149.0	173.3	24.3	0.9
17 нас	159.9	158.0	161.7	158.5	40.7	6.4	146.5	176.4	29.9	0.9
Хөвгүүд										
6 нас	117.0	115.7	118.2	117.1	18.7	4.3	107.0	125.7	18.7	0.6
- 11-14 насны хүүхдүүдийн цифр хараад тогтоох чадвар нь дүрс хараад тогтоох чадвартай харьцуулахад доогуур байна. Хүүхдүүдэд ямар нэгэн дүрсийг хараад тогтооход хялбар байдаг байна. Цифр хараад тогтоох нь танин мэдэхүйн хийсвэрлэлийг тодорхой түвшинд шаарддаг тул тэдний танин мэдэхүйн хөгжилд бодит үйл тодорхой байр суурь эзэлдэгтэй холбоотой байх бүрэн боломжтой. Хүүхдүүд цифрийг богино хугацаанд хараад 5-6-г тогтоодог бол дүрсийг хараад 9-10 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг байна. Нас нэмэгдэх тусам богино хугацаанд мэдээллийг хараад тогтоох чадвар нэмэгдэдг байна.
- 15-17 насанд хүүхдүүдийн цифр тогтоох чадвар хэвийн дундаж түвшинд байгаа ба тэд богино хугацаанд 7 цифрийг хараад тогтоож чаддаг байна. Харин хүүхдүүдийн хувьд 12 хүртэлх энгийн дүрсийг тогтоох чадвартай байна. Богино хугацааны харааны ой тогтоолтын чадвар нь өмнөх суурь боловсролын түвшнээс ахисан үзүүлэлт байна. Энэ нь танин мэдэхүйд хийсвэрлэл давамгайлдагтай шууд холбоотой. Хараад мэдээллийг тогтооход дэс дараалал чухал нөлөөтэй байдаг байна. Эхэнд байгаа зүйлийг илүү сайн тогтоодог нь ажиглагдлаа.
- 11-14 насанд хүүхдүүдийн үгийг сонсоод тогтоох нь хэвийн дундаж түвшинд байна. Хүүхдүүд сонсоод сэргээн санах үгийн тоо нь дунджаар 6-7 байна. 15-17

насанд 7-8 үг болж өсжээ. Сонсоод мэдээллийг тогтооход эхний болон сүүлийн үгсийг илүү сайн сэргээн санадаг зүй тогтол харагдлаа.

- Мэдээллийг утгачлан тогтоох чадварын хувьд 11-17 насны хүүхдүүд нарийн үйл явдал бүхий, байнга хэрэглэдэггүй үг орсон 17-23 хүртэлх утгын нэгжийг тогтоож сэргээн санадаг байна. Ахлах ангид байнга хэрэглэдэггүй үг орсон утга, хийсвэр утгыг тогтоож сэргээн санах нь сайжирдаг аж. Энэ нь тэдний танин мэдэхүйд хийсвэр шинж давамгайлж, үгийн нөөц сайжирдагтай холбоотой юм.

Ерөнхий боловсролын 11-17 насны хүүхдийн сэтгэхүй, хэл ярианы чадвар

11-17 насны хүүхдийн сэтгэхүй, хэл ярианы чадварыг сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах үйлдэл, сэтгэхүйн харьцуулан нэгтгэн дүгнэх үйлдэл, хийсвэр сэтгэхүй, үгийн утга тайлбарлах, бүлэглэх, ярих чадварын хүрээнд судаллаа.

Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах үйлдэл (11-17 нас)


Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах үйлдлийг 11-14 насанд энгийн шинжээр нь харьцуулах, 15-17 насанд дотоод мөн чанар, учир шалтгаанд нь харьцуулах даалгавраар судаллаа.

А. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар (11-17 нас)

11-14 нас. Суурь боловсролын 11-14 насны хүүхдийн сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар нь дунджаас дээш түвшинд байна ($M=3.46$).

Даалгаврын гүйцэтгэл тус бүрээр авч үзэхэд, энгийн хялбар шинж тэмдгээр нь задлан шинжилж харьцуулах чадвар жигд байна, ижил шинж, эсрэг шинж, хэрэглээ зориулалт зэргээр нь задлан шинжилж харьцуулах нь сайн байна.

Зураг 105. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас)



11-14 насны хүүхдийн сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар нь тэдний насны ялгаанаас хамаарсан өөрчлөлт алга байна.

Хүснэгт 161. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадварын статистик үзүүлэлт, насаар (11-14 нас)


Нас	Mean	N	Std. Deviation	Std. Error of Mean
11 нас	3.30	96	1.224	.125
12 нас	3.42	96	1.063	.108
13 нас	3.44	96	1.168	.119
14 нас	3.70	96	1.144	.117
Нийт	3.46	384	1.156	.059

15-17 нас. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадварыг бүрэн дунд боловсролын 15-17 насанд үзэгдэл юмсыг дотоод харьцаа холбоонд нь харьцуулах аргаар судаллаа.

Даалгаврын гүйцэтгэлээр авч үзэхэд, 15-17 насны хүүхдүүдийн юмс үзэгдлийг дотоод харьцаа холбоо мөн чанараар нь задлан шинжилж харьцуулах чадвар сул түвшинд байна (M=1.76).

Зургаас харахад, хүүхдүүд юмсын дотоод мөн чанарыг таньж эсрэг шинжээр нь харьцуулах нь харьцангуй илүү, харин төрөл зүйлийн харьцаа, бүтэц, бүрэлдэхүүн, учир шалтгаан-үр дагаварын холбоо, ижил шинжийг нь таньж харьцуулах нь харьцангуй сул байна.

Зураг 106. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (15-17 нас)



31.

Даалгаврын гүйцэтгэл нь наснаас хамаарсан ач холбогдолтой ялгаа алга байна.

Хүснэгт 162. Сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах чадварын статистик үзүүлэлт, насаар (15-17 нас)

Нас	Mean	N	Std. Deviation	Std. Error of Mean
15 нас	1.72	96	.660	.067
16 нас	1.83	96	.627	.064
17 нас	1.72	96	.593	.061
Нийт	1.76	288	.627	.037

Б. Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар (11-17 нас)

11-14 нас. Суурь боловсролын түвшний хүүхдүүдийн сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар нь дунджаас доогуур түвшинд байна ($M=2.5$). Өмнөх 8-10 насны хүүхдүүдийн чадвараас өссөн үзүүлэлттэй байна.

Даалгаврын гүйцэтгэлээр нь үзэхэд, гадаад шинжээр нь харьцуулах, юмсыг түүний үзүүлж байгаа үйлдэл нөлөөллөөр нь нэгтгэх нь илүү байна.

Хүснэгт 163. Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас)

№	Даалгавар	Хариулт	
		Гадаад шинж, үзүүлэх үйлдэлд тулгуурласан	Гол мөн чанарт тулгуурласан
1.	Хөлөөрөө явдаг, гараараа ...	94.5	
2.	Хөвгүүд өсөөд аав шигээ том болно, охид өсөөд...	85.2	
3.	Хутга, хайч хоёр хоёулаа.. ...	83.8	
4.	Хулгана, муур хоёр хоёулаа ...	7.3	60.7
5.	Ундаа, ус хоёр хоёулаа ...	13.5	72.1
6.	Төгөлдөр хуур, хийл ...	8.6	74
7.	Цас, бороо 2 хоёулаа...	32.3	41.9
8.	Килограмм, метр 2 хоёулаа ...	17.4	49.7
9.	Шанага, хоолны сав хоёрын төсөөтэй тал нь	33.3	14.3
10.	Уул, нуур хоёрын төсөөтэй тал нь ...	13	23.7
11.	Давс, ус хоёрын төсөөтэй тал нь ...	21.1	3.6
12.	Эрх чөлөө, шударга ёсны төсөөтэй тал нь ...	13	0.5
13.	Эхний, сүүлчийн гэдэг үгийн төсөөтэй тал нь ...	8.1	3.1
14.	49; 121 ...	7.3	1.6

11-14 насны хүүхдүүдийн хувьд юмсыг ижил төстэй нийтлэг шинжээр нь харьцуулан нэгтгэх сэтгэхүйн логик чадвар нь сэтгэхүйн задлан шинжлэх чадвартай харьцуулахад сул байна.

15-17 нас. Бүрэн дунд боловсролын түвшинд хүүхдүүдийн сэтгэхүйн харьцуулан нэгтгэн дүгнэх чадварыг хос үгийн нийтлэг шинжийг харьцуулан таньж нэгтгэх аргаар судаллаа.

15-17 насны хүүхдүүдийн сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар дундаж түвшинд байна ($M=3.01$).

Хүснэгтээс харахад, хүүхдүүд гадаад шинж чанар дээр тулгуурлан хүчин чармайлт бага шаардсан даалгаврыг гол шинжээр нь оновчтой нэгтгэн дүгнэж чадсан байна. Харин дотоод шинж чанарт нь тулгуурлан нэгтгэх даалгаврыг хүүхдүүдийн цөөнгүй нь нь илэрхийлж буй үзэгдэл юмсынх нь гадаад шинж үзүүлэх нөлөөгөөр нь

нэгтгэсэн бол нэлээд нь гол шинжээр нь нэгтгэж чадсан байна. Харин мэдлэгт тулгуурлан нэгтгэх даалгаврыг хүүхдүүдийн цөөнгүй хувь нь гол шинжээр нь бус харин гадаад шинж үзүүлэх нөлөөллөөр нь нэгтгэсэн дүр зураг харагдаж байна. Хүүхдүүд үзэгдэл юмсын шинж чанарыг харьцуулан нэгтгэхдээ гол шинжээр нь оновчтой нэгтгэхээс гадна гадаад шинж, үзүүлэх үйлдэл нөлөөлөлд тулгуурлан өнгөцхөн хандах тал ажиглагдаж байна.

Хүснэгт 164. Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (15-17 нас)

№	Даалгавар	Хариулт	
		Гадаад шинж, үзүүлэх үйлдэлд тулгуурласан	Гол мөн чанарт тулгуурласан
1.	Нохой-арслан	10.4	81.3
2.	Сүх-хөрөө	42.7	47.2
3.	Жүрж-гадил/банана	12.2	84.4
4.	Ширээ-сандаг	38.2	35.4
5.	Хойд-баруун	3.5	89.2
6.	Шүлэг-өгүүллэг	35.4	35.1
7.	Агаар- ус	18.4	57.3
8.	Нүд-чих	47.2	40.3
9.	Урамшуулал-шийтгэл	26	12.5
10.	Өндөг- үр тариа	37.5	8.3
11.	Шумуул –мод	15.6	30.2
12.	Мод-нүүрс	71.5	3.1

Хүүхдүүдийн сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар нь наснаас хамаарсан статистик ач холбогдолтой ялгаа алга байна.

Хүснэгт 165. Сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадварын статистик үзүүлэлт, насаар (15-17 нас)


Нас	Mean	N	Std. Deviation	Std. Error of Mean
15 нас	2.82	96	.754	.077
16 нас	3.10	96	.607	.062
17 нас	3.10	96	.732	.075
Нийт	3.01	288	.711	.042

В. Математик сэтгэхүйн чадвар (11-17нас)

11-14 нас: Математик сэтгэхүйн чадварыг тооны үйлдэл бүхий даалгавар гүйцэтгэх аргаар судалсан. Хүүхдүүдийн математик сэтгэхүйн чадвар нь дунджаас дээш түвшинд байна (M=3.5).

Даалгаврын гүйцэтгэлээс харахад, хүүхдүүдийн тоон үйлдэл хийх чадварын хувьд хүүхдүүд юмсыг нарийн учир шалтгаанд нь тооцоолох чадвар сул байна.

Зураг 107. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (11-14 нас)



Математик сэтгэхүйн чадвар ба насны хооронд ач холбогдолтой ялгаа байхгүй боловч нас нэмэгдэхэд хүүхдүүдийн математик сэтгэхүйн чадвар аажмаар сайжирсан байна.


Даалгавар нэг бүрийн гүйцэтгэлийн хувьд, насны ялгааг авч үзэхэд, учир шалтгаанд нь ойлгож тооцоолох чадвар хөгжих чадвар нас нэмэгдэхэд аажмаар хөгжиж байдаг байна.

Хүснэгт 166. Математик сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт, насаар (11-14 нас)

Нас	Mean	N	Std. Deviation	Std. Error of Mean
11 нас	3.42	96	.660	.067
12 нас	3.45	96	.663	.068
13 нас	3.54	96	.679	.069
14 нас	3.55	96	.578	.059
Нийт	3.49	384	.646	.033


Даалгавар нэг бүрийн гүйцэтгэлийн хувьд, насны ялгааг авч үзэхэд, учир шалтгаанд нь ойлгож тооцоолох чадвар хөгжих чадвар нас нэмэгдэхэд аажмаар хөгжиж байдаг байна.

Зураг 108. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, насаар (11-14 нас)



15-17 нас: Математик сэтгэхүйн чадвар нь дундаж түвшинд байна (M=3.36). Даалгаврын гүйцэтгэлийг авч үзэхэд, нарийн учир шалтгаанд нь юмсыг сэтгэх чадвар нь харьцангуй сул байна.

Зураг 109. Математик сэтгэхүйн чадвар, даалгаврын гүйцэтгэлээр, хувиар (15-17 нас)



15-17 насны хүүхдүүдийн математик тооцоолол хийх сэтгэхүйн чадвар нь наснаас хамаарсан ялгаатай үзүүлэлттэй байна ($p < .01$).

Хүснэгт 167. Математик сэтгэхүйн чадварын наснаас хамаарсан статистик ялгаа (15-17 нас)

ANOVA					
	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Between Groups	6.872	2	3.436	6.596	.001
Within Groups	296.950	570	.521		
Total	303.822	572			

Хүснэгт 168. Математик сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт, насаар (15-17 нас)

Сурагчдын нас	Mean	N	Std. Deviation	Std. Error of Mean
15 нас	3.25	96	.665	.068
16 нас	3.27	96	.624	.064
17 нас	3.55	96	.663	.068
Нийт	3.36	288	.663	.039

Хэл ярианы чадвар (11-17 нас)

Хүүхдийн хэл ярианы чадварыг үгийн утгыг ойлгож тайлбарлах, үгийн нийтлэг шинжийг нь таньж ангилах логик чадвар, ярих чадварыг илрүүлэх хүрээнд судаллаа.

А. Үг тайлбарлах чадвар (11-17нас)

11-14 насанд бодит болон хийсвэр үгийн утгыг тайлбарлах логик чадвар нь дундаж ($M=3.15$; $M=3.09$), харин салаа утгатай үгийг тайлбарлах чадвар нь дунджаас доогуур түвшинд байна ($M=2.58$).

15-17 насны хүүхдүүдийн хувьд тухайн чадвар нь нэмэгдэж, бодит, хийсвэр утгатай үгийг тайлбарлах нь сайн ($M=3.7$; $M=3.71$), салаа/ижил утгатай үгийг тайлбарлах нь дундаж түвшинд байна ($M=2.96$).

Даалгаврын гүйцэтгэлээр авч үзэхэд, 11-14 насны хүүхдүүд үгийг гадаад шинж чанар/үзүүлэх нөлөөллийг нь тоочиж тайлбарлах нь илүү бол 15-17 насанд мөн чанараар тайлбарлах нь илүү байдаг байна.

Зураг 110. Үгийн утгыг гадаад шинж, илэрхийлж буй юмсын үйлдэл нөлөөллөөр нь тайлбарлах, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас)



Зураг 111. Үгийн утгыг гол шинжээр нь тайлбарлах, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас)



Үгийн утга тайлбарлах логик чадвар нь наснаас хамаарсан ялгаатай үзүүлэлттэй байна. ($p < .01$) Үгийн утга тайлбарлах чадвар нь 13, 15, 17 насанд тухайн чадвар сайжирсан үр дүн харагдаж байна.

15-17 насны хүүхдүүдийн хувьд үгийн утгыг утгыг тайлбарлах логик чадвар өндөр. Харин 11-14 насанд тухайн чадвар хөгжиж байдаг ба хэвийн түвшинд байгаа тул түүнийг цааш нь дэмжих нь чухал байна.

Ийнхүү 15-17 насанд үгийн утгыг тодорхойлох логик чадвар өндөр байгаа нь тэдний хийсвэр сэтгэхүйн хөгжил сайн байгааг илэрхийлж байна. Харин салаа/ижил утгатай үгийг утгын төлөвшлийг зорилготойгоор дэмжих нь зүйтэй юм.

Хүснэгт 169. Үгийн утга тайлбарлах чадварын наснаас хамаарсан статистик ялгаа (11-17 нас)

			ANOVA					
				Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Үгийн тайлбарлах чадвар	утга	Бодит үг	Between Groups	100.460	6	16.743	12.504	.000
			Within Groups	1535.842	1147	1.339		
			Total	1636.302	1153			
	Хийсвэр үг	Between Groups	132.501	6	22.084	15.529	.000	
Within Groups		1632.534	1148	1.422				
Total		1765.035	1154					

Салаа үг	Between Groups	64.276	6	10.713	7.406	.000
	Within Groups	1669.286	1154	1.447		
	Total	1733.562	1160			

Үгийн утга тайлбарлах чадвар нь 13, 15, 17 насанд тухайн чадвар сайжирсан үр дүн харагдаж байна.

Хүснэгт 170. Үгийн утга тайлбарлах чадварын статистик үзүүлэлт, насаар (11-17 нас)

	Нас	Үгийн утга тайлбарлах чадвар:		
		Бодит үг	Хийсвэр үг	Салаа үг
11 нас	Mean	2.60	2.66	2.01
	N	96	96	96
	Std. Deviation	1.021	1.074	.852
	Std. Error of Mean	.104	.110	.087
12 нас	Mean	2.56	2.72	1.93
	N	96	96	96
	Std. Deviation	.960	1.176	.909
	Std. Error of Mean	.098	.120	.093
13 нас	Mean	2.93	2.94	2.26
	N	96	96	96
	Std. Deviation	1.242	1.204	.954
	Std. Error of Mean	.127	.123	.097
14 нас	Mean	2.97	3.09	2.02
	N	96	96	96
	Std. Deviation	1.209	1.274	.870
	Std. Error of Mean	.123	.130	.089
15 нас	Mean	3.50	3.69	2.42
	N	96	96	96
	Std. Deviation	1.152	1.251	.948
	Std. Error of Mean	.118	.128	.097
16 нас	Mean	3.41	3.54	2.50
	N	96	96	96
	Std. Deviation	.980	1.045	1.005
	Std. Error of Mean	.100	.107	.103
17 нас	Mean	3.47	3.82	2.58
	N	96	96	96
	Std. Deviation	1.076	.984	1.083
	Std. Error of Mean	.110	.100	.110
Нийт	Mean	3.06	3.21	2.25
	N	672	672	672
	Std. Deviation	1.153	1.225	.975
	Std. Error of Mean	.044	.047	.038


Б. Үгийг утгаар нь бүлэглэх чадвар (11-17 нас)

Суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд тэмдэг нэр, хийсвэр үг, салаа/ижил утгатай үгийг тайлбарлах чадвар нь дундаж түвшинд байна (M=3.05; M=3.33; M=3.07). Харин ахуйн шинжтэй бодит, нэрлэсэн үгсийг ангилах чадвар сайтай байна (M=4.29; M=4.06).

Бүрэн дунд боловсролын түвшинд хүүхдүүдийн үгийн утгыг таньж утгаар нь ангилах чадвар нь харьцангуй нэмэгддэг байна.

Ангилал зүйн хувьд гаргаж байгаа алдааг авч үзэхэд, суурь боловсролын түвшинд хүүхдүүд ямар нэгэн нийтлэг шинжийг харахгүйгээр буруу бүлэглэсэн байх нь элбэг бол бүрэн дунд боловсролын түвшинд үгийн илэрхийлж буй утгын гадаад шинж байдлыг нь төслүүлэн ангилсан алдааг нэлээд гаргасан байна. Мөн бүрэн дунд боловсролын түвшинд цөөнгүй хүүхдүүд нийтлэг шинжийг авч үзэхгүйгээр алдаа гаргасан байна.

Зураг 112. Үгийг утгаар нь ангилахад гаргаж байгаа алдаа, даалгаврын гүйцэтгэлээр, насны бүлгээр, хувиар (11-17 нас)



32.

Үгийн утгыг таньж утгаар нь ангилах чадвар нь хүүхдүүдийн наснаас хамаарсан статистик ач холбогдолтой ялгаатай байна ($p < .01$).

Хүснэгт 171. Үгийг утгаар нь ангилах чадварын наснаас хамаарсан статистик ялгаа (11-17 нас)

Чадвар		ANOVA					
		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.	
Үг бүлэглэх	Бодит үг	Between Groups	22.027	5	4.405	8.757	.000
		Within Groups	494.022	982	.503		
		Total	516.049	987			
Тэмдэг нэр		Between Groups	58.433	5	11.687	9.422	.000
		Within Groups	1220.522	984	1.240		
		Total	1278.955	989			
Нэрлэсэн үг		Between Groups	25.492	5	5.098	4.744	.000
		Within Groups	1056.366	983	1.075		
		Total	1081.858	988			
Салаа үг		Between Groups	115.877	5	23.175	14.465	.000
		Within Groups	1576.588	984	1.602		
		Total	1692.466	989			

Хүснэгт 172. Үгийг утгаар нь ангилах чадварын статистик үзүүлэлт, насаар (11-17 нас)

Нас		Үг бүлэглэл				
		Бодит үг	Тэмдэг нэр	Нэрлэсэн үг	Салаа үг	Хийсвэр үг
11 нас	Mean	4.00	2.43	3.72	2.40	3.03
	Std. Deviation	.598	1.023	1.149	1.209	1.080
	Std. Error of Mean	.061	.104	.117	.123	.110
12 нас	Mean	4.13	2.46	3.81	2.56	2.92
	Std. Deviation	.669	1.025	1.059	1.263	1.102
	Std. Error of Mean	.068	.105	.108	.129	.112
13 нас	Mean	4.10	2.85	3.76	2.89	3.10
	Std. Deviation	.703	1.170	1.220	1.337	1.071
	Std. Error of Mean	.072	.119	.125	.136	.109
14 нас	Mean	4.23	3.11	4.23	3.08	3.45
	Std. Deviation	.761	1.150	1.021	1.237	1.113
	Std. Error of Mean	.078	.117	.104	.126	.114
15 нас	Mean	4.20	3.22	4.14	3.23	3.28
	Std. Deviation	.829	1.028	1.038	1.334	1.130
	Std. Error of Mean	.085	.105	.106	.136	.115
16 нас	Mean	4.53	3.29	4.06	3.28	3.36
	Std. Deviation	.615	1.075	1.014	1.237	1.087
	Std. Error of Mean	.063	.110	.103	.126	.111
17 нас	Mean	4.44	3.18	4.17	3.62	3.42
	Std. Deviation	.595	1.036	.925	1.059	1.033
	Std. Error of Mean	.061	.106	.094	.108	.105
Нийт	Mean	4.23	2.93	3.98	3.01	3.22
	N	672	672	671	672	672
	Std. Deviation	.705	1.121	1.078	1.299	1.100
	Std. Error of Mean	.027	.043	.042	.050	.042

В. Ярих чадвар (11-17 нас)

Хүүхдийн ярих чадварыг зураг харуулан яриулах аргаар судалж, өгүүлбэрийн төрөл, утга санааг нэгтгэн дүгнэх шинжээр нь тодорхойллоо.

11-14 нас: Судалгааны 2-р шатанд 11-14 насны хүүхдүүдийн энгийн өгүүлбэрийн хэрэглээ болон утга санааг дүгнэж ярих чадвар нь нэмэгдсэн үр дүн харагдаж байна. Судалгааны 2-р шатанд энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх нь нэмэгдэж нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ буурч, дүгнэж ярих нь нэмэгдсэн байна. Харин хүүхдүүд юмсыг харагдаж байгаагаар нь тоочиж ярих нь харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл, хүүхдүүд санаагаа илэрхийлэхдээ энгийн богино өгүүлбэрээр нэгтгэн дүгнэдэг байна.

15-17 нас: 1 ба 2-р шатны судалгааны үр дүнгийн хооронд статистик ач холбогдолтой ялгаа байна. Судалгааны 2-р шатанд энгийн өгүүлбэрийн хэрэглээ нэмэгдэж, нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх нь багасаж, тоочиж ярихаасаа илүү дүгнэж ярих нь нэмэгдсэн байна. Санаа бодлоо илэрхийлэхдээ энгийн өгүүлбэрээр дүгнэж ярих нь илүү байна.

Суурь болон бүрэн дунд боловсролын түвшний хооронд ярих чадвар нь статистик ач холбогдолтой ялгаатай байна ($p < .01$).

Хүснэгт 173. Ярих чадварын насны бүлгийн хоорондын статистик ялгаа (11-17 нас)

			ANOVA				
			Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Ярих чадвар	энгийн өгүүлбэр	Between Groups	1.756	1	1.756	.813	.368
		Within Groups	2483.743	1149	2.162		
		Total	2485.500	1150			
	нийлмэл өгүүлбэр	Between Groups	5.979	1	5.979	5.477	.019
		Within Groups	1255.458	1150	1.092		
		Total	1261.437	1151			
холбоос ашигласан нийлмэл өгүүлбэр		Between Groups	11.113	1	11.113	43.842	.000
		Within Groups	291.504	1150	.253		
		Total	302.617	1151			
гадаад байдал тоочсон өгүүлбэр		Between Groups	.085	1	.085	.052	.820
		Within Groups	1905.469	1150	1.657		
		Total	1905.555	1151			
дүгнэсэн өгүүлбэр		Between Groups	28.391	1	28.391	12.259	.000
		Within Groups	2663.261	1150	2.316		
		Total	2691.653	1151			

Бүрэн дунд боловсролын түвшинд нийлмэл өгүүлбэрээр санаагаа дүгнэж илэрхийлэх нь тодорхой түвшинд сайжирдаг зүй тогтол харагдаж байна.

Хүүхдүүдийн наснаас хамаарсан бага зэргийн ялгаа байгаа хэдий ч статистик ач холбогдолтой зөрүү бага байна. Насны хувьд өөрчлөлт аажмаар нэмэгддэг зүй тогтол байна. Харин илт сайжирдаг нь ажиглагдсангүй.


Хүснэгт 174. Ярих чадварын наснаас хамаарсан статистик ялгаа (11-17 нас)

			ANOVA				
			Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Ярих чадвар	энгийн өгүүлбэр	Between Groups	30.447	6	5.075	2.357	.029

	Within Groups	2471.331	1148	2.153		
	Total	2501.778	1154			
нийлмэл өгүүлбэр	Between Groups	9.554	6	1.592	1.461	.188
	Within Groups	1252.075	1149	1.090		
	Total	1261.629	1155			
холбоос ашигласан нийлмэл өгүүлбэр	Between Groups	11.831	6	1.972	7.791	.000
	Within Groups	290.788	1149	.253		
	Total	302.619	1155			
гадаад байдал тоочсон өгүүлбэр	Between Groups	24.745	6	4.124	2.519	.020
	Within Groups	1880.822	1149	1.637		
	Total	1905.567	1155			
дүгнэсэн өгүүлбэр	Between Groups	32.957	6	5.493	2.357	.029
	Within Groups	2677.147	1149	2.330		
	Total	2710.104	1155			

Насны ялгаатай байдлыг авч үзэхэд, энгийн богино өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх нь 12, 14, 16 насанд нэмэгдэж, 17 насанд буурчээ. Нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх нь 12, 17 насанд аажим нэмэгддэг байна. Санаа бодлоо нэгтгэн дүгнэж илэрхийлэх нь 12, 16 насанд илэрхий сайжирдаг үр дүн харагдаж байна. Гадаад шинж байдлыг тоочин илэрхийлэх нь нас нэмэгдэх тусам аажмаар буурдаг байна.

Зураг 113. Ярих чадвар, насаар, дундаж үзүүлэлт (11-17нас)



Хүүхдүүд дунджаар 2 минутад 32-33 үгээр санаа бодлоо илэрхийлжээ.

Дүгнэлт

Суурь ба бүрэн дунд боловсролын түвшний 11-17 насны хүүхдүүдийн сэтгэхүй, хэл ярианы хөгжлийн онцлог

11-17 насны хүүхдийн сэтгэхүй хэл ярианы чадварыг сэтгэхүйн задлан шинжилж харьцуулах үйлдэл, сэтгэхүйн харьцуулан нэгтгэн дүгнэх үйлдэл, хийсвэр сэтгэхүй, үгийн утга тайлбарлах, үгийг утгаар нь ангилах, ярих чадварын хүрээнд судалсан.

Судалгааны үр дүнгээс дараах онцлог ажиглагдлаа.

- Судалгааны 2-р шатанд энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэн дүгнэж ярих нь нэмэгдсэн байна. Харин үгийн утгыг тайлбарлах, нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, тоочиж ярих нь буурсан дүр зураг харагдаж байна. Нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх нь буурч байгаа нь хүмүүс хоорондын харилцааны идэвх буурсантай холбоотой байх боломжтой юм. Үгийн утгын эзэмшилт, бүтэн өгүүлбэрээр санаа бодлоо дэлгэрэнгүй оновчтой илэрхийлэх чадварыг нь дэмжих шаардлага байна.
- Сэтгэхүйн хөгжлийн хувьд 11-14 насны хүүхдүүд юмс үзэгдлийг бүтцэд нь задлан шинжилж харьцуулах чадвар нь дундаж хэвийн түвшинд байгаа бол юмсыг харьцуулан нийтлэг шинжээр нь нэгтгэх сэтгэхүйн логик чадвар нь сул түвшинд байна. Хүүхдүүд юмс үзэгдлийг гадаад шинжээр нь харьцуулан нэгтгэх нь дамгайлдаг. Мөн гадаад шинж үйлдэл нөлөөллийг нь онцлон нэгтгэдэг дүр зураг харагдаж байна. Нас нэмэгдэхэд сэтгэхүйн харьцуулан нэгтгэх чадвар аажмаар сайжирдаг дүр зураг харагдаж байна. Ялангуяа 13, 14 насанд нэмэгддэг тал байна. 15-17 насанд юмс үзэгдлийн дотоод мөн чанарыг таньж задлан шинжилж харьцуулан нэгтгэх чадвар сул байна.
- Хийсвэр сэтгэхүйн гол мөн чанарыг илэрхийлдэг математик сэтгэхүйн хувьд хөгжил нь хэвийн дундаж түвшинд байгаа хэдий ч юмсыг нарийн учир шалтгаанд нь сэтгэх тооцоолох чадвар дутмаг байна. Нас нэмэгдэхэд тухайн чадвар нь сайжирчээ. (11-17 нас)
- Хэл ярианы чадварын хувьд үгийн утга тайлбарлах логик чадвар нь 11-14 насанд хэвийн дундаж, 15-17 насанд үгийн утгыг тайлбарлах чадвар сайн байна. 11-14 насны хүүхдүүд үгийн утгыг гадаад шинж, үйлдлээр нь тайлбарлах хандлагатай бол 15-17 насны хүүхдүүд үгийг гол утгаар нь тайлбарлах чадвар сайтай байна.
- 11-17 насны хүүхдүүд үгийг утгаар нь ангилах ангилал зүйн чадвар сайтай байна. Үгий төрөл зүйлийн хувьд тэмдэг нэр, салаа/ижил утгатай үг, хийсвэр утгатай үгийг ангилах нь дундаж түвшинд байна. Нас нэмэгдэхэд тухайн төрөл зүйлийг ангилах чадвар сайжирч байгаа нь хүүхдийн үгийн нөөц ухагдахууны ойлголт нь нас нэмэгдэхэд тэмдэг нэр, салаа/ижил утгатай үгээр баяждагийг илэрхийлж байна. 15-17 насанд хүүхдүүдийн ангилал зүйн чадвар харьцангуй сайжирдаг байна.
- Ярих чадварын хувьд 11-17 насны хүүхдүүд санаа бодлоо илэрхийлэхдээ энгийн богино өгүүлбэрээр товчхон дүгнэж ярих хандлага давамгайлж байна. Гэхдээ 15-

17 насанд хүүхдүүд нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, гадаад тоочиж ярихаасаа илүүтэй дүгнэж ярих нь тодорхой хэмжээгээр сайжирдаг зүй тогтол байгаа боловч ихэнх нь энгийн богино өгүүлбэрийг хэрэглэдэг зүй тогтол харагдлаа. Ярих чадварын хөгжлийн мэдрэмтгий үе нь 12, 16, 17 нас байна. Хүүхдүүд дунджаар 2 минутад 32-33 үгийн хооронд ярьжээ.

- Бүрэн дунд боловсролын түвшинд хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүй, хэл ярианы чадвар сайжирдаг байна.

2.3.4. Дүгнэлт

Бага боловсролын 6-10 насны хүүхдүүдийн танин мэдэхүйн онцлог

Нийт танин мэдэхүйн даалгаврын үр дүнг нь ерөнхийд нь нэгтгэж үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

- Судалгааны 2-р шатанд 6-7 насны хүүхдүүдийн анхааралтайгаар, хурдтайгаар энгийн дүрс зураг тэмдэглэгээ хийх хурд, энгийн үйл явдалтай богино өгүүллэгийг утгаар нь тогтоох чадвар нэмэгдсэн байна.
- Мөн 6-10 насны хүүхдүүдийн энгийн богино өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, юмс үзэгдлийг хараад ерөнхийлөн дүгнэж илэрхийлэх чадвар нэмэгдсэн байна.
- 8-10 насны хүүхдүүдийн оюуны үйлд анхаарлаа төвлөрүүлэн бүтээлчээр ажиллах чадвар, богино хугацаанд цифр хараад дэс дарааллаар нь тогтоож сэргээн санах чадвар, нийлмэл өгүүлбэр хэрэглэж санаа бодлоо илэрхийлэх, үгийн утгыг тайлбарлах болон үгийг утгаар нь ангилах хэл ярианы логик чадвар буурсан дүр зураг харагдаж байна.
- Бага боловсролын 6-10 насны хүүхдүүд зорилготойгоор мэдээллийг хүртэх, анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэхүйн ангилал зүйн чадвар сул байдаг байна. Харин энгийн математик тооцоолол хийх, хэл ярианы мэдээллийг хийсвэрлэн ойлгох, энгийн шинжээр нь юмсыг задлан шинжлэх, харьцуулах чадвар хэвийн дундаж түвшинд байна. Хүүхдүүд зураг хараад санаа бодлоо хүүрнэн илэрхийлэх танин мэдэхүйн чадвар сайн байна. Танин мэдэхүйн чадварууд нь жигд хөгжиж байгаа байдал харагдаж байна.
- Даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг авч үзэхэд бүхэл бүтнээр нь хүртэх, богино хэмжээний хялбар эхийг утгачлан тогтоох, нэг зүйлээс нөгөөд анхаарлаа шилжүүлэх, богино хугацаанд энгийн дүрсийг хараад тогтоох,

математик тооцооллын чадвар, богино хугацаанд цифр хараад тогтоох чадвар нь дундаж ба түүнээс бага зэрэг доогуур түвшинд байна.

Суурь ба бүрэн дунд боловсролын 11-17 насны хүүхдүүдийн танин мэдэхүйн онцлог

Судалгааны 2-р шатанд 11-14 насанд богино хугацаанд цифрийг дэс дараагаар нь тогтоож сэргээн санах, нарийн үйл явдалтай үлгэр, өгүүллэгийг утгачлан тогтоож сэргээн санах, санаа бодлоо энгийн өгүүлбэрээр, үзэгдэж байгаа юмсын гадаад шинж байдлыг тоочиж илэрхийлэх чадвар өссөн бол нийлмэл өгүүлбэр хэрэглэн санаа бодлоо илэрхийлэх, үзэгдэж байгаа юмсын шинж байдлыг ерөнхийлөн дүгнэж илэрхийлэх, үгийн утгыг тайлбарлах логик чадвар буурсан дүр зураг харагдаж байна.

15-17 насанд оюуны үйлд анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах, богино хугацаанд цифр хараад тогтоож дэс дарааллаар нь сэргээн санах, хоорондоо холбоогүй үгсийг сонсоод сэргээн санах, энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх, үзэгдэж байгаа юмсын шинж байдлыг ерөнхийлөн дүгнэж илэрхийлэх, үгийн утга тайлбарлах логик чадвар өссөн үзүүлэлттэй байна.

Суурь боловсролын түвшний танин мэдэхүйн чадварууд нь бага боловсролын түвшинтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Бүрэн дунд боловсролын түвшинд хүүхдүүдийн чадвар нэмэгддэг байна. Суурь болон бүрэн дунд боловсролын түвшний хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар нь хамгийн сул байна. Бусад чадварууд нь харьцааны хувьд жигд хөгжилтэй байна.

Танин мэдэхүйн чадвар тус бүрээр нарийвчлан авч үзвэл, 11-17 насанд хүүхдүүд оюуны үйлд анхаарлаа төвлөрүүлэн бүтээлчээр ажиллах, нийлмэл өгүүлбэрээр бодол санаагаа илэрхийлэх нь сул байна.

2.4 СУДАЛГААНД ХАМРАГДСАН 3-17 НАСНЫ ХҮҮХДИЙН НИЙГЭМШЛИЙН ОНЦЛОГ

2.4.1 Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн нийгэмшлийн онцлог

Нас бүр нь сэтгэцийн хөгжлийн өвөрмөц онцлог шинжтэй. Хөгжлийн үе шат бүр нь хүүхдийн бие хүний онцлогийг тодорхойлох олон тооны өөрчлөлтийг агуулна.

Хүүхэд нийгмийн харилцаанд орж өөрийгөө болон бусдыг таньж, сэтгэл хөдлөлөө барьж зохицуулж эхэлдэг. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд шинэ хэрэгцээ буюу үе тэнгийнхэнтэйгээ харьцах харьцааны өөрчлөлт нь бие биетэйгээ хамтдаа тоглох, санал бодол, сэтгэгдлээ хуваалцах боломжтой болгоно. Өөрийгөө үнэлэх үнэлгээ хөгждөг бөгөөд энэ нь заримдаа сэтгэл хөдлөлийн мэдрэмжийг нэмэгдүүлж, заримдаа хүүхдүүдийн хооронд маргаан үүсгэдэг. Цаг хугацаа өнгөрөх тусам хүүхэд улам бүр бие даасан болдог.

Д.И.Фельдштейн сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжилд дүрд тоглох тоглоомны үүргийг онцолсон байдаг. Дүрд тогтсоноор хүүхэд эцэг эх, ах дүүгээ, эмээ өвөөгөө хайрлах хайр, ойр дотны хүмүүсээ өрөвдөх сэтгэл, нөхөрсөг харьцааг баяжуулж, өөрчилж, илүү төвөгтэй нийгмийн мэдрэмжийг бий болгох үндэс суурь болдог гэж тайлбарласан байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшлийн хөгжилд тоглоом чухал үүрэгтэй. Хүүхдүүдийн хоорондын жинхэнэ харилцаа бол хамтаран тоглох үед үүснэ. Тоглох явцад үүссэн бодит харилцаа нь хүүхдийн хувийн хөгжлийн шинж чанар, үе тэнгийнхний хоорондын харилцааны шинж чанараар тодорхойлогдоно. А.П.Усова, С.Н.Карпова, Л.Г. Лысюк нарын эрдэмтэд бодит харилцаа нь хүүхдийн харилцааны болон нийгмийн чадамжийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж тэмдэглэсэн байна. Тоглоомын ид өрнөл хэсэгт харилцааны хэм хэмжээ дэх чиг баримжаа бодитоор бие биенээ хүлээн зөвшөөрч хамтран тоглох, эсвэл тоглохоо болих гэх зэргээр илэрдэг байна.

Тоглох үед хүүхдийн танин мэдэхүйн чадварууд, мэдрэмж, анхаарал, ой тогтоолтын үндсэн сэргээн санах, таних процессууд, төсөөлөл, сэтгэхүй, нийгэмшлийн үзүүлэлтүүд болох харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж, хүсэл эрмэлзлийг бий болгодог. Гэхдээ эдгээр эерэг нөлөөллүүд нь тоглоомыг насны онцлогт тохирсон байдлаар зөв чиглүүлснээр бий болдог.

Ж.Пиажегийн үзэж байгаагаар сургуулийн өмнөх насны хүүхэд тоглоом, бодит байдал гэсэн хоёр ертөнцөд нэгэн зэрэг амьдардаг.

Гэр, цэцэрлэг сургуулийн гадаа талбайд байдаг тоглоомууд нь бие бялдрын хөгжилд маш чухал ач холбогдолтой. Гадаа тоглох нь бага насны хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Тухайлбал: хүүхдүүд бие биенийхээ нүүрний хувирал, хөдөлгөөн, хэл яриа дууны өнгө гэх мэт гадаад илэрхийллийг ажиглаж, таньж, бие даан зохицож сурдаг байна. Энэ насанд хүүхдүүд сэтгэлийн хөдөлгөөний байдлаа нууж чаддаггүй учир бие биенийхээ сэтгэлийн хөдөлгөөний байдалд аяндаа дасаж таньж эхлэн дасан зохицдог байна.

Сэтгэлийн хөдөлгөөний эерэг, сөрөг илрэл нь хурдан өөрчлөгддөг учир нөхцөл байдлаас шалтгаалан сэтгэл хөдлөлөө барьж, хязгаарлаж чадахгүй ч аажим аажмаар аяндаа үүссэн нөхцөлд өөрийн байр сууриа олж, бие хүний зан төлөвийн шинж болж хувирч өөрчлөгдөж эхэлдэг. Хүүхдүүд гэрийн, цэцэрлэгийн, ангийн дүрэм баримталж эхлэх үед өөртөө ойрын зорилтууд тавьж эхлэх ба зоригийн чанарууд бага багаар бий болж эхэлдэг. Гэсэн ч энэ үед ч гэсэн хүүхдүүдэд тэсвэр тэвчээртэй байх, эхэлсэнээ дуустал хийх тууштай байх чадвар төлөвшөөгүй байна. Тиймээс хүүхдүүд тодорхой зорилготой болох, бие дааж, тэсвэр тэвчээртэй, эхэлсэнээ дуусгах, шийдэмгий байх гэх мэт чадваруудын суурийг тавьж хөгжүүлэх хэрэгтэй байдаг.

Хүүхдүүдийн өөрийн тухай ойлголтыг нэрээ мэддэг эсэх, хэдэн настай, хүйсээ зөв хэлж буй байдал, аав, ээжийнхээ нэрийг мэддэг эсэх болон гэртээ хэдүүлээ амьдардаг, цэцэрлэгийн ямар бүлэгт явдагаа нэрлэж мэдэж байгааг асуулгаар хариултын хувилбаруудтай авч үзлээ.

д/д	Сэтгэлийн хөдөлгөөн			Харилцааны чадвар
1.	Өөрийн мэдрэх	сэтгэлийн	хөдөлгөөнийг	Үе тэнгийнхэнтэйгээ харилцах, хамтарч тоглох
2.	Бусдын мэдрэх	сэтгэлийн	хөдөлгөөнийг	Бусдаас дэмжлэг авах чадвар

Даалгаврын найдвартай чанар буюу reliability нь Cronbach's Alpha гэдэг статистик үзүүлэлтээр тодорхойлсон. Бидний даалгаврын найдвартай чанар 0.613 гарсан тул нийгэмшлийн чадваруудыг сорил даалгаврууд тодорхойлж чадсан гэж үзлээ.

Өөрийн тухай ойлголт

Сургуулийн өмнөх наснаас эхлэн хүүхэд өөрийнхөө талаар маш их зүйлийг мэддэг, өөрийн мэдрэмж, зан аашаа хэрхэн удирдахаа мэддэг болох ба дур зоргоороо зан авир ч гаргаж эхэлдэг. Хоёр нас таван сартайгаас эхлэн танин мэдэхүйн хөгжилтэй

зэрэгцэн хүүхдийн бэлгийн чиг баримжаа явагдаж, 3 настайдаа ихэнх хүүхдүүд насаа төдийгүй хүйсээ нэрлэж чаддаг болно.

Судалгаанд хамрагдсан хүүхдийн өөрийн болон аав, ээжийн нэр, өөрийн нас, хүйсээ нэрлэх, гэртээ хэдүүлээ амьдардаг, ямар бүлэгт сурдаг зэргээ илэрхийлж байгаа байдлаар тэдний өөрийгөө илэрхийлэх чадварыг судлав.

Хүснэгт 175. Өөрийн тухай ойлголт - Өөрийн нэрийг мэддэг байдал, насаар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Нэрээ хэлээгүй	5.2	1.0	2.1	2.8
Гэр бүлийнхэн нь нэрлэдэг насаа хэлсэн	2.1	0.0	0.0	0.7
Нэрээ хагасалж хэлсэн	12.5	3.1	4.2	6.6
Нэрээ бүтэн хэлсэн	80.2	95.8	93.8	89.9

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдүүд 3 наснаас 80.2 хувь нь нас нэмэгдэх тусам энэ үзүүлэлт нэмэгдсэн буюу 4-5 насандаа хүүхдүүд өөрийн нэрээ хэлж танилцуулах чадвартай болсон байна.

Хүснэгт 176. Өөрийн насаа мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Насаа хэлээгүй	2.1	0.0	0.0	0.7
Насаа буруу хэлсэн	22.9	15.6	4.2	14.2
Насаа хуруугаараа зөв харуулсан	25.0	26.0	11.5	20.8
Насаа зөв хэлсэн	50.0	58.3	84.4	64.2

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3 настай хүүхдүүдийн 50.0 хувь нь өөрийн насаа мэддэг, 5 настай хүүхдүүдийн 84.4 хувь насаа зөв танилцуулж байгаа ч 3 настай хүүхдүүдийн 25 хувь, 5 настай хүүхдүүдийн 11.5 хувь нь насаа хуруугаараа харуулдаг хэлж байна.

Хүснэгт 177. Өөрийн хүйсээ мэддэг эсэх, насаар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хүйсээ хэлээгүй	24.0	4.2	3.1	10.4
Хүйсээ буруу хэлсэн	18.8	8.3	5.2	10.8
Хүйсээ зөв хэлсэн	57.3	87.5	91.7	78.8

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүдийн 57.3 хувь нь өөрийн хүйсээ зөв танилцуулсан 5 настай хүүхдүүдийн 91.7 хувь нь зөв танилцуулсан ба нийт хүүхдүүдийн 10.4 хувь нь хүйсээ хэлээгүй, 10.8 хувь нь хүйсээ буруу хэлсэн байна.

Хүснэгт 178. Аавынхаа нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Аавынхаа нэрийг хэлээгүй	24.0	11.5	1.0	12.2
Аавынхаа нэрийг буруу хэлсэн	8.3	1.0	1.0	3.5
Аавынхаа нэрийг хагасалж хэлсэн	36.5	22.9	22.9	27.4
Аавынхаа нэрийг бүтэн хэлсэн	31.3	64.6	75.0	56.9

Хүүхдүүд аавынхаа нэрийг бүтэн нэрээр нь 3 насны хүүхдүүдийн 31.3 хувь, 4 настай хүүхдүүдийн 64.6 хувь нь, 5 настай хүүхдүүдийн 75.0 хувь нь өөрийнхөө аавын нэрийг хэлж танилцуулсан байна.

Хүснэгт 179. Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Ээжийнхээ нэрийг хэлээгүй	20.8	6.3	3.1	10.1
Ээжийнхээ нэрийг буруу хэлсэн	4.2	0.0	1.0	1.7
Ээжийнхээ нэрийг хагасалж хэлсэн	43.8	38.5	22.9	35.1
Ээжийнхээ нэрийг бүтэн хэлсэн	31.3	55.2	72.9	53.1

Хүүхдүүд ээжийнхээ нэрийг бүтэн нэрээр 3 насны хүүхдүүдийн 31.3хувь, 4 настай хүүхдүүдийн 55.2 хувь нь, 5 настай хүүхдүүдийн 72.9 хувь нь танилцуулсан байна.

Хүснэгт 180. Ам бүлийн тоог хэлсэн байдал, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хэлээгүй/ мэдэхгүй	9.4	1.0	1.0	3.8
Би агаа, аниатайгаа гэх мэтээр хэлсэн	15.6	11.5	7.3	11.5
Би аав, ээж, дүү, ахтай гэх мэтээр хэлсэн	60.4	57.3	41.7	53.1
Хэдэн ам бүлтэйгээ зөв хэлсэн	14.6	30.2	50.0	31.6

Хүүхдүүд өөрийн амьдарч буй гэрийн ам бүлийн гишүүдийн тоог хэлж чадаагүй 3 настай хүүхдүүдийн 9.4 хувь байгаа ба би агаа аниатай амьдардаг гэж 15.6 хувь нь хариулсан бол 3 болон 4 настай хүүхдүүдийн 14.6-30.2 хувь нь гэр бүлийн гишүүдийн тоог зөв хэлсэн байна. Гурав дөрвөн настай хүүхдүүд ам бүлийнхээ тоог хэлхээс илүү аав ээж, ах, дүүтэйгээ амьдардаг гэж тоочиж нэрлэдэг байна.

Хүснэгт 181. Суралцдаг бүлэг нэрлэсэн эсэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хэлээгүй/ мэдэхгүй	53.1	28.1	16.7	32.6
Би ангидаа/ цэцэрлэгт явдаг	16.7	25.0	16.7	19.4
Бүлгээ буруу хэлсэн	22.9	10.4	4.2	12.5
Бүлгээ зөв хэлсэн	7.3	36.5	62.5	35.4

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 5 настай хүүхдүүдийн 62.5 хувь нь, 4 настай хүүхдүүдийн 36.5 хувь нь, 3 настай хүүхдүүдийн 7.3 хувь нь хамрагдаж буй цэцэрлэгийнхээ ямар нэртэй бүлэгт суралцаж буйгаа танилцуулсан байна.

Хүүхдүүд 3 насандаа өөрийнхөө хүйс, нэр, ээж аавынхаа нэрийг болон өөрийн суралцаж буй бүлэг, гэр бүлийн гишүүдийн тухай ойлголтой болсон байдаг байна.

Сэтгэлийн хөдөлгөөн

Хүүхдүүдийн өөрийн дуртай зүйлийг хэлэх, ямар үед уурладаг, уйтгар гунигтай байдаг, ямар үед гоё, баяртай байдаг талаар өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх чадварыг авч үзлээ.

Хүснэгт 182. Эерэг сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Ойлгохгүй/ хэлээгүй	27.1	16.7	3.1	15.6
Хариулт тодорхой биш	20.8	21.9	12.5	18.4
Өөрт тохиолдсон үйл явдал дурдаж байгаа бол	3.1	10.4	3.1	5.6
Тодорхой нөхцөл нэрлэж байгаа бол	49.0	51.0	81.3	60.4

Хүүхдүүдийн өөрийн сэтгэл хөдлөлөө тийм үед ингэж байсан гэж өнгөрсөн цаг дээр 3 настай хүүхдүүдийн 3.1 хувь нь санаж дурсан ярьсан байна. Би бэлэг аваад их

баярладаг гэх мэтээр 3 настай хүүхдүүдийн 49 хувь, 4-5 настай хүүхдүүдийн 51.0-83.3 хувь нь хариулсан байна. Гурван наснаас хүүхдүүд өөртөө ямар үед тааламжтай сэтгэл хөдлөл үүсдэг талаар мэдлэгтэй болсон байдаг байна.

Хүснэгт 183. Сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас)


	3 нас	4 нас	5 нас	Нийт
Ойлгохгүй/ хэлээгүй	43.8	26.0	11.5	27.1
Хариулт тодорхой биш	16.7	12.5	9.4	12.8
Өөрт тохиолдсон үйл явдал дурдаж байгаа бол	5.2	9.4	10.4	8.3
Тодорхой нөхцөл нэрлэж байгаа бол	34.4	52.1	68.8	51.7

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүдийн 43.8 хувь, 4-5 настай хүүхдүүдийн 26.0-11.5 хувь нь ямар үед өөрт нь тааламжгүй уйтгартай, гунигтай, ууртай болдог талаар хариулаагүй байна. Харин хүүхдүүдийн 16.7-9.4 хувь яагаад ууртай, гунигтай болдог талаар тодорхой хариулт өгч чадаагүй байна. Би надад таалагдаагүй учир тэгж ууралсан гэх мэт тодорхой нөхцлүүдийг дурдаж, яагаад гомдсон, уурласан байдлаа 3 настай хүүхдүүдийн 34.4 хувь, 4-5 настай хүүхдүүдийн 52.1-68.8 хувь нь тодорхой хариулсанаас үзэхэд хүүхдүүд өөрийн сөрөг сэтгэл хөдлөлийг таньж мэдэх чадвар нас нэмэгдэх тусам сайжирдаг байна

Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних чадвар

Хүүхдүүдэд зураг дээрх хүүхдүүдийн биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаар ямар сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж байгааг танилах сорил гүйцэтгүүлсэн.

Зураг 114. Гунигтай, ууртай байгаа хүүхдийг таних хувиар (3-5 нас)



Хэд хэдэн сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн зураг дотроос сөрөг буюу гунигтай байгаа хүүхдийг олох даалгаврыг 4 настай хүүхдүүдийн 86.5 хувь, 5 настай хүүхдүүдийн 95.8 хувь нь зөв гүйцэтгэсэн байна. Хүүхдүүд бие биенийхээ бие биенийхээ

нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөс харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж чаддаг байна.


Хүснэгт 184. Гайхаж байгаа хүүхдийг олж таних чадвар (3-5 нас)

	4 нас	5 нас	Нийт
Буруу	43.8	34.4	39.1
Зөв	56.3	65.6	60.9

Гайхаж байгаа байдалтай хүүхдийг олж танин чадвар 4 настай хүүхдүүдийн 56.3 хувь, 5 настай хүүхдүүдийн 65.6 хувьд байгаа нь хүүхдүүд бие биенийхээ нүүрний

хувирал, биеийн хөдөлгөөнөөс харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж таних нь ууртай байгаа баярлаж байгаа нүүр царайны илрэлийг таних нь сул байна.

Зураг 115. Баярлаж байгаа хүүхдийг олж таних (3-5 нас)



Олон хүүхдүүдийн сэтгэл хөдөллийн байдлыг илэрхийлсэн илэрлүүдээс хөөрч баярлаж байгаа хүүхдийг 97.9- 93.8 хувь нь олж танисан байна.

Харилцааны чадвар

Хүүхдүүд цэцэрлэгтээ нийгмийн харилцаанд орж өөрийгөө болон бусдыг таньж, сэтгэл хөдлөлөө барьж зохицуулж эхэлдэг. Хүүхэд насанд хүрэгчидтэй харилцах харилцаа өөрчлөгдөж, аажмаар насанд хүрэгчдийн зааврыг бие даан биелүүлж эхэлдэг ба хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ тодорхой харилцаанд орж эхэлдэг (нийгмийн орчин өөрчлөгдөж цэцэрлэгт хамрагдах гэх мэт). Энэ насанд хүүхдүүдэд шинэ хэрэгцээ буюу үе тэнгийнхэнтэйгээ харилцах хэрэгцээ гарч, үе тэнгийнхэнтэйгээ харьцах харьцаа эрс өөрчлөгддөг. Хүүхдүүд бие биетэйгээ хамтдаа тоглох, санал бодол, сэтгэгдлээ хуваалцах боломж болно.

Хүүхдийн хөгжил нийгмийн харилцаанаас ангид явагдах боломжгүй юм. Өөрийгөө үнэлэх үнэлгээ хөгждөг бөгөөд энэ нь заримдаа сэтгэлийн хөдөлгөөний мэдрэмжийг нэмэгдүүлж, заримдаа хүүхдүүдийн хооронд маргаан үүсгэдэг. Цаг хугацаа өнгөрөх тусам хүүхэд улам бүр бие даасан болдог. Сургуулийн өмнөх наснаас эхлэн хүүхэд өөрийнхөө талаар маш их зүйлийг мэддэг, өөрийн мэдрэмж, зан аашаа хэрхэн удирдахаа мэддэг болох ба дур зоргоороо зан авир ч гаргаж эхэлдэг.

Дөрвөөс зургаан насандаа хүүхдүүд "эцэг эх", "охин, ээжүүд", "эмнэлэг" "цагдаа" гэх мэтээр тоглож, эцэг эх, эмч гэх мэт аль нэгнийх нь үүргийг өөрийнхөө харсанаар дүрд орж илэрхийлнэ. Д.И.Фельдштейн сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжилд дүрд тоглох тоглоомны үүргийг онцолсон байдаг. Дүрд тогтолсоноор хүүхэд эцэг эх, ах дүүгээ, эмээ өвөөгөө хайрлах хайр, ойр дотны хүмүүсээ өрөвдөх сэтгэл, нөхөрсөг харьцааг баяжуулж, өөрчилж, илүү төвөгтэй нийгмийн мэдрэмжийг бий болгох үндэс суурь болдог гэж тайлбарласан байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшлийн хөгжилд тоглоом чухал үүрэгтэй. Хүүхдүүдийн хоорондын жинхэнэ харилцаа бол хамтран тоглох үед үүснэ. Тоглох явцад үүсгэсэн бодит харилцаа нь хүүхдийн хувийн хөгжлийн шинж чанар, үе тэнгийнхний хоорондын харилцааны шинж чанараар тодорхойлогдоно. А.П.Усова, С.Н.Карпова, Л.Г.Лысюк нарын эрдэмтэд бодит харилцаа нь хүүхдийн харилцааны болон нийгмийн чадамжийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж тэмдэгэлсэн байна. Тоглоомын ид өрнөл хэсэгт харилцааны хэм хэмжээ дэх чиг баримжаа бодитоор бие биенээ хүлээн зөвшөөрч хамтран тоглох, эсвэл тоглохоо болох гэх зэргээр илэрдэг байна.

Тоглох үед хүүхдийн танин мэдэхүйн чадварууд, мэдрэмж, анхаарал, ой тогтоолтын үндсэн сэргээн санах, таних процессууд, төсөөлөл, сэтгэхүй, нийгэмшлийн үзүүлэлтүүд болох харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж, хүсэл эрмэлзлийг бий болгодог. Гэхдээ эдгээр зэрэг нөлөөллүүд нь тоглоомыг насны онцлогт тохирсон байдлаар зөв чиглүүлж өгсөнөөр бий болдог.

Төсөөлөл, дүрслэх, дүрслэх сэтгэлгээ түүнийг хөгжүүлэх үндэс нь тоглоом юм. Тоглоомын үйл ажиллагаа нь төсөөллийн үйл явцыг бий болгодог. Ж.Пиажегийн үзэж байгаагаар сургуулийн өмнөх насны хүүхэд тоглоом, бодит байдал гэсэн хоёр ертөнцөд нэгэн зэрэг амьдардаг.

Харилцааны чадварыг хүүхдүүд найзтай эсэх, найзуудтайгаа тоглодог эсэх, тоглоомоо хуваалцдаг талаар авч үзлээ.

Хүснэгт 185. Найзуудтайгаа тоголдог, хэрхэн тоглодог талаар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй	4.2	1.0	0.0	1.7
Тоглодоггүй	4.2	2.1	4.2	3.5
Хэрхэн тоглодог хэлсэн	91.7	96.9	95.8	94.8

Хүүхдүүдээс найзуудтайгаа хэрхэн тоголдог талаар асуухад 3 настай хүүхдүүдийн 4.2 хувь нь хамтран тоглодоггүй, 4 настай хүүхдүүдийн 2.1 хувь нь, 5 настай хүүхдүүдийн 4.2 хувь нь хамтран тоглодоггүй гэсэн бол нийт хүүхдүүдийн 94.8 хувь нь найзуудтайгаа хэрхэн тоглодог тухайгаа тайлбарлан ярьсан байна.

Хүснэгт 186. Хүүхэд тоглоомоо хуваалцах байдал (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	8.3	2.1	2.1	4.2
Тоглоомоор ганцаараа тоглоно	20.8	8.3	7.3	12.2
Тоглоом өгнө	27.1	35.4	35.4	32.6
Хамт тоглоно	43.8	54.2	55.2	51.0

Хүүхдүүд тоглоомоо найзуудтайгаа хувааж тоглох талаарх ойлголт 3 наснаас бий болдог байна. Гурван настай хүүхдүүдийн 20.8 хувь нь ганцаараа тоглох дуртай гэсэн бол найздаа тоглоомоо өгнө, хамт тоглоно гэж 70.9 хувь нь хариулсан байна.

Бусдаас дэмжлэг авах чадвар

Хүснэгт 187. Аюул тохиолдсон үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй	18.8	4.2	2.1	8.3
Уйлна гэнэ	8.3	1.0	1.0	3.5
Хажууд байгаа хүнээс тусламж хүснэ	10.4	12.5	9.4	10.8
Ээж, аав, эмээ, өвөө, эмч дээр очно	62.5	82.3	87.5	77.4

Хүүхдүүд ямар нэг байдлаар аюул тохиолдсон үед гэр бүлийн гишүүд болох өвөө эмээ, ээж, ааваасаа болон эмч дээр очиж тусламж авна гэж 3 настай хүүхдүүдийн 62.5 хувь, 4 настай хүүхдүүдийн 82.3 хувь, 5 настай хүүхдүүдийн 87.5 хувь нь хариулсан байна. Тухайн аюул тохиолдсон үед хамгийн ойр хажууд байгаа хүнээс тусламж авна гэж 4 настай хүүхдийн 12.5 хувь, 5 настай хүүхдийн 9.4 хувь нь л хариулсан байна. Тухайн үед хамгийн ойр байгаа хүнээс тусламж авах тухай хүүхдэд ойлголт өгөх хэрэгтэй байна.

Хүснэгт 188. Өөрт хэрэгтэй зүйл авах үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	13.5	1.0	3.1	5.9
Аав, ээж, ах, эгчээсээ тусламж авна	20.8	19.8	21.9	20.8
Худалдагч/ хажууд байгаа хүнээс тусламж авна	65.6	79.2	75.0	73.3

Хүүхдүүд өөрт хэрэгтэй зүйлийг авах үедээ өөрт хамгийн ойр хажууд байгаа хүнээсээ тусламж дэмжлэг авна гэж 3 настай хүүхдүүдийн 65.6 хувь, 4-5 настай хүүхдүүдийн 79.2-75.0 хувь хариулсан байна. Аюул тохиолдсон үед хажууд ойр байгаа хүнээс тусламж дэмжлэг авахаас илүү өөрийн дотны хүмүүсээс дэмжлэг авна гэж байсан бол өөрийн хэрэглээний зүйлд харин хамгийн ойр байгаа хүмүүсээс дэмжлэг авч болно гэж үздэг байна.

Дүрэм, журам баримтлах чадвар

Хүснэгт 189. Дүрэм, журам баримтлах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	3.1	0.0	0.0	1.0
Зөв хаяж болно	7.3	1.0	0.0	2.8
Хогийн сав ойрхон биш бол хаяж болно.	1.0	0.0	1.0	0.7
Болохгүй	88.5	99.0	99.0	95.5

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүдийн 1.0 хувь, 5 настай хүүхдүүдийн 1.0 хувь нь өөрт хэрэггүй болсон хогийг байсан газраа буюу хогийн сав ойрхон биш бол хаяж болно гэж үзэж байгаа бол 4 настай хүүхдүүдийн 99 хувь нь заавал хогийн саванд хогоо хаях ёстой гэж үздэг байна. Яагаад гэвэл орчноо бохирдуулна, гэрээ муухай болгоно, дэлхийгээ муухай болгоно гэх мэтээр учрыг нь тайлбарлажээ.

Хүснэгт 190. Олон нийтийн газар дүрэм журам баримтлах чадвар (3-5 нас)

Хариулт	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	3.1	4.2	5.2	4.2
Зөв	27.1	6.3	4.2	12.5

Уйлж байгаа нь буруу/муухай байна	0.0	0.0	2.1	0.7
Буруу	69.8	89.6	88.5	82.6

Олон нийтийн газар хүүхэд дэлгүүрт өөрийн авах гэсэн зүйлийг уйлж байж авах явдал байдаг. Энэ талаар хүүхдүүдийн хариултыг авч үзэхэд ингэж уйлах нь зөв гэж 3 настай хүүхдүүдийн 27.1 хувь нь, 4 настай хүүхдүүдийн 6.3 хувь, 5 настай хүүхдүүдийн 4.2 хувь нь хариулсан байна. Харин ингэж уйлж өөрийн хүссэн зүйлийг авах нь буруу гэж 3 настай хүүхдүүдийн 69.8 хувь, 4 настай хүүхдүүд 89.6 хувь, 5 настай хүүхдүүдийн 88.5 хувь нь хариулсан байгаагаас үзэхэд өөрийн санал сэтгэл хөдлөлийг хүүхдүүд хаана яаж гаргах талаар тодорхой мэдлэгтэй болсон байдаг байна.

2.4.2. Бага боловсролын 6-10 насны хүүхдийн нийгэмшлийн онцлог

Өөртөө хандах хандлага


Бага боловсролын 6-10 настай хүүхдийн өөрийн ухамсрын хөгжлийн онцлогийг бодомж бүхий асуулгын аргаар буюу өөрийн ухамсрын онцлогийг өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөрийн үнэлэмж, өөртөө хандах хандлагын чадвараар судаллаа.

Хүснэгт 191. Өөртөө хандах хандлагын чадваруудын ялгаа, судалгааны үе шатаар (6-10 нас)

	t-test for Equality of Means						
	t	df	Sig. (2-tailed)	Mean Difference	Std. Error Difference	95% Confidence Interval of the Difference	
						Lower	Upper
Өөртөө итгэх итгэл	-8.913	817	0.000	-0.627	0.070	-0.765	-0.489
Өөрийн үнэлэмж	-7.007	818	0.000	-0.505	0.072	-0.646	-0.363

Судалгааны 1 ба 2 дугаар шатанд 6-10 настай хүүхдүүдийн өөртөө хандах хандлагын чадваруудын дундаж түвшинг чадвар тус бүрээр авч үзэхэд өөртөө итгэх итгэл болон өөрийн үнэлэмж статистик ач холбогдолтой ялгаа байна.

Зураг 116. Өөртөө хандах хандлагын чадваруудын дундаж үзүүлэлт, судалгааны үе шатаар (6-10 нас)



Зургаас харахад Судалгаа 2-т хамрагдсан хүүхдүүдийн өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө итгэх итгэл болон өөрийн үнэлэмж илүү сайн байна.

Хүснэгт 192. Даалгаврын тохирц болон найдвартай чанар, өөртөө хандах хандлага (6-10 нас)

Rotated Component Matrix ^a		
	Component 1	Cronbach's Alpha
Даалгавар 1.1 [Би өөрийгөө байгаагаар нь хүлээн зөвшөөрдөг.]	.617	.707
Даалгавар 1.1 [Миний сайн тал сул талаас маань илүү олон.]	.456	
Даалгавар 1.2 [Бусад хүмүүс намайг өндрөөр үнэлдэг гэж боддог.]	.569	
Даалгавар 1.2 [Би аливаа зүйлийг бусдаас дутахааргүй сайн хийж чаддаг.]	.613	
Даалгавар 1.3 [Надад олон сайн шинж чанар байдаг, түүгээрээ бахархдаг.]	.637	
Даалгавар 1.3 [Хүмүүст ямар санагдах нь хамаагүй, би өөрийгөө үнэ цэнтэй гэж боддог.]	.610	
Даалгавар 1.3 [Би бусдаас дутахааргүй хүндлэл хүлээдэг, сайн хүн.]	.651	

Даалгавруудын тохирц чанарыг хүчин зүйлийн шинжилгээгээр тодорхойлоход даалгаврууд харилцан хамааралтай багцыг үүсгэж чадаж байгаа тул тохирцтой гэж үзлээ.

Сургуулийн бага боловсролын насны хүүхдүүдийн өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөрийгөө үнэлэх, өөртөө итгэх итгэл нь өөртөө хандах хандлага нь эерэг түвшинд байна (M=4.0).

Хүүхдүүд өөрийн гадаад дүр төрх, зан төлөв, мэдлэг чадвартайгаа зөрчилддөггүй дотоод зөрчилгүй, хийж гүйцэтгэж байгаа үйлдэл үйл ажиллагаандаа эерэг ханддаг, өөдрөг, сэтгэл зүйн тэнцвэрт байдалтай, бэрхшээлийг даван туулах итгэлтэй зан төлөвтэй байна.

Хүснэгт 193. Өөртөө хандах хандлагын чадваруудын статистик үзүүлэлт (6-10 нас)


	Minimum	Maximum	Mean	Std. Deviation
Өөрийгөө хүлээн зөвшөөрөх	1	5	4.02	1.124
Өөртөө итгэх итгэл	1	5	4.28	1.003
Өөрийн үнэлэмж	1	5	4.27	1.053

Хүснэгт 194. Өөртөө хандах хандлагын корреляц хамаарал (6-10 нас)

	Өөрийгөө хүлээн зөвшөөрөх	Өөрийн үнэлэмж	Өөртөө итгэх итгэл
Өөрийгөө хүлээн зөвшөөрөх	1	.415**	.369**
Өөрийн үнэлэмж		1	.537**
Өөртөө итгэх итгэл			1

